

**Байгаль орчинд нөлөөлөх
байдлын үнэлгээнд олон нийтийн
оролцоог хангах нь:**

Оролцогч талуудын судалгаа

Энэхүү судалгааны тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП2) хүрээнд боловсруулсан бөгөөд АМЕП 2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

* * *

* * *

* * *

* * *

* * *

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа

Энэ судалгааны тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох төслийн хүрээнд боловсруулав.

Бодлогын судалгааны тайланг боловсруулсан: АМЕП-2 төслийн олон нийтийн оролцооны зөвлөх Доктор Д.Бямбажав

2021 оны 6 сарын 15

Хураангуй

Энэхүү судалгааг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП2) хүрээнд боловсруулсан бөгөөд АМЕП 2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү судалгааг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” (БОНБУ) хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангах чиглэлээр оролцогч талуудын санаа бодлыг нэгтгэх зорилгоор гүйцэтгэсэн. Судалгаанд БОНБУ хийх эрх бүхий компаниудын төлөөлөл, үнэлгээний ажлын захиалагч тал болох уул уурхай, бусад салбарын компаниудын төлөөлөл, салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, орон нутгийн удирдлага (сум, дүүрэг, баг хорооны), иргэдийн төлөөлөл нийт 115 оролцогчийг хамруулан зохион байгуулсан.

Юуны өмнө БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн итгэх итгэл сул байгааг онцолж, үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь нөлөөллийн үнэлгээний дагуу байгаль хамгаалах үр дүнтэй ажлууд хийгддэггүй, үнэлгээ нь иргэдэд ойлгомжгүй, ил тод бус, санал өгсөн ч түүнийг тайланд тусгана гэдэг итгэл, хүлээлт бага байдаг явдал юм гэж үзсэнийг дурьдах нь зүйтэй.

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа нь хуулийн дагуу яамнаас шаарддаг үнэлгээний тайланг хэлэлцсэн Иргэдийн нийтийн хурлын (ИНХ) тогтоол, хурлын тэмдэглэлийг гаргуулахад төвлөрч, харин хууль, журамд заасан иргэдэд мэдээлэл өгөх, урьдчилсан санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлангийн ил тод байдлыг хангах шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Түүнчлэн, үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгчид үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах гол арга зам болж буй ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх ажлын зорилгын талаар ойлголтын зөрүү байгаа нь хурлын зохион байгуулалт, талуудын оролцооны идэвх, сонирхолд сөргөөр нөлөөлж байна. Судалгаанд оролцогчид орон нутгийн удирдлагын үүрэг хариуцлагын талаар зохицуулаагүй орхигдуулснаас болж ИНХ-ын хэлэлцүүлгийн тов, ирц, үр дүнтэй холбоотой асуудлууд тулгарч байна гэж үзсэн байна.

БОНБУ-ний тухай хууль, холбогдох журмуудад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг тусгахдаа хэн, хэзээ, хэрхэн гэдэг үүрэг, хариуцлагын уялдааг хангаагүйн улмаас ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатны мэдээлэл өгөх, санал авах ажил орхигдох, утга учиртай, мэдээлэлд суурилсан оролцоог хязгаарлах сөрөг үр дагавар гарч байна. Үүний зэрэгцээ үнэлгээ хийх төслийн ангилал хэт өргөн хүрээтэй, зарим жижиг, дунд хэмжээний төслүүдийн төсөв хэт бага, мөн үнэлгээ эрхлэгч компаниудын оролцоог хангах чадавх сул байдгаас оролцоог хангах шаардлага огт хэрэгжихгүй байна.

Орон нутгийн удирдлагын хувьд үнэлгээний ажлын талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй, ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатанд иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх үүргээ үнэлгээ эрхлэгчид хэрэгжүүлдэггүй гэдэг байр суурийг илэрхийлсэн байна. Тийм учраас мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг сайжруулах, иргэдэд БОНБУ-ний талаар мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдээс авсан саналын үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжоор хангах, үнэлгээ эрхлэгчдийн орон нутагтай илүү ойр, төслийн үнэлгээний эхнээс хамтарч ажиллах саналуудыг дэвшүүлсэн байна.

Судалгаанд оролцогчид үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчилж үзэх, түүний дагуу оролцооны шаардлагуудыг ялгаатай тусгах, үнэлгээний эхлэлээс батлагдах хүртэлх олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхой болгох, БОНБУ-ний талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулах, үнэлгээний мэдээллийн хүртээмжтэй байдлыг сайжруулах хэрэгтэй гэдэг саналууд дэвшүүлсэн байна.

Гарчиг

Судалгааны зорилго, арга зүй.....	7
Судалгааны зорилго, зорилт	7
Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	7
Үнэлгээ эрхлэгчдийн судалгаа	8
Судалгаанд оролцогчид	8
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт	9
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах практик	9
Мэдээллийн ил тод байдал, хүртээмж.....	10
Иргэдийн саналыг авах, боловсруулах чадавх.....	12
ИНХ-ын хэлэлцүүлэгтэй холбоотой асуудлууд.....	15
Үнэлгээний ажлын төсөв ба оролцоо	18
Бусад оролцогч талуудын тухай (1-5 оноогоор үнэлэх).....	19
Тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам	21
Дүгнэлт	27
Төсөл хэрэгжүүлэгч компаниудын судалгаа	29
Судалгаанд оролцогчид: Уул уурхайн компаниуд	29
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт	30
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах туршлага ба тулгарч буй асуудал	31
Шийдвэрлэх арга зам, түүний хувилбаруудын талаарх байр суурь.....	34
Дүгнэлт	37
Бусад салбарын төсөл хэрэгжүүлэгчид	39
Судалгаанд оролцогчид	39
БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангахад тулгарч буй асуудлууд	39
БОНБУ-нд оролцоог хангах санал, шийдлийн хувилбарууд.....	41
Дүгнэлт.....	41
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт	43
Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах практик	44
Асуудлын шийдэл, хувилбарууд	47
Дүгнэлт	52
Орон нутгийн иргэд.....	53
Судалгаанд оролцогчид	53

БОНБУ-ний талаарх иргэдийн итгэл	53
Цаашид анхаарах асуудлууд	54
Дүгнэлт	55
Төрийн бус байгууллагууд, салбарын холбоод	56
Оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд	56
Оролцоог сайжруулах арга замууд.....	59
Дүгнэлт	60
Оролцогч талуудын саналын тойм.....	61

Судалгааны зорилго, арга зүй

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангах чиглэлээр оролцогч талуудын санаа бодлыг нэгтгэх зорилгоор гүйцэтгэсэн.

Энэхүү судалгааг чанарын судалгааны арга болох гүнзгийрүүлсэн ярилцлага судалгааны аргаар гүйцэтгэсэн. Судалгааны асуултуудыг зөвлөх Д.Бямбажав болон төслийн баг өмнөх судалгаа, баримт бичгийн дүн шинжилгээ, олон улсын туршлагын талаарх мэдээлэлд тулгуурлан боловсруулсан. БОНБУ-нд оролцоог хангаж буй байдал, БОНБУ-ний оролцоог хангах хэсгийг хэрхэн зохион байгуулдаг талаарх туршлага, ойлголт, мэдээлэл, оролцоог хангахтай холбоотой гол бэрхшээлүүд, оролцогч талуудын эрх үүрэг, харилцаанд тулгарч буй бэрхшээл, давуу талууд, үнэлгээг хийхэд ашигладаг тодорхой аргууд, аргачлал, сайн туршлагаууд, журамд оруулах өөрчлөлтийн хувилбарын саналууд болон цаашид сайжруулах тодорхой санаа, шийдэл гэсэн сэдвүүдийн хүрээнд асуултуудыг боловсруулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Хараат бус судалгааны хүрээлэн /IRIM/ хэрэгжүүлсэн. Судалгаанд БОНБУ хийх эрх бүхий компаниудын төлөөлөл, үнэлгээний ажлын захиалагч тал болох уул уурхай, бусад салбарын компаниудын төлөөлөл, салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, орон нутгийн удирдлага /сум, дүүрэг, баг хорооны/, иргэдийн төлөөлөл нийт 115 оролцогчийг хамруулан зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг COVID-19 цар тахлын онцгой нөхцөлд бүрэн зайнаас зохион байгуулсан. Ингэхдээ ярилцлага судалгаанд оролцогчидтой утсаар холбогдож мэдээлэл цуглуулсан. Ярилцлага судалгаа дунджаар 40-60 минут үргэлжилсэн ба судалгааны мэдээллийг аудио рекордод буулгаж, дараа нь нэг бүрчлэн сонсож бичвэр хэлбэрт шилжүүлсэн. Нэг оролцогчоос судалгааны мэдээлэл цуглуулахын тулд дунджаар 2-3 удаагийн хандалтаар мэдээлэл цуглуулсан.

Судалгааны өгөгдөлд агуулгын хяналт хийсэн. Агуулгын хяналт хийхдээ аудио рекордын бичлэг ярилцлагын бичвэрт үнэн зөв, логик уялдаатай бичигдсэн эсэхийг хянан баталгаажуулсан. Судалгааны нийт түүврийн 54% (62)-г үндсэн түүврийн жагсаалтаас, 46% (53)-г нөөц жагсаалтаас авсан байна. Үндсэн жагсаалтаас судалгаанд хамрагдаагүй компаниудын нийтлэг шалтгаан нь буруу утасны дугаар байх, утсаа авахгүй байх, судалгаа өгөхөөс татгалзаж байсантай холбоотой.

Судалгааны анхдагч мэдээллийг Хараат бус судалгааны хүрээлэнгийн баг MS EXCEL программ дээр нэгтгэж асуулт бүрийн утгыг нарийвчилсан байдлаар кодлож давхардсан утгуудыг тооцоолсон. Төслийн зөвлөх Д.Бямбажав судалгааны анхдагч мэдээллийг дахин шалгаж, чанарын мэдээллийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тайланг боловсруулсан болно.

Үнэлгээ эрхлэгчдийн судалгаа

Судалгаанд оролцогчид

Судалгаанд сүүлийн 3-5 жилд Байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ /БОННУ/ хийсэн компаниуд болон бие даасан үнэлгээний мэргэжилтнүүд болох 30 оролцогчтой гүнзгийрүүлсэн ярилцлага судалгааг хийсэн. Үнэлгээний компаниуд нь БОАЖЯ-ны Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу байгаль орчинд нарийвчилсан үнэлгээ /БОННУ/ хийдэг. Судалгаанд хамрагдсан үнэлгээний компаниуд болон мэргэжилтнүүд нь энэ салбарт хамгийн багадаа 3 жил, хамгийн ихдээ 25 жил, дунджаар 11 жил ажилласан байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд 15 эмэгтэй, 15 эрэгтэй оролцогчид хамрагдсан ба насны хувьд хамгийн залуу нь 23 настай, хамгийн ахмад нь 66 настай бол, дундаж нас 41 байна. Судалгаанд тухайн байгууллагын удирдах албан тушаалтан болон ахлах мэргэжилтнүүд голлон хамрагдсан. Үнэлгээний компаниуд бүгд Улаанбаатар хотод төвлөн үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдийн мэдээлэл

№	Компанийн нэр	Үйл ажиллагаа явуулсан жил
1	Грийн ассесмент	8
2	Говьхангайн төгөл ХХК	9
3	Экологийн бүтээмж ХХК	11
4	Дөрвөн талст экологи ХХК	10
5	Глобал энвайрон ХХК	13
6	Экотон ХХК	24
7	Грийн трендс ХХК	9
8	Монслов ХХК	15
9	Лэндс ХХК	10
10	Эхопланет ХХК	15
11	ЖЭМР ХХК	25
12	Ашид ананда ХХК	8
13	Эко экспресс ХХК	6
14	Газар чандмань ХХК	8
15	Саблайм ХХК	7
16	Эконатур ХХК	16
17	Тэкол ХХК	21
18	Цагаан уулын оргил ХХК	11
19	Эм И Си Эс Зэт Би ХХК	6
20	Өндөрхаан трейд ХХК	11
21	Мон газар экологи" ХХК	9
22	Шүрэн завъяа ХХК	7
23	Эко Жэй Ти ХХК	5
24	Экотайкүүн ХХК	6
25	Сайхан ариун дэлхий ХХК	15

26	Үнэлгээний мэргэжилтэн	15
27	Үнэлгээний мэргэжилтэн	10
28	Үнэлгээний мэргэжилтэн	14
29	Үнэлгээний мэргэжилтэн	10
30	Үнэлгээний мэргэжилтэн	3

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт

1. Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь нөлөөллийг зөв тогтоох, мэдээлэл, хяналтыг сайжруулах ач холбогдолтой

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдийн дийлэнх нь олон нийтийн, ялангуяа төслийн нөлөөлийн бүсийн иргэдийн оролцоо нь төслийн сөрөг нөлөөллийг оновчтой тодорхойлох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхөд чухал ач холбогдолтой гэж үзжээ. Түүнчлэн, оролцоо нь иргэд төслийн эерэг, сөрөг нөлөөллийн талаарх мэдээлэл авах, түүнд түшиглэн хяналт тавих боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой учраас оролцоог үр дүнтэй, утга учиртай байдлаар хангахад хуулийн зохицуулалт чиглэх ёстой гэж үзсэн байна.

2. Иргэд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар тодорхой санал гаргах нь үр дүнтэй

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдээс ямар асуудлаар иргэд саналаа хэлбэл үнэлгээний ажилд үр дүнтэй вэ гэж асуусан. Төслийн үлмаас байгаль орчин болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд үзүүлж болох эсвэл үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар тодорхой санал хэлбэл чухал байдаг гэж үнэлгээ эрхлэгчид үзсэн байна. Үүний тулд төслийн БОНБУ-ний мэдээллийг ойлгох, өөрсдийн орон нутгийнхаа талаарх мэдлэг, туршлагаасаа хуваалцах хэрэгтэй байдаг гэж үзсэн байна.

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах практик

3. Багийн ИНХ-аар тайлан хэлэлцүүлэхийг оролцооны үндсэн арга зам гэж үзэж байна

Бид юуны өмнө судалгаанд оролцогчдоос БОНБУ хийхэд олон нийтийн оролцоог хэрхэн зохион байгуулдаг тухай нээлтэй асуулт асуусан. Ингэхдээ баг, хорооны тухайд тус бүрт нь тайлбарлаж өгөхийг хүссэн.

Төлөв байдлын үнэлгээний үед төслийн үйл ажиллагаа ямар цар хүрээг хамарч байгааг тодорхойлж түүний нөлөөллийн бүсийн иргэдээс мэдээлэл цуглуулдаг. Үнэлгээ хийж эхлэхийн өмнө тухайн орон нутгийн удирдлагаас тухайн багийн нутаг дэвсгэрт үнэлгээ хийлгэхийг зөвшөөрч байгаа талаар албан бичиг авдаг. Сүүлд нь багийн ИНХ-аар иргэдээс санал авч, хэлэлцүүлдэг.
Үнэлгээ эрхлэгч

Багийн хувьд нийт 30 оролцогчоос 29 нь багийн Иргэдийн Нийтийн Хурал /ИНХ/-аар үнэлгээг танилцуулж санал авах үйл ажиллагааг, 11 нь төлөв байдлын үнэлгээг хийхдээ иргэдтэй уулзаж, судалгаа авах үйл ажиллагааг, 6 нь нарийвчилсан үнэлгээг хийх явцдаа айл өрхөд зочилж санал авах үйл ажиллагааг дурьдсан байна. Үнэлгээ эрхлэгчдийн дийлэнх нь багийн ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлж санал авах үйл ажиллагааг олон нийтийн оролцоог хангах үндсэн арга зам гэж үзэж байна.

4. Төлөв байдлын үнэлгээний нийгмийн судалгааг олон нийтийн оролцоо гэж үзэж байна Үнэлгээ эрхлэгч нь төслийн төлөв байдлын үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг үргэлжлүүлэн буюу хамтад нь хийхээр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээлж хийх нь нийтлэг практик байна. Иймээс төслийн төлөв байдлын үнэлгээнд оруулдаг төслийн талбай, нөлөөллийн бүсийн өрхүүдийн судалгааг олон нийтийн саналыг авч буй нэг арга гэж үзэх нь олон байна. БОНБУ хийж эхлэх үе буюу таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, иргэдийн санал авах ажил хийдэг үү гэдэг асуултад оролцогчид 100 хувь тийм гэж хариулсан боловч үүнийг төлөв байдлын үнэлгээний дээрх судалгаагаар тооцож байна.

Төлөв байдлын судалгаа хийхдээ ойрын айлууд байгааг олж мэдээд, багийн засаг дарга нартай холбогдож айлуудын мэдээлэл аваад, хээрийн судалгаа хийхдээ 5 км орчимд буй айлуудаар мэдээлэл өгч судалгаа авдаг.

Үнэлгээ эрхлэгч

5. Нарийвчилсан үнэлгээг хийх явцад санал авахгүй байна Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу нарийвчилсан үнэлгээг хийх явцад олон нийтэд танилцуулга хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах, амаар болон бичгээр санал авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх тохиолдол маш цөөн байна. Дэлхийн банкны санхүүжилттэй төслийн үнэлгээ хийх тохиолдолд эсвэл тухайн нэг төслийн онцлогоос хамаарч цөөн тохиолдолд ИНХ болохоос өмнө иргэдээс санал авах ажлыг зохион байгуулдаг байна.

6. Хорооны ИНХ-ын тэргүүлэгчид л санал өгч байна УБ хотын хороодын хувьд үнэлгээ хийсэн түршлагатай судалгаанд оролцогч 27 хүнээс 12 нь хорооны ИНХ-аар нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцүүлдэг гэж хариулсан бол 15 нь зөвхөн ИНХ-ын тэргүүлэгчдийн хурал эсвэл Засаг даргын зохион байгуулсан хуралд танилцуулж санал авдаг гэж хариулсан байна. Түүнчлэн зарим оролцогчид хурлаар хэлэлцүүлж санал авсан гэдэг хуурамч бичиг гаргуулах явдал их байдаг тухай дурьдсан байна. Зөвхөн 6 оролцогч л төслийн талбайн ойр орчмын айлууд эсвэл гудамжинд алхаж яваа хүмүүсээс санамсаргүй түүврээр судалгаа авдаг гэж хариулсан байна.

Хорооны ихэнх хүмүүсийг цуглуулах боломж бага учраас ихэвчлэн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцдэг

Үнэлгээ эрхлэгч

Мэдээллийн ил тод байдал, хүртээмж

7. Үнэлгээний талаарх мэдээлэл иргэдэд хүрдэггүй Судалгаанд оролцогчдын 18 нь иргэд төслийн болон нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээллийг авах боломж хангалтгүй гэж хариулсан байна.

Яг нийтээр нэг мэдээлэл авсан байдал бараг байдаггүй байх. Иргэдийн нийтийн хурал нь зайтай улиралд 1 удаа болдог учир ам дамжсан яриагаар мэдээлэл авсан байдаг байх.

Үнэлгээ эрхлэгч

Иргэдэд мэдээлэл дутмаг байгаагийн шалтгааныг хэд хэдэн янзаар тайлбарлаж байна. Нэгдүгээр, үнэлгээ эрхлэгч талаас орон нутгийн удирдлагад хүргүүлсэн мэдээллийг цааш түгээх ажил хангалтгүй гэж үзэх хэсэг байна. Хоёрдугаарт, үнэлгээний төсөвтэй холбоотой иргэдэд мэдээлэл түгээх ажил хийх нь бэрхшээлтэй бөгөөд зөвхөн хээрийн судалгааны үеэр л судалгаа авч буй хүрээнд зарим мэдээлэл өгдөг байна. Гуравдугаарт, төсөл болон үнэлгээтэй холбоотой мэдээллийг иргэдэд өгөх сонирхол байхгүй бага байна. Энэ нь иргэдийн зүгээс сөрөг хандлага үүсэхээс болгоомжлох, үнэлгээний тайланг хувийн болон байгууллагын нууц гэж үзэх, иргэний хөдөлгөөн, ТББ-уудаас болгоомжлох хандлагатай холбоотой байна.

Иргэдэд танилцуулах хуудас, мэдээллийн хураангуйг хэвлэж төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч өөрсдөө тараах, цахим хэлбэрээр мэдээлэл түгээх тохиолдол маш цөөн байна. Сүүлийн жилүүдэд орон нутгийн олон нийтийн цахим сүлжээ, ялангуяа Фэйсбүүк групп болон хуудаснаа орон нутагтай хамтран холбогдох мэдээлэл оруулах, санал авах хийж байгаа зарим үнэлгээ эрхлэгчид байна.

Мэдээллийг манай сайтаас болон Фэйсбүүк групп дээрээс авах боломжтой. Бид саналын хуудсаа урьдчилаад ИНХ-ын дарга руу явуулчихдаг. Мөн зарим орон нутгийн Фэйсбүүк групп дээр нь урьдчилж хэлэлцүүлдэг. Эндээс бас их санал гардаг.

Үнэлгээ эрхлэгч

Ихэнхдээ орон нутгийн иргэд үнэлгээний ажлын талаар мэдэхгүй явсаар, нарийвчилсан үнэлгээ хийгдэж дуусаад ИНХ-аар хэлэлцүүлэх шатан дээр л анх сонсдог байдал нийтлэг байна.

8. Үнэлгээний талаар олон нийтэд огт зарлан мэдээлэхгүй байна

Дэлхийн банкны санхүүжилттэй төслийн олон улсын аргачлалаар хийсэн үнэлгээний тухайд л нийтэд зарлан мэдээлж байсан байна. Ингэхдээ үнэлгээ эрхлэгч үнэлгээний талаарх тойм мэдээллийг бэлтгэн орон нутгийн зарлалын самбарт байршуулах, эмзэг бүлэг, захиргааныхан, сонирхолын бүлэг гэх мэт бүлгүүдэд ялгаатай аргачлалаар мэдээлэл хүргэж, санал авсан байна. Гэвч дотоодын төсөл дээр ингэж ажиллах цаг хугацаа болоод хөрөнгө санхүү байдаггүй гэж тайлбарлсан байна. Манай судалгаанд оролцогч 30 үнэлгээ эрхлэгчээс 22 нь үнэлгээний талаар нийтэд зарлан мэдээлдэггүй гэж хариулсан бол бусад 8 нь заримдаа цахим, сошиал сүлжээгээр зар мэдээлэл оруулдаг, нөлөөллийн бүсийн иргэдэд зар мэдээлэл хүргэж байсан гэжээ. Зарим оролцогчид зар мэдээг орон нутагт хүргүүлдэг, цааш нь түгээдэг эсэх нь тодорхойгүй гэсэн байна.

9. Үнэлгээний тайлангийн хураангуй мэдээллийг бэлтгэж ИНХ-д танилцуулж байна

Оролцогчдын 25 нь үнэлгээний тайлангийн гол мэдээллийг агуулсан танилцуулга мэдээллийг бэлтгэж орон нутагт илгээх, хуралд танилцуулах ажлыг зохион байгуулдаг гэсэн. Эдгээр нь үнэлгээ эрхлэгчийн танилцуулах слайдууд хэлбэрээр болон орон нутгийн удирдлага, иргэдэд зориулсан мэдээллийн хуудас хэлбэртэй байна.

Төслийнхөө товч тодорхойлолтууд, болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга замууд болон зөвлөмж, санал дүгнэлтээ оруулсан хураангуй бэлддэг.

Үнэлгээ эрхлэгч

Бид материалаа эхэлж явуулахдаа тайлангийн товч танилцуулга бэлтгээд тухайн сум, хорооны хүмүүсийн тоог гаргаад хэвлээд цуг хүргүүлдэг. Хүмүүс хурлаас өмнө мэдээлэлтэй болчихсон байдаг.

Үнэлгээ эрхлэгч

Иргэдийн нийтийн хуралд орохдоо танилцуулга бэлдэж өгдөг л дөө. Ийм төсөл, ийм хүчин чадалтай, ийм хүн ажиллах гэж байна, байгаль орчинд ийм сөрөг нөлөөтэй, ийм ийм аргаар байгаль орчны сөрөг нөлөөллийг нь бууруулах гээд байна гэх мэт жижигхэн танилцуулга хийгээд тараана л даа. Гэхдээ яг хурлын өдөр л тараана шүү дээ.

Үнэлгээ эрхлэгч

Танилцуулга мэдээллийг хурал болохоос өмнө орон нутгийн удирдлага, иргэдэд хүргүүлж, уншиж танилцах боломжоор хангах үүргийг орон нутгийн удирдлагад найдаж орхих хандлага давамгайлж байна. Түүнчлэн, танилцуулга мэдээллийг зөвхөн ИНХ дээр л танилцуулах, тараах байдал дунд, жижиг төслүүдийн хувьд нийтлэг байна.

10. Тайлангийн бүрэн эхтэй танилцах боломж маш хязгаарлагдмал байна

Үнэлгээний тайлан батлагдахаас өмнө иргэд уншиж танилцах боломж маш байдаг гэдгийг үнэлгээ эрхлэгчид хүлээн зөвшөөрч байна. Нэгдүгээрт, хуулийн дагуу тайлан батлагдахаас өмнө орон нутагт тайланг хүргүүлэх, нээлттэй мэдээлэх хуулийн шаардлага байхгүй. Хоёрдугаарт, иргэдийн хувьд тайланг бүрэн эхээр нь унших сонирхол бага байдаг гэж үзсэн байна. Гуравдугаарт, төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгчид үнэлгээний тайлангаа олон нийтэд дэлгэх сонирхол бага байдаг байна.

Тайлан батлагдсаны дараа хуулийн дагуу орон нутагт хүргүүлсэн тайлангийн хувьтай танилцах, мөн Байгаль орчны мэдээллийн сангаас цахимаар танилцах боломжтой байдаг гэж зарим үнэлгээ эрхлэгчид үзсэн байна.

Иргэдийн саналыг авах, боловсруулах чадавх

11. Иргэдийн оролцоог хангах байгууллагын чадавх сул

Үнэлгээний компаниудад иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлыг дагнан ажилладаг мэргэжилтэн байдаггүй байна. Гол төлөв үнэлгээний багийн ахлагч, үнэлгээний компанийн захирал нь санал авах ажлыг давхар хариуцан ажиллаж байна.

Маш цөөн, томоохон төслийн хувьд нийгмийн судалгааны мэргэжилтэн гэрээгээр ажилладаг байна.

12. Үнэлгээ эрхлэгчид иргэдээс бичгээр санал авах хуудас ашиглаж байна

Иргэдээс бичгээр санал авахдаа маягт, асуулгын хуудас ашиглах компаниудын хувьд нийтлэг байна. Гэхдээ суурь судалгаа буюу төлөв байдлын үнэлгээ хийхэд нийгэм, эдийн засгийн мэдээллийг цуглуулах зорилгоор иргэдээс авдаг асуулга судалгааг үүнд хамааруулан ойлгож буй үнэлгээ эрхлэгчид олон байна.

ИНХ-аар тайлан хэлэлцүүлэхээс өмнө иргэдээс санал авах зорилготой асуулгын хуудас боловсруулж ашигладаг тохиолдол нилээд байна. Мөн ИНХ-аар тайлан хэлэлцүүлэх үеэр иргэдээс бичгээр санал авах зорилготой асуулгын хуудас ашигладаг байна.

Манайд өөрсдийн бэлтгэсэн загвар асуулга байдаг, харьцангуй сайжраад явж байгаа. Голлох зүйлүүд гэвэл тухайн төсөлтэй холбоотой байгаль орчныг бууруулах, сөрөг нөлөөллийг бууруулах ямар зөвлөмж, зөвлөмжтэй танилцаад та ямар зөвлөмжийг нь боломжтой гэж үзэж байна, төсөл хэрэгжүүлэгчтэй холбоотой нийгмийн хариуцлагын хүрээнд ямар ажил

хамтарч зохион байгуулбал таны амьдралд хэрэгтэй байна вэ зэрэг асуудлуудыг тусгаж өгдөг.

Үнэлгээ эрхлэгч

БОННУ-ний тайлангийн олон нийтийн оролцоог хангах хэсгийн загвар анкет гэж байдаг. Дийлэнх тохиолдолд үүнийг ашиглана. Уул уурхайн том төслүүд дээр экспертүүд авч ажиллуулдаг. Тэдгээр хүмүүс маань өөрсдөө асуултуудаа төсөлтэйгөө холбож бэлддэг.

Үнэлгээ эрхлэгч

13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах боломж бага байна
Нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах талаар хичээж ажилладаг гэсэн байр суурь давамгайлж байна. Харин тодорхой бодлого, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад эмзэг бүлгийн төлөөллийг оролцуулах талаар нэвтрүүлсэн зарчим, аргазүйн талаар дурьдсан тохиолдол байхгүй байна.

14. Иргэд байгаль орчныг хамгаалах тодорхой санал гаргах нь хязгаарлагдмал байна
Судалгаанд оролцогч үнэлгээ эрхлэгчдийн 45 хувь нь иргэд төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах талаар ач холбогдолтой санал гаргадаг гэж хариулсан байна. Харин 55 хувь нь иргэд орон нутгийн бүтээн байгуулалт, тохижилт, худаг усны хангамж, хандив тусламжийн талаар асуулт асуух, санал хэлэх тохиолдол давамгайлдаг гэж үзсэн байна. Байгаль орчны үнэлгээний ажилд холбогдолгүй асуулт, саналууд их гардаг шалтгааныг зарим үнэлгээ эрхлэгчид дараах шалтгаантай гэж үзсэн байна. Үүнд:

- Ашиг сонирхлын зөрчилтэй буюу төсөлд зөвшөөрөл өгөх гэж байна гэдэг хандлагаар асуулт, саналууд хэлдэг.
- Төслийн талаарх ойлголт дутмаг, мэдээлэл аваагүй байдаг учраас оновчтой асуулт, санал хэлэх боломжгүй байхын зэрэгцээ бусдын нөлөөлөлд амархан ороход хүргэдэг.
- Орон нутгийн байгаль орчны асуудлуудыг орон нутагт хэрэгжиж буй төслүүдээс л болж байна гэдэг ташаа ойлголт хүчтэй байдаг учраас санал нь өрөөсөл болдог.
- Иргэдийн өөрсдийн үзэл бодлоо нээлттэй илэрхийлэх чадвар сул учраас орон нутгийн удирдлага, цөөн хэдэн хүний аясыг харсан байдалтай байдаг нь үр дүнтэй санал гаргахад сөргөөр нөлөөлдөг.

Эдгээр нь иргэдийг төслийн болон үнэлгээний талаарх мэдээллээр хангах, БОННУ-ний зорилго, ач холбогдлыг таниулан сурталчлах маш их хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна. Түүнчлэн, иргэд жижиг бүлгээр болон хувиараа асуулт асуух, санал авах арга замуудыг нэмэгдүүлэх нь тэдний оролцог хангахад чухал болохыг харуулж байна.

Үнэлгээ эрхлэгчдийн хэлснээр иргэд байгаль орчинтой холбоотой дараах асуулт, саналуудыг санал авах, хэлэлцүүлэг хийх үеэр гаргадаг байна. Үүнд:

- Усны чанар, хүрэлцээ
- Агаарын чанар, тоосжилт
- Замын хөдөлгөөнтэй холбоотой сөрөг нөлөөлөл /хөрсний эвсрэл, тоосжилт, мал дайрагдах/
- Хог хаягдал
- Дүйцүүлэн хамгаалах талбай, чиглэл

- Аюулгүй орчин /машины хурд, газар шорооны ажил/
- Дуу чимээ
- Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- Малын бэлчээр
- Малын эрүүл мэнд
- Зэрлэг амьтан, ургамал
- Нөхөн сэргээлт
- Химийн бодисын хадгалалт, хэрэглээ

Зарим үнэлгээ эрхлэгчид орон нутгийн онцлогыг ойлгоход иргэдийн санал маш чухал болохыг онцолсон байна.

Нутгийн онцлогоо мэддэг, тухайн нутагт удаан амьдарсан хүмүүс, мөн уурхайн ажлыг ойлгодог, мэдээлэлтэй хүмүүс ач холбогдолтой санал хэлдэг. Тийм хүмүүстэй тусгайлан ярилцлага хийж, саналыг сонсохыг зорьдог. Бидний хувьд богино хугацаанд судалгаа хийж байгаа учраас тэр нутгийн онцлогыг төдийлөн мэдэхгүй. Харин иргэд тайланд ач холбогдолтой санал хэлдэг.

Үнэлгээ эрхлэгч

Зарим үед ганц хоёр удаа нутаг орноо сайн мэддэг нутгийн иргэд, хөгшдөөс дүйцүүлэн хамгаалах талаар тухайн нутаг усны яг энэ хэсгийг ингэж хамгаалах хэрэгтэй, тэнд нь худаг ус гаргаж өгөх хэрэгтэй байна гэсэн санал гардаг.

Үнэлгээ эрхлэгч

Зарим хүмүүс маш аятайхан санал хэлдэг. Нэг жишээ дурьдахад ойн мэргэжилтэй нэг иргэн шувуу судалдаг хүмүүсийн эрх ашгийг хангах талаар санал гаргаж байсан. Энэ саналыг тайланд оруулсан.

Үнэлгээ эрхлэгч

15. Нийгэм, амьжиргааны шинжтэй саналуудыг төсөл хэрэгжүүлэгчид уламжилж байна Судалгаанд оролцсон 30 үнэлгээ эрхлэгчийн 24 нь иргэдийн хэлсэн нийгэм, амьжиргааны шинжтэй саналуудыг тодорхой хэмжээнд үнэлгээний тайланд тусгадаг гэж хариулсан байна. Төсөл хэрэгжүүлэгч компанид саналуудыг танилцуулах, үнэлгээний тайланд саналуудыг хавсаргах замаар иргэдийн саналуудыг уламжилдаг байна. Дэлхийн банк болон бусад олон улсын санхүүжилттэй томоохон төслүүдийн хувьд нийгмийн асуудлуудын талаар нарийвчлан дүгнэлт хийж зөвлөмж гаргадаг бол дотоодын төслүүдийн хувьд ийм жишиг байдаггүй байна.

Иргэдийн саналыг менежментийн төлөвлөгөөнд тусгах, үнэлгээний тайлангийн зохих хэсэгт оруулах талаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвлөлдөж шийддэг байна. Үнэлгээ эрхлэгчийн тайланд тусгаж байсан зарим саналуудыг доор сийрүүлэв.

Нөлөөллийн бүсэд орсон айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, ар гэрийн хүмүүсийг нь ажилд авах, сургалтын төлбөр гэх мэт зүйлсийг нь төлж өгөх талаар тусгадаг..

Үнэлгээ эрхлэгч

Жишээлбэл ойр орчмын малчдад өвлийн хэцүү цагт нь тусламж олгоно гэх мэтийн иймэрхүү амьжиргаанд нь туслах асуудлууд ганц нэг оруулж өгдөг.

Үнэлгээ эрхлэгч

Төсөл хэрэгжүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд тайланд тусгана. ИНХ дээр хийж өгнө гэж амласан, тохирсон бүх асуудлыг тайланд тусгадаг.

ИНХ-ын хэлэлцүүлэгтэй холбоотой асуудлууд

16. ИНХ-аар хэлэлцүүлэх зорилгын талаарх ойлголтын зөрүү

Баг, хорооны ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлэх нь орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, тэдний саналыг авах зорилготой юу эсвэл тэднээс дэмжиж байна гэдэг шийдвэр гаргуулах зорилготой юу гэдэг асуудлаар оролцогч талуудын хооронд ойлголтын зөрүү байна гэдгийг үнэлгээ эрхлэгчид үзэж байна. Орон нутгийн удирдлага, иргэдийн хувьд ИНХ-ын хэлэлцүүлгийг иргэдийн дэмжсэн эсэх саналыг авах зөвшөөрөл өгч буй үйл явц гэж явцуу утгаар ойлгож ханддаг гэж үзсэн байна.

Яамны зүгээс иргэдийн саналыг үнэлгээний тайланг боловсруулахад хэрхэн авсан, тэдгээрийг хэрхэн тусгасанд анхаарахаас илүүтэй дэмжсэн эсэх тухай тогтоолд ач холбогдол өгч байгаа нь үүний тод жишээ гэж зарим оролцогчид үзсэн байна. Яамны шинжээч, мэргэжлийн зөвлөлөөр шийдвэр гаргахаас өмнөх үнэлгээний талаар шийдвэр гаргах эхний шат гэх ойлголт түгээмэл болсон гэж үзсэн байна.

17. ИНХ-ын хуралдааны тов, давтамжын тодорхой бус байдал

Баг, хороодын хурлын тогтсон хуваарь буюу тов байдаггүй бөгөөд баг, хорооны удирдлага тухай бүрт шийдвэр гаргаж ээлжит болон ээлжит бус хуралдаан зохион байгуулдаг байна. Хөдөө орон нутагт ихэнхдээ Цагаан сарын өмнө нэг удаа, хавар мал төллөсний дараа буюу 5, 6-р сарын үеэр нэг удаа, намар хадлан, өвлийн бэлтгэлийн дараагаар буюу 10-р сарын орчимд нэг удаа багийн хурал зохион байгуулагддаг байна. Зарим орон нутагт улирал бүр багийн хурал хуралддаг бол зарим газар хурлын тов, давтамж маш их хэлбэлздэг байна. Байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлс, орон нутгийн яаралтай ажлууд, сонгуулийн мөчлөг, хурлын ирц дутуу зэрэг шалтгаанаар товлогдсон хурал цуцлагдах тохиолдол их байдаг байна.

Үнэлгээ эрхлэгчдээс ИНХ-ын хуралдааны товыг тодорхой болгох, үнэлгээний үйл ажиллагаанд чирэгдэл багатай болгох талаар дараах саналуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Орон нутагт хуралдах гэж байгаа багийн иргэдийн нийтийн хурлынхаа тоо давтамжийг нэмэх
- 1-р улирлын хурал тэдэн сарын тэдний өдөр хуралдаж байна гэсэн байдлаар хуралдааны товыг тодорхой болгох
- ИНХ-ын дарга ээлжит хуралдааныг зохион байгуулаагүй хариуцлагыг хууль, журмаар тодорхой болгох
- БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журмын 2.7-д заасан “Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна” гэдэг зохицуулалтыг бусад хуультай үялдуулах

Ийнхүү жилд дунджаар 2-4 удаа болдог ИНХ-ын хуралдааны товыг хүлээж, хэрэв хуралдааны тов эрт буюу ойрхон зарлагдсан бол 1-3 сард багтаан хэлэлцүүлэгт орох, хэрэв тухайн улиралд амжаагүй эсвэл хуралдаан товлогдохгүй удах тохиолдолд 3-6 сар хүлээх болдог байна. Ийм тодорхойгүй байдал нь нэжгээд сөрөг үр дагаврыг учруулдаг байна. Үүнд:

- Тухайн төслийн төлөвлөлт, явцыг удаашруулах, зогсоох, улмаар эдийн засгийн үнэ цэнэ буурдаг.
- 3-6 сараар хүчинтэй байхаар гардаг Ерөнхий үнэлгээний хугацаа дуусдаг тул дахин дүгнэлт гаргуулах болж чирэгдэл үүсдэг.
- Хурлын зохион байгуулахын тулд орон нутгийн удирдлагаас гүйх, тэдэнд нөлөөлөх, тохиролцох, авилгал өгөх зэрэг үйлдэл хийхэд хүргэдэг.
- Хуралдаан болсон мэт хуурамч бичиг баримт бүрдүүлэх зөрчил гардаг.

УБ хотын хороодын хувьд ИНХ-ын давтамж харьцангуй олон боловч дээрх тодорхойгүй байдал болон сөрөг үр дагаврууд мөн адил гардаг байна. Энэ талаар судалгаанд оролцогчдын хэлсэн тайлбарыг доор танилцуулав.

Хурал мөн адил улиралд 1 удаа болдог. Дарга нар нь солигдсон, хурал хойшилсон зэрэг асуудлаар хугацаа нь хойшилдог. Байнга ойр ойрхон очоод уулзаад байх боломж их учир хөдөө орон нутгаа бодвол харьцангуй гайгүй байдаг.

Үнэлгээ эрхлэгч

Хотод ИНХ-аар тайланг бараг танилцуулдаггүй. Үндсэндээ бол хурлаар хэлэлцүүлсэн гэдэг шал худлаа бичиг авдаг байхгүй юу даа.

Үнэлгээ эрхлэгч

Зарим хорооны хувьд хурлын товоо гаргаад холбогдоно гэсэн хариу өгнө. Зарим нь бүр огт ямар ч хариу өгөхгүй байх жишээтэй.

Үнэлгээ эрхлэгч

18. ИНХ-ын хэлэлцүүлгийн зохион байгуулалт

Зөвхөн үнэлгээний тайланг хэлэлцэх ээлжит бус хурал зохион байгуулах тохиолдол маш цөөн байна. Ихэнхдээ ИНХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах байдлаар үнэлгээний тайланг хэлэлцүүлж байна. Орон нутгийн “дотоод” асуудлаа хэлэлцэж дуусаад үнэлгээний тайлангийн танилцуулгыг сонсож хэлэлцдэг жишиг нийтлэг байна.

Үнэлгээ эрхлэгч эсвэл төсөл хэрэгжүүлэгч дунджаар 10-20 минут орчим танилцуулга хийсний дараа асуулт, хариулт, санал авах ажил 1-2 цаг орчим үргэлжилдэг байна.

Бусад асуудлыг хамт хэлэлцүүлнэ. Зөвхөн үнэлгээни тайланг хэлэлцүүлэхийн тулд багийн иргэдийг цуглуулна гэвэл иргэд нь мал хуй гээд ирдэггүй. Өөрсдөд эь ямар ч хамаагүй юм шиг үл тоосон байдалтай байдаг. Зөвхөн нөлөөллийн бүсийн иргэдийг хуралд оролцуулах юм бол ИНХ-ын ирцийг нь хангахгүй учраас бид нар дараагийн хурлыг хүлээдэг.

Үнэлгээ эрхлэгч

Орон нутгаасаа хамаараад янз бүр. Зарим газар бол товлосон нийтийн хурал дээрээ манай асуудлыг тавьчихдаг. Өөрсдийнхөө асуудлыг хуралдаад л байна. Бид нар өглөө 9-д бэлэн оччихоод орой 6, 7 цагийн үед тайлангаа танилцуулах үе байна. Эсвэл яг зөвхөн манай тайланг хэлэлцүүлээд тараадаг үе байна.

Үнэлгээ эрхлэгч

Хотын хувьд үнэлгээ хийсэн компаниудын жагсаалт гаргаж байгаад дарааллын дагуу хэлэлцэж байсан.

Үнэлгээ эрхлэгч

Багийн хурлаар хэлэлцэх асуудлыг багийн удирдлага тодорхойлж, түүний дагуу иргэдэд зар мэдээ хүргэдэг байна. Багийн хурлын тов тодорхой болсоны дараа үнэлгээ эрхлэгч танилцуулах материал, холбогдох мэдээллийг баг, хорооны удирдлагад явуулдаг боловч иргэдэд цааш нь түгээдэг эсэх нь тодорхой бус байдаг байна. Ихэнх тохиолдолд ИНХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилсан зарлан мэдэгдэх явдал ховор бөгөөд тухайн хуралдаан болон өдөр танилцуулдаг байна.

Дэлхийн банкны төсөл дээр ажиллаж байхад урьдчилаад 10 гаран хоногийн өмнө хурлын зар, танилцуулгаа тарааж өгчихөөд хурал болох үед буцаж ирээд тайлангаа хэлэлцүүлж байсан. Манай дотоодын төсөл дээр бол ийм зүйл байхгүй.

Үнэлгээ эрхлэгч

Сүүлийн үед багийн иргэд фейсбүүк групптэй болчихсон. Тэр групп дээр зарим газрууд хурлын зар, мэдээллээ тавьдаг болсон байна.

Үнэлгээ эрхлэгч

Багийн дарга мэдээллийг салбар ашиглаж хурал болох өдөр, хэлэлцэх асуудлын жагсаалт зэрэг мэдээллийг иргэдэд хүргэдэг. Алслагдсан өрхүүддээ утсаар мэдэгддэг.

Үнэлгээ эрхлэгч

19. Хурлын ирц бүрдэхэд бэрхшээл учирч байна

Хуулиар баг, хорооны Хурлын хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцдог. Энэ хэмжээнд баг, хорооны хурлын ирц бүрдээгүйн улмаас хурал хойшлох, үнэлгээний хэлэлцүүлгийн дахин хийх зэрэг чирэгдэл үүсдэг байна.

Тухайн хуралдаанаар ямар асуудлуудыг хэлэлцэхээс хамаарч ирц янз бүр байдаг байна. Зарим тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч иргэдийг гэрээс очиж авах, гэрээр нь очиж санал авч гарын үсэг зуруулах, иргэдийн сонирхлыг татсан арга хэмжээ /сугалаа, хоол хүнс, тэмцээн/ давхар зохион байгуулах замаар ирц бүрдүүлэхийг зорьдог байна.

УБ хотын хороодын хувьд хуульд заасан ирцийн босгыг хангасан хуралдаан зохион байгуулахад хорооны хүн амын тоо, заал танхимын хүрэлцээнээс хамаараад маш бэрхшээлтэй байдгийг зарим оролцогчид онцолсон байна.

Хурлын ирцийг бүрдүүлэх нь орон нутгийн удирдлагын эрх хэмжээний асуудал учраас төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч нь орон нутгийн удирдлагатай хэрхэн хамтарч ажиллахаас нилээд хамааралтай байдаг байна. Зарим тохиолдолд энэ нь ашиг сонирхлын зөрчил, авилгалын эрсдэл үүсгэж байна.

20. ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийн нийтлэг жишиг байхгүй байна

Дунджаар хуралдаан болсноос хойш 7 хоногт багтаан хурлын тогтоол, тэмдэглэлийг хүлээн авдаг байна. ИНХ-аар үнэлгээний тайланг танилцуулж, хэлэлцүүлсэн тэмдэглэл, хурлын тогтоолыг бэлтгэх нийтлэг ашигладаг загвар, жишиг маягт байдаггүй учраас зарим тохиолдолд үнэлгээ эрхлэгч тогтоол, хурлын тэмдэглэлийн эхийг бэлтгэдэг байна. Зарим тохиолдолд тогтоолын агуулга, хаяглалт, гарчиг ойлгомжгүй, албан хэрэг хөтөлөлтийн шаардлага хангаагүй байдаг учраас дахин гаргуулж авдаг байна.

Үнэлгээний ажлын төсөв ба оролцоо

21. Үнэлгээний ажлын төсөв, үнэ зах зээлийн өрсөлдөөнөөр тогтож байна

Үнэлгээний ажлын жишиг тариф байхгүй бөгөөд ихэнхдээ өрсөлдөөний зарчмаар үнийг тохиролцож байна. Үнэ нь төслийн байршил, төслийн хэмжээ, аль чиглэлийн төсөл, судалгааны ажлын цар хүрээ буюу хэдэн мэргэжилтэн оролцох зэргээс хамаарч хэлбэлздэг байна.

Улаанбаатар хотын ойр орчмын жижиг төслүүдийн үнэлгээ харьцангуй бага төсвөөр хийгдэж байна. Жишээ нь үйлчилгээний чиглэлийн жижиг төслийн үнэлгээ 4-15 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын төслийн үнэлгээ 5-15 сая орчимд хэлбэлздэг байна. Орон нутгийн хувьд томилолт, тээврийн болон бусад нэмэлт зардал гардаг тул төсөв нь бага зэрэг нэмэгддэг байна. Үнэлгээний олон жижиг компаниуд өрсөлдөж байдаг учраас заримдаа дундаж үнээс маш багаар буюу 500 мянгаас 2 сая орчимд тохирч үнэлгээ хийх тохиолдол байдгийг зарим оролцогч дурьдсан байна.

Уул уурхайн чиглэлийн төслүүдийн үнэлгээ төслийн төрөл, хэмжээнээс хамаарч хэлбэлзэх бөгөөд оролцогчдын мэдээлснээр жижиг төслүүдийн үнэлгээ 15-20 орчим сая, дундаж нь 30-50 сая, томоохон төслүүд нь 80-100 сая болон түүнээс дээш байдаг байна. Дэд бүтцийн томоохон төслүүдийн үнэлгээний үнэ харьцангуй өндөр байдгийг зарим оролцогчид дурьдсан байна.

Үнийн доод хязгаар эсвэл жишиг тариф тогтоох талаар үнэлгээ эрхлэгчдийн холбооноос санал дэвшүүлж байсан байна. Энэ судалгаанд оролцсон зарим үнэлгээ эрхлэгчид жишиг үнэ тогтоох нь үнэлгээний чанарт сайнаар нөлөөлнө гэж үзсэн байна.

22. Үнэлгээний төсөвт оролцооны ажлын эзлэх хувь 5-10 орчим байна

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдийн баримжаа тооцооллоор төслийн байршил, оролцоог хангах ажлын цар хүрээнээс хамаарч үнэлгээний ажлын төсвийн 5-10 хувийг оролцоог хангахтай холбоотой ажилд зарцуулдаг байна. Үүнд гол төлөв нөлөөллийн бүсд ажиллах, ИНХ-д оролцоход гарах тээврийн болон томилолтын зардал багтдаг байна.

Томоохон уул уурхайн төслийн хувьд олон удаагийн судалгаа, орон нутгийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатай бол төсвийн 20 орчим хувийг зарцуулсан тохиолдол байна. Ялангуяа Дэлхийн банкны санхүүжилттэй төслийн хувьд нэг төслийн үнэлгээнд 20 гаруй удаа орон нутаг ажиллах шаардлагатай болж, төсвийн 30 гаруй хувь нь түүнд зарцуулагдаж байсан жишээ байна.

23. Оролцоог хангахад шаардлагатай зардлыг үнэлгээний төсөвт суулгаж чадахгүй байна

Үнэлгээ эрхлэгчид үнэлгээний ажлын төсвийг төсөл хэрэгжүүлэгчтэй тохиролцохдоо оролцоог хангахад шаардлагатай зардлыг тусд тооцож оруулах боломж бага байдаг байна. Учир нь үнэлгээ эрхлэгчид ихэнхдээ төсөл хэрэгжүүлэгчидтэй үнэлгээний ажлын үнийг тохирохдоо нийт үнийн дүн санал болгодог байна. Ялангуяа жижиг, дунд хэмжээний төслийн үнэлгээний хувьд оролцоог хангахтай холбоотой зардал гэж тусд нь тавьж өгвөл төсөл хэрэгжүүлэгч ойлгож хүлээж авахгүй гэж үздэг байна.

Харин төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулахдаа хуульд заасан иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажилтай холбоотой гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч талаас гаргах, хамтран ажиллах талаар тусгахыг хичээдэг байна.

Улаанбаатар хот орчмын жижиг төслүүдийн үнэлгээний хувьд төсөл хэрэгжүүлэгч нь ИНХ-ын тогтоол буюу орон нутгаас “бичгээ авах” ажлыг хариуцдаг учраас оролцооны талаар зардал гэхээр зүйл нийт төсөвт багтдаггүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч тал бидэн лүү хандахдаа тэчнээн төгрөгийн ажил гэж хэлдэг. Ер нь хамгийн гол нөхцөл нь нийт үнэлгээг хэдэн төгрөгөөр хийх вэ гэдэг байдаг. Зардлуудаа тухай бүрт нь тооцоод өгөхөөр нэлээн өндөр гардаг. Бусад компаниуд хямд үнэ хэлээд байхад өндөр үнээр хийлгэх сонирхол байхгүй шүү дээ. Тийм болохоор бид хамгийн боломжит үнээ хэлээд түүн дотроо олон нийтийн оролцоог хангах зардал гэх мэт зүйлсээ өөрсдөө зохицуулдаг. Төсөвтөө тааруулж л ажилладаг.

Үнэлгээ эрхлэгч

Иргэдийн оролцоог хангах тал дээр цаад захиалагч компани хариуцна гэж оруулдаг. Тэгэхгүй болохоор манайх чинь хэцүү шүү дээ зарим иргэдийн нийтийн хурал дээр иргэдээ цуглуулахын тулд боодог хийнэ. Бөөн л юм болно шүү дээ. Урилга заллагаар зарим хүмүүсийг аваачина гээд бөөн л юм болно. Тиймээс захиалагч талдаа даатгадаг.

Үнэлгээ эрхлэгч

Иргэдийн нийтийн оролцоо, иргэдтэй холбоотой зүйлс гарч ирэхэд захиалагч тал аль болох бага мөнгө тусгах талаар боддог. Тиймээс удирдлагын зардлаар дотооддоо шийдэх асуудал мөнгө зарцуулахгүй хийе гэсэн зүйлс их гардаг.

Үнэлгээ эрхлэгч

Үүнээс үзэхэд үнэлгээний ажлын зардлын төсөвт оролцоог хангах талаар сайтар тусгаж өгдөггүйгээс аль болох бага зардлаар, шуурхай байдлаар санал авах, хэлэлцүүлэгт орох сэдэл болдог байна.

Бусад оролцогч талуудын тухай (1-5 оноогоор үнэлэх)

24. Төсөл хэрэгжүүлэгчид оролцооны асуудалд анхаарах шаардлага нэмэгдсэн /3.93 оноо/
Сүүлийн үед төсөл хэрэгжүүлэгчид оролцооны асуудалд анхаарал хандуулж хамтран ажиллах байдал сайжирч байна гэж үзсэн байна. Энэ нь хуульд заасан оролцооны шаардлагыг хангаагүй тохиолдолд төслийн үнэлгээ, улмаар төслийн хэрэгжилт удааширч буй асуудлаас үүдэлтэй байна. Төсөл хэрэгжүүлэгчийн БОНБУ, түүнд олон нийтийн оролцооны талаарх ойлголт, компанийн засаглал, нийгмийн хариуцлагын бодлого, төслийн цар хэмжээнээс хамааран үүрэг оролцоо нь янз бүр байна.

- Зарим төсөл хэрэгжүүлэгчид иргэдийн санал авах, ИНХ-аар тогтоол гаргуулах нь үнэлгээ эрхлэгчийн үүрэг гэж үзэн шүүд оролцохоос зайлсхийж, батлагдсан тайлан хүлээн авах нөхцөлтэй гэрээ хийдэг байна.
- Зарим төсөл хэрэгжүүлэгчид үнэлгээ эрхлэгчтэй нягт хамтран ажиллаж иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх ажилд эхнээсээ идэвхтэй оролцдог байна. Ингэхдээ зөвхөн дэмжсэн тогтоол гаргуулахад биш урт хугацаандаа орон нутагтай хамтран ажиллах, байгаль орчны үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаардаг байна.
- Зарим төсөл хэрэгжүүлэгчид оролцооны асуудлыг өөрснөө дангаараа хариуцан зохион байгуулдаг байна. Ялангуяа нь ИНХ-аар тогтоол гаргуулахад маш их анхаарч янз бүрийн арга

чарга хэрэгжийг хичээдэг компаниуд байдаг. Жишээ нь төслийг эсэргүүцдэг иргэдийг хуралд оролцуулахгүй байх, зарим иргэдийн саналыг худалдаж авах, нэр нөлөө бүхий хүмүүсээр иргэдэд нөлөөлөх зэрэг аргууд ашиглаж дэмжсэн тогтоол гаргуулахыг зорьдог байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх, хүндэтгэлтэй хандаж, иргэд, оролцогч талуудыг сонсох, үнэлгээний төсвийн уян хатан байдлыг дэмжих, үнэлгээ эрхлэгчтэй хамтран ажиллах, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах үүргээ хэрэгжүүлэх нь чухал болохыг үнэлгээ эрхлэгчид дурьдсан байна.

25. Орон нутгийн удирдлагын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна /3.03 оноо/

Орон нутгийн удирдлагын иргэдийн оролцоог хангах чиг үүргийн хэрэгжилт харилцан адилгүй байна. Гэвч ИНХ-ыг зохион байгуулах үүрэг хариуцлагаа орон нутгийн удирдлага хангалттай биелүүлэлдэггүй гэдэг байр суурь үнэлгээ эрхлэгчдийн дунд давамгайлж байна. Ингэхдээ хэд хэдэн чухал асуудлыг хөндөж байна. Үүнд:

- Орон нутгийн удирдлага иргэдийг мэдээллээр хангах үүргээ хангалттай хэрэгжүүлэхгүй байна. Үүнд үнэлгээний танилцуулга материал, тайланг уншиж судлах, улмаар хурлын зар мэдээ, үнэлгээний танилцуулга мэдээллийг хүргэх зэрэгт ач холбогдол өгөхгүй хойрго хандах байдал их байдаг.
- ИНХ-ын ирцийг бүрдүүлэхэд хүчин чармайлт гаргадаггүй. Төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн удирдлагатай ямар харилцаатай байхаас хамаарч хурлын ирцийг бүрдүүлж үнэлгээг хэлэлцэх эсэхийг шийддэг байдал нилээд байна. Энэ харилцаа нь төсөл хэрэгжүүлэгч орон нутагт тодорхой бүтээн байгуулалт, хандив түслэмжийн амлалт өгч тохиролцох, заримдаа орон нутгийн удирдлагад шан харамж өгөх эсэхээс хамаардаг байна.
- ИНХ-ын хуралдааны зохион байгуулалт тааруу. БОНБУ-ний талаарх ойлголт сул, орон нутгийн удирдлага болон иргэд мэдээлэлтэй урьдчилан сайтар танилцаж судлаагүй учраас хэлэлцүүлгийн зохион байгуулалт, асуулт, саналын үр дүн хангалтгүй байдаг байна.

26. Нутгийн иргэд, олон нийтийн оролцоо сул /2.88 оноо/

Улаанбаатар хоттой харьцуулахад хөдөө орон нутгийн ИНХ-д иргэдийн оролцох идэвх сайн байдаг байна. Үнэлгээ эрхлэгчдийн үзэж байгаагаар иргэдийн оролцоонд дараах саад бэрхшээл учирдаг байна.

- Хуралд ирж оролцох сонирхол бага. Зарим орон нутаг хуралдаад сурчихсан буюу иргэдийн ирц сайн байдаг бол ихэнх газар хуульд заасан ирцийг бүрдүүлэхэд орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчдээс хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог.
- БОНБУ-ний талаарх мэдлэг, ойлголт бага учраас асуулт, хариулт, хэлэлцүүлэгт оролцохдоо сул байдаг. Төслийг бүхэлд эсэргүүцэх, огт хамааралгүй сэдвээр асуух, бусдыг аялдан дагалдах явдал их байдгийг дурьдсан байна.

Орон нутгийн төрийн бус байгуулагуудын оролцоо үнэлгээний явцад төдийлэн байдаггүй гэж үзсэн байна. Зарим томоохон төслүүд эсвэл уул уурхай төвлөрсөн орон нутагт ТББ-уудын зүгээс хяналт тавих чиглэлээр оролцдог боловч жижиг, дунд хэмжээний төслүүдийн хувьд оролцоо байдаггүй байна. Үнэлгээ эрхлэгчдийн ихэнх нь ТББ-уудын талаар нилээд сөрөг ойлголт хандлагатай буюу ТББ-ууд нь ашиг сонирхлын зөрчилтэй, үймүүлэх эсэргүүцэх байр суурьтай, мэргэжийн бус, ул суурьтай ханддаггүй зэрэг шүүмжийг дурьдсан байна.

27. БОАЖЯ, мэргэжлийн зөвлөлийн дэмжлэг сул /2.88 оноо/

Яамнаас хуульд заасан бичиг баримтын бүрдүүлэлт буюу ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийг хавсаргасан байхыг шаардаж ажилладаг байна. Үнэлгээ эрхлэгчид дараах асуудлуудад яам, мэргэжлийн зөвлөлөөс анхаарал хандуулах шаардлага гэж үзсэн байна. Үүнд:

- ИНХ-аар хэлэлцүүлж санал авах гэдгийг “зөвшөөрсөн” “дэмжсэн” гэж ойлгох уу эерэг, сөрөг бүхий л саналыг сонсож, хариу тайлбарлаж, хэлэлцсэн гэж ойлгох уу гэдгийг тодорхой болгох шаардлагатай байна. Яам болон мэргэжлийн зөвлөл “зөвшөөрсөн” гэдэг утгаар ойлгож заавал “Дэмжих тухай” тогтоол шаардаж байгаа нь хуульд заасан үзэл баримтлалаас зөрж байна гэж үзэж буй үнэлгээ эрхлэгчид байна.
- ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийг шаардахаас өөрөөр яамнаас иргэдийн оролцоог хангах чиглэлээр бодлого, үйл ажиллагаа дутагдаж байна. Жишээ нь ИНХ нь хуралдахгүй хэлэлцүүлгийг хойшлуулж буй газрууд, орон нутгийн зүгээс төслийн үнэлгээг дэмжээгүй газруудад ажлын хэсэг, эксперт томилох байдлаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, БОНБУ-ний тогтолцоо, түүний ач холбогдлын талаар сурталчлан таниулах, орон нутгийн чадавхийг сайжруулах ажил зохион байгуулах хэрэгцээ байдгийг дурьдсан байна.
- Олон нийтийг оролцоог хангах хууль, журмыг батлан хэрэгжүүлж буй нь сайшаалтай боловч олон нийтийн утга учиртай оролцоог бий болгож чадаж байна уу, журам нь бусад хууль, бодит амьдралтай нийцэж хэрэгжиж байна уу гэдэг талаар үнэлгээ дүгнэлт хийх хэрэгтэй байна гэж үзсэн байна.

28. Үнэлгээний чиглэлүүд дэх иргэдийн оролцоог хангах байдлын ялгаа

Салбаруудыг хооронд нь харьцуулахад үнэлгээнд иргэдийн оролцоог хангах түвшин ямар байгааг үнэлүүлэхэд дараах дүн гарч байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн салбарт иргэдийн оролцоог маш сайн хангаж буй гэсэн хэрэг биш бусад салбартай харьцуулахад оролцооны асуудалд илүүтэй анхаарч байна гэж ойлгож болно.

Чиглэл	Дундаж оноо	Ерөнхий тайлбар
Уул уурхай	4.11	Олон нийтийн анхааралд байдаг, үйл ажиллагаа нь ил явагдаж, орон нутгийн сонирхол өндөр учраас оролцоог хангахад анхаардаг.
Дэд бүтэц	3.57	Томоохон төслүүдийн хувьд оролцоог хангахад анхаардаг.
Хүнд үйлдвэр	3.05	Мэдээлэл өгөх, иргэдийн санал авах байдал сул.
ХАА, үйлчилгээ	3.36	Ихэнх жижиг, дунд төслүүд иргэдийн санал биш захиргааны саналыг л авдаг.

Тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам

29. Журмын хэрэгжилтийн үнэлгээ: 3.11

Үнэлгээ эрхлэгчид журмын хэрэгжилтийг үнэлж өгсөн онооны дундаж 3.11 байна. Хуульд заасан ИНХ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлийг үнэлгээний тайланд хавсаргах шаардлага зохих хэмжээнд хэрэгжиж байна гэж үзсэн байна. Яамны зүгээс үнэлгээний тайлангийн бичиг баримтын бүрдүүлэлтийг шалгахдаа энэ тогтоол, тэмдэглэлийг хатуу шаарддаг байна. Харин процесс буюу иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах үйл явц үр дүнтэй явагдаж, байгаль орчны

шийдвэр гаргахад ач холбогдолтой мэдээллийг танилцуулах, оршин суугч, нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах талаасаа хангалтгүй байна гэж зарим үнэлгээ эрхлэгчид үзсэн байна. Олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилт жигд биш, ялангуяа жижиг, дунд хэмжээтэй төслүүдийн хувьд хангалтгүй байна гэж дурьдсан байна.

Журмын тодорхой заалтууд хэрэгжих боломж багатай, мөн тодорхой бус утга агуулгатай байдаг нь хэрэгжилтэнд саад болдог байна. Жишээ нь журам дээр тайланг боловсруулж дуусгаад 15 хоногийн дотор ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тогтоол, тэмдэглэлийн авна гэж заасан ч хэрэгждэггүй гэдгийг онцолсон байна. Мөн олон нийт, иргэд, нөлөөллийн бүсийн иргэд зэрэг ойлголтуудын тайлбар тодорхой бус учраас нөлөөллийн бүсийн иргэдийн саналын ач холбогдол буурдаг гэж үзсэн байна. Оролцоог хангахад талуудын үүрэг хариуцлагыг маш тодорхой зааж өгөөгүйгээс иргэдэд мэдээлэл өгөх, санал авах, ИНХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэг зохион байгуулах ажлууд хариуцах эзэнгүй хийддэг гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдоос журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээлийг асуухад дараах асуудлуудын дурьдсан байна. Зарим үнэлгээ эрхлэгчид журмын хэрэгжилттэй холбоотой саад бэрхшээл байхгүй гэж хариулсан бөгөөд тодорхой хариулт өгсөн 20 оролцогч байснаас 11 нь ИНХ-ын тов, ирцтэй холбоотой хугацаа алддаг асуудлыг дурьдсан байна.

Оролцогчдын дурьдсан асуудлууд	Давтамж
ИНХ-ын тов, ирцтэй холбоотой хугацаа алдах	11
Иргэдийн оролцоо сул, мэдээлэл багатай	3
Төслийн ангилал харгалзахгүй ижил шаардлага тавьдаг	3
Санал авах, зөвшөөрөл авах гэдэг ойлголтын зөрүү үүссэн	2
Оролцоотой холбоотой талуудын үүрэг хариуцлага тодорхой бус	2
Нөлөөллийн бүсийн иргэдийн саналын жин, үүрэг тодорхой бус	2

30. Цаашид анхаарах 5 асуудал

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдээс БОНБУ-нд оролцоог хангах чиглэлээр нэн түрүүнд засч сайжруулах асуудал юу вэ гэж асуусан бөгөөд тэд маш чухал саналуудыг дэвшүүлсэн. Эдгээрийг дараах 5 асуудлын хүрээнд ангилан үзэж, саналуудыг товчлон хүргэж байна. Хариултад хэдэн удаа дурьдагдсан давтамжийн тоогоор 1-5 хүртэл эрэмбэлсэн болно.

Асуудал	Оролцогчдын саналын тойм
1. Төслийн ангилал ба оролцооны шаардлага	<p><i>Төслүүдийн төрөл, нөлөөлөл, ангилал, хамрах хүрээнээс хамаараад иргэдийн оролцоог хангах асуудлыг ялгаатай тусгаж өгөх хэрэгтэй.</i></p> <p><i>Уул уурхай болон хүнд үйлдвэрлэлийн төсөл дээр зайлшгүй ИНХ-аа хэлэлцүүлээд жижиг төслүүд дээр ИНХ хуралдуулах шаардлагагүй. Үүний оронд ИНХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх, иргэдийн саналыг авсан тайлангаа олон нийтэд ил тод мэдээлэх, тайланд хавсаргах, мэргэжлийн зөвлөлөөр сайн хэлэлцээд зөвлөмж өгдөг байж болно.</i></p> <p><i>Орон нутгийн Байгаль орчны газарт үнэлгээний ангилалд үндэслэн БОННУ-ний тайланд дүгнэлт гаргах эрх мэдлийг шилжүүлэх замаар яамны ачааллыг бууруулж, орон нутгийн оролцоог нэмэгдүүлнэ.</i></p>
2. ИНХ-ын тов, зохион байгуулалт	<p><i>ИНХ, ИТХ-ын товыг улирал тус бүрээр тодорхой тогтоож өгөх хэрэгтэй байна.</i></p>

		<p><i>ИНХ-ын ээлжит бус, нэмэлт, хэсэгчилсэн хуралдаан хийх замаар БОНБУ-тэй асуудлыг хэлэлцвэл шуурхай, үр дүнтэй болно.</i></p> <p><i>Хурлын тов, зохион байгуулалт, ирц бүрдүүлэлтийг нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хуульд оруулж өгөх хэрэгтэй. Үүнд хурлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлагын механизм байх ёстойг тусгах хэрэгтэй.</i></p> <p><i>Бүх үйл ажиллагааг цахим болгох шаардлагатай. Хурлын тов нь тодорхой байдаг, тухайн аймаг, сум, багийн удирдлага, ажилтнууд хурлын мэдээллээ цахимаар цаг тухай бүрд нь мэдээлдэг, хурлын цагаа мэдэгддэг харилцаа холбоотой байх шаардлагатай байна.</i></p>
3.	Оролцооны талаарх талуудын ойлголт, хандлага	<p><i>Багийн ИНХ-аас гарсан шийдвэрийг яам талаасаа авч үзэхдээ дэмжих/дэмжихгүй гэсэн саналыг нь голчлох биш иргэдээс ирсэн саналуудыг нарийвчилсан үнэлгээн дээр хэрхэн тусгасан байна вэ гэдгийг нь харгалзаж үзэх хэрэгтэй.</i></p> <p><i>БОНБУ-ний зорилго, түүнд иргэдийн оролцоо ямар үүрэгтэй талаар талууд нэгдмэл ойлголттой болох хэрэгтэй байна. Үнэлгээний компаниудыг төсөл хэрэгжүүлэгчийн талд үйлчилж, зөвшөөрлийг авч өгдөг гэсэн ташаа ойлголтыг өөрчлөх хэрэгтэй байна.</i></p> <p><i>Иргэдэд БОНБУ хийхийн ач холбогдол, түүнд санал авах явц ямар үүрэгтэй болохыг сайтар сурталчан таниулах хэрэгтэй байна. Сургалт, сурталчилгааны ажлаа сайн хийх хэрэгтэй.</i></p>
4.	Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал	<p><i>Орон нутгийн хүмүүс ихэнхи нь интернет орж байгаа. Яамны сайтад үнэлгээний бүх мэдээлэл байгаа ч түүнийг олж мэдэхгүй байна. Тиймээс үнэлгээтэй холбоотой мэдээллийг цогц байдлаар нэг эх үүсвэрээс хялбар байдлаар иргэдэд түгээдэг байвал сайн байна.</i></p> <p><i>Орон нутгийн удирдлага төслийн эхний шатнаас иргэдэд мэдээлэл хүргэдэг байх хэрэгтэй. Зарлалын самбар, Фэйсбүүк, бусад сувгаар мэдээллийг хүргэж байх хэрэгтэй.</i></p> <p><i>Мэдээллийн олон сувгууд, ялангуяа хамгийн их ашиглаж байгаа сувгаар нь өгвөл зүгээр.</i></p> <p><i>Багтайгаа харилцаад тухайн баг хороонд мэдээллээ өгөөд, самбарт танилцуулга бэлдээд өгч болно /холбогдох мэдээлэл утас, холбоо барих хаягаа үлдээдэг/. Тухайн үйл ажиллагааны талаар сонирхсон асуудал санал байвал чөлөөтэй асууж болдог байвал зүгээр. Мөн танилцуулга материал бэлдээд тавьчихдаг, тэдгээрийг иргэд өөрсдөө сонирхвол уншаад танилцдаг байвал зүгээр.</i></p> <p><i>БОАЖЯ-аас, холбогдох төрийн байгууллагаас иргэдэд орон нутагт нь хийгдэж байгаа үнэлгээний талаар мэдээлэл өгдөг байх хэрэгтэй. Үүнд байгаль орчны мэдээллийн санг үр дүнтэй, шуурхай ашигладаг хэлбэрт шилжүүлж сурталчилж болно.</i></p> <p><i>Зөвхөн үнэлгээ эрхлэгчид биш төсөл хэрэгжүүлэгчид өөрсдөө үнэлгээний тайлангаа танилцуулж талуудад зөв тайлбар, мэдээлэл өгөх хэрэгтэй.</i></p>

		<i>ИНХ-ын хэлэлцүүлгийг хүлээлгүй үнэлгээний тайлангийн танилцуулга, хэлэлцүүлгийг үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгчид янз бүрийн арга, хэлбэрээр зохион байгуулдаг байх хэрэгтэй.</i>
5.	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	<i>БОННУ-ний дагуу боловсруулсан менежментийн төлөвлөөний хэрэгжилтийг хангах хариуцлага, хяналтын механзмыг сайжруулах хэрэгтэй.</i> <i>Жил бүрийн менежментийн төлөвлөгөө батлах, шалгах эрх бүхий субъектүүд нь тухайн төсөл иргэдийн оролцоог хангасан эсэхийг шалгаж, хангаагүй бол асуудал тавьдаг байх хэрэгтэй.</i>

31. Үнэлгээний явцад иргэдийн оролцоог хангах 3 хувилбар

Судалгаанд оролцогчдоос үнэлгээг хийж эхлэх үед болон хийж байх явцад санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэж асуусан. Өөрөөр хэлбэл ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдээс санал авах шаардлагыг хэрхэн хэрэгжүүлжсэн нь үр дүнтэй вэ гэж асуусан. Энэхүү үнэлгээний явцын оролцооны талаар гарсан саналуудыг дараах 3 бүлэгт ангилан үзэж болно.


Төлөв байдлын үнэлгээг хийх үед буюу ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахаас өмнө санал авах	Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах шатанд буюу байгаль орчны үнэлгээний суурь төлөв байдлын үнэлгээ хийх үед иргэдэд мэдээлэл өгч, санал авах нь үр дүнтэй. Төлөв байдлын үнэлгээний үе шатанд багахан хэмжээний танилцуулга хурал зохион байгуулж, ийм байгууллага, энэ газар ийм үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулах гэж байна гэсэн мэдээлэл өгөөд тухайн үйл ажиллагааг сонирхож байгаа иргэд санал хүсэлтээ хүргүүлж болдог байх хэрэгтэй.
Нарийвчилсан үнэлгээг хийх явцад буюу ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсаны дараа санал авах	Ерөнхий үнэлгээний дүгнэлт гараад нарийвчилсан үнэлгээг боловсруулж байх явцад иргэдийн саналыг аваад тайландаа тусгаад, хэрхэн тусгаснаа дараа нь хурал дээр танилцуулдаг байвал үр дүнтэй. Суурь судалгааны шатанд иргэдэд мэдээлэл өгч саналыг авах, үнэлгээ боловсруулах явцад нэмэлт саналыг авах, мөн ИНХ-аар хэлэлцүүлж санал авах гэх мэт шат дараатай хэд хэдэн удаа мэдээлэл өгч, саналыг нь авдаг байвал сайн.
Нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг авах	Нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдийн судалгааг гаргаж нарийвчилсан үнэлгээний явцад тэдний дунд санал асуулга, хэлэлцүүлэг, ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, тайланг хавсаргадаг болох хэрэгтэй.

32. Шийдлүүдийн шууд бус үр дагаврыг тооцох хэрэгтэй

БОНБУ-ний хэрэгжилтийн талаарх өмнөх судалгаа, олон улсын туршлага, зарим шинжээчидтэй хийсэн ярилцлагад үндэслэн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах байдлыг сайжруулахад авч хэрэгжүүлж болох арга хэмжээ буюу шийдлүүдийн хувилбаруудыг судалгаанд оролцогчдод танилцуулж, дэмжих эсэх болон яагаад гэдэг шалтгааныг асуусан.

Асуулгын үр дүнг доорх графикт тоймлон харуулав. Үүнээс үзэхэд төслийн ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлагыг дийлэнхээр дэмжсэн бол бусад санал болгосон шийдлүүдийн хувьд чухал ач холбогдолтой боловч үр дүнтэй хэрэгжих эсэх, нэмэлт хүнд суртал, шат дамжлаг үүсгэхгүй байх талаас нь сайтар судлан үзэх хэрэгтэйг дурьдсан байна.

График 1. Санал болгосон шийдлүүдийн талаарх байр суурь: Үнэлгээ эрхлэгчид



Шийдэл тус бүрийн хувьд дэмжихгүй гэж хариулсан үнэлгээ эрхлэгчдийн саналыг дараах хүснэгтэд тоймлон авч үзэв.

Шийдлийн хувилбарууд	Дэмжихгүй байгаа шалтгаан
1. БОАЖЯ, орон нутгийн байгууллага Ерөнхий үнэлгээ хийх тухай эсвэл хийсэн талаар нийтийн зар мэдээ хүргэх, санал хүлээн авах	<p><i>Бид нарын хийдэг шиг төлөв байдлын шатанд асуумжаар авчихдаг бол дэмжинэ. Дахиад ямар нэгэн хурал хийнэ гэвэл дэмжихэд хэцүү л юм.</i></p> <p><i>Төслийг улам л удаашруулна шүү дээ. Одоогийн ном журмын дагуу явахад 1 жил ч бараг хангалтгүй байна. Ерөнхий үнэлгээний түвшинд орон нутгаас санал авах юм бол уул уурхайн төсөл дээр бол нөлөөллийн бүсэд байхгүй иргэд хүртэл ирж эсэргүүцнэ. Энэ бол хүнд суртлыг улам нэмэгдүүлэх асуудал гэж бодож байна.</i></p> <p><i>Орон нутгийн байгууллага хийнэ гэвэл болж байна. Бүх асуудлыг яаман дээр төвлөрүүлэх шаардлагагүй.</i></p>
2. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд оролцоог хангах ажлын шаардлагуудыг тодорхой тусгах	<p><i>Ерөнхий үнэлгээгээр та нар бүр нарийвчлаад судлаад ир гэж байгаа учраас ерөнхий үнэлгээнд нарийвчилж тусгах шаардлага байхгүй.</i></p> <p><i>Авдаг хавсаргах бичиг баримтын тоо нь нэмэгдээд, үүн дээр дахин ерөнхий үнэлгээн дээр нь ахиад санал авдаг асуудал нэмэгдвэл улам л хүндрэлтэй байна байх.</i></p>

	<i>Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд олон нийтийн оролцоог хангах талаар тунхагын хэд хэдэн зүйл байдаг. Заавал дэлгэрүүлээд байх шаардлага байхгүй.</i>
3. Үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах	<i>Зураг авахад их дургүйцдэг. Орчин үед хүмүүс эрх үүрэг их ярьдаг болсон учраас нотлох баримтны зураг, бичлэг цуглуулах их хэцүү байдаг.</i> <i>Бичиг цаасны нэмэр. Гэхдээ хавсаргахад асуудал байхгүй л дээ. Цаг, мөнгө зараад ажлаа хийж ирээд тайлангаа өгч байхад заавал бүгдийг нь хавсаргаж цаас нэмэр шаардлагагүй.</i> <i>Одоо байгаа нөхцөлөөр хавсаргадаг, түүнийгээ яаж багасгах вэ гэж байхад ихэсгэвэл дэмжихгүй.</i>
4. Төслийн ангилалаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах	<i>Шаардлагагүй. Одоо байгаа аргачлал нь 2-3 үе шат дамждаг болохоор зүгээр гэж бодож байна. Аргачлалын дагуу том төсөл дээр үнэлгээ хийж болж байна, жижиг төсөл хөтөлбөр дээр хийж болж байна.</i>
5. Яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах	<i>Дахиад л төрийн захиргааны байгууллага руу хандана гэдэг бол дахиад л хугацааны асуудал үүсгэнэ.</i> <i>Бүх зүйлийг яамнаас журамлаад байвал яаман дээр очоод гацна. Нийтлэг заавар, аргачлал гаргаж түүнийг хүрээнд ажиллавал зүгээр.</i> <i>Асуултуудыг маш оновчтой тодорхой болгохгүй бол. Нэгдсэн журмаар гээд хэтэрхий ерөнхий асуудлууд дэвшүүлсэн байвал харьцуулж үр дүн гаргахад учир дутагдалтай болчих байх. Нэгдсэн нэг арга зүй байхад болно.</i>
6. БОНБУ-ний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах	<i>Баг хорооны дарга нар чинь хурлаа хуралдуулахгүй гацаана шүү дээ. Хурал хэнд ашигтай вэ гэвэл төсөл хэрэгжүүлэгчид ашигтай тийм учраас төсөл хэрэгжүүлэгч л өөрөө хариуцаж хурал хийлгэнэ үү гэхээс цаад хүн хариуцвал хөдлөхгүй шүү дээ.</i> <i>Орон нутаг өөрсдөө хариуцна гэхээсээ илүү хурлын хугацааг нь аймаг, сумаас нь гаргаад өгчихдөг байвал зүгээр. Сард нэг удаа хуралддаг болчихвол маш сайн байна. Улиралд нэг хуралдана, тэгж байгаад хуралдана гэсэн хариу өгдөг.</i>
7. Олон нийт, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх	<i>Үр дүн бага. Хөдөө орон нутгийн иргэд зоот гэх мэт онлайн платформ ашиглах боломж бага, Ирц бүрдэхгүй, дагаад асуудлаа хэлэлцэхгүй гэх мэт янз бүрийн зүйлс гарч ирнэ.</i> <i>Малчин айлын хүүхдүүд теле хичээлдээ хамрагдаж чадахгүй байхад энэ асуудал боломжгүй болов уу. Сүлжээ, техникийн асуудлууд маш их тулгарах байх. Гэхдээ аажимдаа заавал хэрэгжүүлэх зүйлсийн нэг болох байх.</i> <i>Тухайн төслийг хэрэгжүүлэхээр олон хүмүүс хөдөлмөр, цаг, мөнгөө зарцуулж байхад компьютерийн цаанаас юу ч бичиж болно. Биечилж уулзаад танилцуулаад ойлгуулаад тулгарч байгаа асуудлыг нь сонсоод хэлэлцүүлсэн нь илүү үр дүнтэй.</i>

	<i>Хот, Аймаг, сумын төвийн багуудад цахимаар санал авбал дэмжинэ.</i>
8. БОНБУ-ний талаар баг, сумаас Олон нийтийн сонсгол зохион байгуулах	<p><i>Хэрэв тийм зүйл боллоо гэхэд иргэд оролцохгүй байх.</i></p> <p><i>Иргэдээр тухайн төслийг дэмжих үгүйг шийдэх нь утгагүй санагддаг.</i></p> <p><i>Аль болох өргөн цар хүрээтэй зохион байгуулахаар утгаа алдаад байна.</i></p> <p><i>Өөрсдийн дотооддоо нэг сонсгол хийгээд ярилцдаг бол болно. Хүсэлт тавих үед ч юм уу. Сонсгол нь хурдан шуурхай болдог бол болно. Манайхан сонсголоо тавьж байна дараа нь хурлаа хийж байна гээд нэлээн хүндрэлтэй байдал үүсэх болов уу.</i></p>
9. Зөвхөн баг, хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /шинэ хуулиаар Зөвлөл/ үнэлгээний тайланг хэлэлцдэг байх	<p><i>Төслөөсөө хамаарна. Том хэмжээний төсөл дээр зөвхөн тэргүүлэгчдээс нь санал авч болохгүй. Жижиг, дунд хэмжээний төслүүд дээр тэргүүлэгчид нь байхад болно гэж бодож байна.</i></p> <p><i>Асуудалтай төслүүдийн хувьд маш том боломж болчихож байгаа юм. Уг нь дэмжихвэл зүгээр. Гэхдээ тэр асуудалтай төслүүд нь 5 хүнд хэд хэдэн төгрөг өгөөд л шийдүүлчих талтай байх. Тэр 5 нөхөр орон нутгийн иргэдийн оролцоог бүрэн дүүрэн хангаж чадахгүй шүү дээ.</i></p> <p><i>Нөлөөллийн бүсийн иргэдийн 70% нь дэмжиж байна үлдсэн хувь нь эзгүй байна оролцох боломжгүй байвал иргэдийн төлөөлөгчдийн даргад очиж тогтоол гаргуулж болно. Эсвэл нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг 100% тусгаад түүнийг тайланд хавсаргаад яам баталдаг байвал үр дүнтэй.</i></p> <p><i>Төсөл төслөөсөө хамаарч хэлэлцэх хэрэгтэй. Жнь: Том уул уурхайн төслүүд дээр заавал ИНХ хуралдаж шийдэх хэрэгтэй.</i></p> <p><i>Том төслүүдийг зөвхөн тэргүүлэгчдийн хурлаар шийдэж болохгүй. Зөвхөн хувийн ашиг сонирхолоо бодвол дэмжиж болно. Гэхдээ ингэж шийдвэл их хор хохиролтой.</i></p> <p><i>Ажлаа бодвол дэмжмээр байна. Гэхдээ хүмүүс бичгээ авахын тулд тэргүүлэгчдэд хахууль өгөх асуудал үүсэх байх.</i></p>

Дүгнэлт

Үнэлгээ эрхлэгчдийн судалгаанаас үзэхэд БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа нь хуулийн дагуу яамнаас шаарддаг үнэлгээний тайланг хэлэлцсэн ИНХ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийг гаргуулахад төвлөрч байна. Гэвч хууль, журамд заасан иргэдэд мэдээлэл өгөх, урьдчилсан санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлангийн ил тод байдлыг хангах шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

БОНБУ-ний тухай хууль, холбогдох журмуудад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг тусгахдаа хэн, хэзээ, хэрхэн гэдэг үүрэг, хариуцлагын үялдааг хангаагүйн улмаас ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатны мэдээлэл өгөх, санал авах ажил орхигдох, ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах ажил утга учиртай, мэдээлэлд суурилсан оролцоог хязгаарлах сөрөг үр дагаварт хүргэж байна. Үүний зэрэгцээ үнэлгээ хийх төслийн ангилал хэт өргөн хүрээтэй, зарим жижиг, дунд

хэмжээний төслүүдийн төсөв хэт бага, мөн үнэлгээ эрхлэгч компаниудын оролцоог хангах чадавх сул байдгаас хамаарсан бэрхшээл тулгарч байна.

Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчид олон нийтийн, ялангуяа төслийн нөлөөлийн бүсийн иргэдийн оролцоо нь төслийн сөрөг нөлөөллийг оновчтой тодорхойлох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхөд чухал ач холбогдолтой гэж үзсэн. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчилж үзэх, түүний дагуу оролцооны шаардлагуудыг ялгаатай тусгах, үнэлгээний эхлэлээс батлагдах хүртэлх олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхой болгох, БОНБУ-ний талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулах, үнэлгээний мэдээлийн хүртээмжтэй байдлыг сайжруулах хэрэгтэй гэдэг саналууд дэвшүүлсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч компаниудын судалгаа

Судалгаанд оролцогчид: Уул уурхайн компаниуд

Төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн компаниудын хувьд сүүлийн 3-5 жилд нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн, томоохон 30 компанийн төлөөллийг хамруулсан. Ашигт малтмалын хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөлд БОННУ-г хавсаргасан байхаас гадна уул уурхайн ашиглалтын ордыг дагасан үйлдвэр, дэд бүтэц барих, ашиглахтай холбоотой БОННУ хийлгэх шаардлага үүсдэг. Судалгаанд нийт 13 аймаг, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 34 байршил хамрагдсан байна. Байршлын хувьд авч үзвэл Монгол улсын уул уурхайн тэргүүлэх бүс нутаг болх Өмнөговь, Төв, Баянхонгор аймаг, мөн зүүн, баруун, төвийн бүсээс хамрагдсан байна.

Хүснэгт 2. Уул уурхайн компаниудын байршил, %

№	Аймаг	Тоо	%	№	Аймаг	Тоо	%
1	Баянхонгор	2	5.9	8	Өмнөговь	9	26.5
2	Говь-Алтай	1	2.9	9	Сүхбаатар	1	2.9
3	Дархан-Уул	2	5.9	10	Сэлэнгэ	2	5.9
4	Дорнод	2	5.9	11	Төв	6	17.6
5	Дундговь	1	2.9	12	Увс	1	2.9
6	Завхан	1	2.9	13	Улаанбаатар	2	5.9
7	Өвөрхангай	2	5.9	14	Хэнтий	2	5.9
Нийт						34	100%

Уул уурхайн олборлолтын салбарын хувьд зэс, нүүрс, төмөр, өнгөт металл, алт, жонш, шавар зэрэг ашигт малтмалын төрлүүд жигд тэнцвэртэй хамруулсан байна. Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа явуулсан жилийг авч үзвэл хамгийн багадаа 3 жил, хамгийн ихдээ 43 жил, дунджаар 14 жил үйл ажиллагаа явуулсан уул уурхайн аж ахуй нэгжүүд хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдыг авч үзвэл 19 эрэгтэй, 11 эмэгтэй байсан бол насны хувьд хамгийн залуу нь 25, хамгийн ахмад нь 76 настай бол, дундаж нас 39 байна.

Хүснэгт 3. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын мэдээлэл

№	Компанийн нэр	Хот/Аймаг	Сум/Дүүрэг	Салбар	Ү/а явуулсан жил
1	Хан Алтай Ресурс ХХК	Говь-Алтай	Есөнбулаг	УУ	3
2	Болдтөмөр ерөө гол ХХК	Сэлэнгэ	Ерөө	УУ/Төмөр	14
3	Эрдэнэ Ресурс ХХК	Баянхонгор	Шинэжинст	УУ	13
4	МАК ХХК	Өмнөговь, Дорнод, Дорноговь, Төв	Гурвантэс	УУ/Нүүрс/Алт	23
5	Тэгшхан ХХК	Дархан-Уул	Дархан	УУ/Шавар	14
6	Дацан трейд ХХК	Увс,Төв, Хэнтий	Норовлин	УУ/Алт	10
7	Эрдэнэс таван толгой ХК	Өмнөговь	Цогтцэций	УУ/Нүүрс	10
8	Саус Гоби Сэндс ХХК	Өмнөговь	Гурвантэс	УУ/Нүүрс	13
9	Хонгорын орд ХХК	Сэлэнгэ	Баянгол	УУ/Алт	17

10	Степ голд ХХК	Дорнод	Цагаан-Овоо	УУ/Алт/Мет	3
11	Багануур ХК	Улаанбаатар	Багануур	УУ	43
12	Хүнт-өгөөж ХХК	Сүхбаатар	Мөнххаан	УУ/Жонш	14
13	Энержи Ресурс ХХК	Өмнөговь	Цогтэций	УУ	13
14	Илт гоулд ХХК	Төв	Заамар	УУ/Заамар	13
15	Оюу толгой ХК	Өмнөговь	Ханбогд	УУ/Зэс	20
16	Андын тэмүүлэл ХХК	Баянхонгор	Баян-Овоо	УУ/Алт	5
17	Шохой цагаан булаг ХХК	Төв, УБ	Эрдэнэ	УУ/Чулуу	13
18	Хангад эксплорэйшн ХХК	Өмнөговь	Ханхонгор	УУ/Дэд	7
19	Чинхуа мак нарийн сухайт ХХК	Өмнөговь	Гурвантэс	УУ/Нүүрс	18
20	Аум алт ХХК	Өвөрхангай	Уянга	УУ/Алт	9
21	Баян айраг эксплорэйшн ХХК	Завхан	Дөрвөлжин	УУ	11
22	Өсөх Зоос ХХК	Өмнөговь	Гурвантэс	УУ	6
23	Монполимет ХХК	Төв	Заамар	УУ/Алт	20
24	Уулзаамар ХХК	Төв	Заамар	УУ/Алт	8
25	Хүдэр-Эрдэнэ ХХК	Төв	Сэргэлэн	УУ/Алт	25
26	Гурвантамга ХХК	Өвөрхангай	Зүүнбаян-Улаан	УУ	18
27	Тэвшийн говь ХХК	Дундговь	Сайнцагаан	УУ	31
28	Шандын нуруу ХХК	Хэнтий	Жаргалтаан, Цэнхэрмандал	УУ	6
29	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	Дархан-Уул	Хонгор	УУ	27
30	Өсөх зоос алтаговь ХХК	Өмнөговь	Гурвантэс	УУ	2

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт

1. Оролцоо нь үр дүнтэй үнэлгээ хийх чухал алхам

Судалгаанд оролцогчид БОНБУ-нд иргэд, олон нийт оролцох нь үнэлгээг үнэн бодитой, үр дүнтэй хийх, сөрөг нөлөөллийг бүрэн гүйцэт тодорхойлж, сөрөг нөлөөллөөс зайслхийх, бууруулах арга замуудыг боловсруулахад чухал ач холбогдолтой үйл явц байх ёстой гэж үзсэн байна. Түүнчлэн оролцоог хангах нь иргэд мэдээлэл авах боломжийг олгож, төслийн үйл ажиллагаа, үнэлгээний талаар зөв ойлголттой болоход чухал гэж үзсэн байна.

Зарим оролцогчид БОНБУ нь уул уурхайн төсөл орон нутгийн иргэдтэй харилцан ойлголцох чухал үе шат гэж үзсэн байна. Иргэд уул уурхайн төсөл хэрэгжээд дуусахад хохироод үлдэх ёсгүй учраас мэдлэг мэдээлэлтэй байж, өөрсдийн санал, эрх ашгаа аль болох тодорхой, үндэслэлтэй илэрхийлэх нь зөв гэж зарим оролцогчид үзсэн байна.

2. Мэдээлэлд үндэслэсэн тодорхой санал үр дүнтэй

Орон нутгийн иргэд мэдээлэлтэй сайтар танилцаж, байгаль орчин, өөрсдийн амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тодорхой саналуудыг гаргавал үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг оновчтой боловсруулахад ач холбогдолтой гэж уул уурхайн мэргэжилтнүүд үзсэн байна.

Уул уурхайн төсөл ямар нэг байдлаар байгаль орчинд тодорхой хэмжээний нөлөөг үзүүлнэ. Тэр нөлөөллийг тухайн орон нутгийн онцлогт тохируулж хэрхэн бууруулах вэ? гэдгийг тухайн орон нутгийн иргэд хамгийн сайн мэднэ. Тийм болох тэдний орон нутгийн байгаль орчны онцлогийн талаарх мэдлэгийг бидэнтэй хуваалцах хэрэгтэй гэж бодож байна.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч Байгаль орчны талаар, түүнийг төсөл хэрэгжүүлэгчтэй хамтарч хэрхэн шийдвэрлэх талаар санал хэлбэл илүү үр дүнтэй байж чадна. Төсөл хэрэгжүүлэгч болон иргэд ойлголтоо нэгтгэх хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч иргэдэд мэдээлэл өгдөг байх хэрэгтэй.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч Олон нийтийг хамарсан бэлчээртэй холбоотой шийдвэрлэх санал хэлбэл хэрэгтэй. Амин хувийн гэхээсээ илүү олон нийтийн эрх ашгийн асуудал байвал зүгээр.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч

БОНБУ-нд иргэдийн саналыг авахад анхаарах зарим асуудлыг судалгаанд оролцогчид дурьдсан байна Үүнд:

- Төсөл, үнэлгээний талаар урьдчилсан мэдээлэл өгч, уншиж танилцах боломж олгох
- Иргэдтэй нээлттэй нүүр тулсан үулзалтууд хийж саналыг сонсох
- Иргэд саналаа амаар болон бичгээр буюу саналын хуудсаар өгөх боломжтой байх
- Иргэд саналаа аль болох нэгтгэж, нийтийн эрх ашгийн төлөөх тодорхой санал хэлэх

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах түршлага ба тулгарч буй асуудал

3. ИНХ-аар хэлэлцүүлэх нь оролцоог хангах үндсэн ара зам

Судалгаанд оролцогчдоос “Таны түршлага, ойлголтоор үнэлгээний компаниуд үнэлгээ хийхдээ олон нийт, иргэдийн санал авах ажлыг хэрхэн зохион байгуулдаг вэ?” гэж асуухад нийт 30 оролцогчоос 23 нь багийн ИНХ-аар хэлэлцүүлэх, 8 оролцогч төлөв байдлын үнэлгээний өрхийн судалгаа, 7 оролцогч айл өрхүүд зочилж санал бодлыг сонсох, санал асуулгын хуудас бөглүүлэх ажлыг үнэлгээ эрхлэгчид зохион байгуулдаг гэж хариулсан байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн хувьд багийн ИНХ-ын хэлэлцүүлгийг зохион байгуулахад гол үүрэгтэй оролцдог байна. Зарим тохиолдолд үнэлгээ эрхлэгч оролцохгүйгээр төсөл хэрэгжүүлэгч багийн хуралд оролцож үнэлгээг танилцуулдаг байна.

4. Үнэлгээний явцад санал авах үйл ажиллагааны талаар мэдээлэл багатай байна

Төсөл хэрэгжүүлэгчдийн хувьд төлөв байдлын үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээний явцад иргэдээс санал авах үйл ажиллагааны талаар мэдээлэл багатай байна. Үнэлгээний тайланд иргэдийн саналыг хэрхэн харгалзан үздэг, хичнээн айл өрхөөс, ямар аргачлалаар санал авсан талаарх мэдээлэл бага байдгийг судалгаанд оролцогчдын хариултаас дүгнэж болохоор байна.

5. ИНХ-аар хэлэлцүүлэхийг зөвшөөрөл өгөх гэдэг ойлголт түгээмэл байна

ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах хуулийн шаардлагыг орон нутгийн удирдлага, иргэд төслийн үйл ажиллагааг зөвшөөрөх эсэх тухай санал гэсэн ойлголттой байдаг нь олон сөрөг үр дагавартай байна гэж үзсэн байна. Үүнд:

- Орон нутгийн удирдлага хурлаар дэмжихгүй бол энэ төсөл цаашаа үргэлжлэх боломжгүй юм байна гэсэн ойлголтоор өөрт ашигтай байдал үүсгэхийг оролдох
- Иргэдийн саналыг нь дэмжих, дэмжихгүй гэдэг байр суурьт холбогдуулж буруушаах хандлага байдаг тул тодорхой санал хэлэхээс зайлсхийхэд хүрэх
- Нөлөөлөлд өртөж болзошгүй эсвэл өртөж буй иргэдийн оролцоо, саналын үнэ цэнэ үгүй болж орон нутгийн удирдлага, тодорхой хэсэг хүмүүсийн байр суурь давамгайлах
- Саналаа наймаалцах буюу дэмжих санал өгсөний хариуд амин хувийн дэмжлэг авах сэдэл үүсгэх

Тийм учраас энэхүү ойлголтын зөрүүг арилгах талаар журамд тодорхой заах, яамнаас мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах шаардлагатай байна.

6. Мэдээллийн хүртээмж хангалтгүй учраас иргэдийн ойлголт муу байна

Нэгдүгээрт, БОНБУ-ний талаарх мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг оролцогч талууд, ялангуяа багийн удирдлагад зориулж зохион байгуулах шаардлагатай байгааг төсөл хэрэгжүүлэгчид дурьдсан байна.

Хоёрдугаарт, тухайн төслийн үнэлгээний талаарх мэдээллийг олон сувгаар орон нутгийн иргэдэд хүргэж, ямар зорилгоор санал авч байгаа, ямар ач холбогдолтой талаар зөв ойлгуулах хэрэгтэй байна гэж үзсэн байна.

7. Үнэлгээний компанийн оролцоог хангах чадавх сул байна

Үнэлгээний компаниуд иргэдээс мэдээлэл цуглуулах, санал авах ажлыг журмын дагуу, хангалттай сайн хийхгүй мэдээлэл хүргэх, оролцооны асуудлыг орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчийн хариуцлага гэж үзэх байдал их байдгийг дурьдсан байна. Үүнд иргэдээс санал авч буй аргачлал нь тодорхой бус, тайланд хэрхэн тусгасан талаар мэдэх боломжгүй байдаг, хотод байдаг учраас орон нутгийн талаар хангалттай сайн судлах, иргэдтэй уулзах боломж багатай, орон нутгийн онцлогийн талаар мэдээлэл муу байдгаас асуудлын гүн рүү оролгүй өнгөц дүгнэлт хийдэг талаар дурьдсан байна. Зөвхөн байгаль орчны мэргэжлийн үнэлгээ, судалгаанд анхаарч үнэлгээний оролцогч талуудын талаар судлах сонирхол бага байдаг гэсэн байна.

Үнэлгээний компаниуд бол аль болох л хийж байгаа ажлаа орон нутагт шилжүүлэх, асуудлаа яамаар нь батлуулж ажлынхаа ард гарахыг л бодож байгаа. Зарим сайн туршлагатай үнэлгээний компаниуд бол зарим байгаль орчинд хөнөөлтэй төслийн яг зөв үр дүнг нь гаргаад иргэдэд танилцуулаад тэр төсөл хэрэгжих үгүй нь хамаагүй, өөрсдийнх нь ажил дуусах үгүй нь хамаагүй гэж ханддаг. Тэгээд зарим нэг төсөл авч байгаагүй компаниуд ерөөсөө л энэ ажлыг бушуухан шиг батлуулж байвал болоо гэсэн хандлагатай байдаг.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч

8. Орон нутгийн иргэд хангалттай мэдээлэлгүйгээр оролцож байна

Иргэдэд үнэлгээний талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр, урьдчилж өгөөгүйн улмаас ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлэг маш үр дүнгүй болдог гэдгийг зарим оролцогчид дурьдсан байна.

Иргэд багийн ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлэхэд төслийн талаар, түүний хүрээнд хийгдэж байгаа үнэлгээний талаар бүрэн ойлгож чаддаггүй. Учир нь үнэлгээний тайланг хамгийн багадаа 100 гаруй хуудас бөгөөд тэр бүгдийг 1-2 цагт ойлгоод, ач холбогдолтой санал хэлнэ гэдэг бараг боломжгүй зүйл. Иймээс зөвхөн ИНХ-ийн үед бэлтгэсэн танилцуулга дээр үндэслэж санал хэлж, асуулт тавьж байгаа нь үр дүнтэй биш байдаг.

9. Орон нутгийн удирдлагын сонирхол иргэдийн оролцоонд нөлөөлдөг

Уул уурхайн компани ба орон нутгийн удирдлагын харилцааны төлөв байдлаас ИНХ-ын хурлыг шуурхай зохион байгуулах, ирц бүрдүүлэх, иргэдийн дэмжлэг авах үйл явц ихээхэн хамаардаг байна. Орон нутагтай хамтын ажиллагаа сайтай, тайлан төлөвлөгөөг хэлэлцүүлж явдаг компаниудын хувьд үнэлгээний санал авах, хэлэлцүүлэг хийх ажил бэрхшээл багатай хэрэгждэг бол бусад газруудад орон нутгийн удирдлагын зүгээс оролцоо, дэмжлэг бага, зарим газар зориуд чирэгдэл үүсгэдэг байдал нилээд байдаг байна.

Нөгөөтэйгүүр орон нутгийн удирдлага үнэлгээ эрхлэгчид болон төсөл хэрэгжүүлэгчдээс мэдээлэл авдаг боловч иргэдэд танилцуулах, мэдээлэл хүргэх үүргээ биелүүлдэггүй гэж үзсэн байна. Сонгуулийн үр дүнд сонгогдох эсвэл томилогдож ажилладаг албан тушаалтнуудын хувьд уул уурхайн төслийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх нь улстөрийн эрсдэл байдлаар ойлгож зайлсхийдэг гэж үзсэн байна.

Та нар өөрсдөө хурлаа хийгээд яв гэдэг эсвэл нэг очоод уулзахаар ганц компанийн төлөө багийн ИНХ-ыг хуралдуулдаггүй юм аа байж бай гээд хүлээлгээд байна. Бид нар хүсэлтээ өгчихсөн багаа цаг хугацаа боломжит байдлыг маань ойлгоод хуралдуулаад өгөөч гэж гуйхаар нэг компанийн захиалгаар төрийн ажил явдаггүй юм гээд данхайгаад байж байдаг.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч

Удирдлагууд бол ойлгоно. Засаг даргын тамгын газар ажиллаж байгаа хүн чинь ядаж л дээд боловсролтой байгаа тийм хүмүүс чинь бол ойлгодог. Гэхдээ ойлгож байгаагаа иргэддээ ярьдаггүй байхгүй юу. Тэгж танилцуулбал уурхайн талд орсон болчихно, тэгэхлээр сонгуулиар нөгөө иргэд нь өөрийнх нь талд орохгүй больчихно гэж бодоод байдаг.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч

10. Багийн ИНХ-ын хуралдааны давтамж харилцан адилгүй байна

Багийн ИНХ нь жилдээ 2-3 удаа хуралддаг гэсэн хариултууд олонх байсан бол зарим газар тэгш тоотой сар болгонд буюу жилд 6 удаа, зарим газар шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдаан зохион байгуулдаг гэж хариулсан байна. Жилд цөөн удаа хурал болдог багт үнэлгээний тайланг хэлэлцүүлэхэд хугацаа алдах, зарим тохиолдолд Тэргүүлэгчдийн хурлаар тогтоол гаргуулдаг байна.

Үнэлгээний тайланг ихэнх тохиолдолд ээлжит хурлаар багийн бусад хэлэлцэх асуудлуудын дараалалд оруулж хэлэлцдэг байна.

17-20 гаруй асуудал хэлэлцэнэ жилдээ цөөн удаа болдог учраас янз бүрийн тэтгэвэр тэтгэмж тогтоолох, хүмүүстээ шагнал тодорхойлох мөн янз бүрийн нэгж байгууллагуудаас гардаг шийдвэрүүд бол ИНХ-аар хэлэлцүүлэг хийгддэг.

Төсөл хэрэгжүүлэгч

Хамт дарааллын дагуу хэлэлцдэг. Уул нь энэ асуудлаа нэг цэгцэлмээр байгаа юм. Эхлээд багийнхаа дотоод асуудлыг зөндөө ярьдаг. Тэгээд хамгийн сүүлд нь компаниудаа оруулдаг. Тэгэхээр зарим иргэд нь холоос ирсэн байдаг болохоор яг компанийн асуудал хэлэлцүүлэх хэсэг дээр гараад явчихдаг. Тэгээд ирц хүрэхгүй хойшлох асуудал гардаг.

Судалгаанд оролцогч 30 хүнээс 13 нь ИНХ-ын ирц бүрдэх тухайд бэрхшээл тулгардаггүй гэсэн бол бусад 17 оролцогч ирц бүрдэхтэй холбоотой бэрхшээл тулгардаг гэж хариулсан байна. Үүнд тухайн ИНХ ямар асуудлаар хуралдах гэж байгаагаас хамаарах, орон нутгийн улирлын онцлогтой иргэдийн оролцох боломж, хурлыг дуусгалгүй гарах зэрэг шалтгааныг дурьдсан байна. Ирц бүрдээгүйн улмаас хурал хойшлох, хэлэлцүүлгийг хийх боломжгүй тарах асуудлууд үүсдэг байна. Ирц нь иргэдийн идэвх, зохион байгуулалт, сүүртшлын тархалт, багийн удирдлагын хариуцлага, зохион байгуулалтын асуудал учраас орон нутаг бүрт харилцан адилгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгчид ИНХ-ын хэлэлцүүлгийн үр дүнтэй болгоход дараах арга хэмжээг авч болох санал дэвшүүлсэн. Үүнд:

- Ээлжит бус хурал зохион байгуулж үнэлгээг дангаар нь хэлэлцэх
- Ээлжит хурлуудын давтамжийг нэмэгдүүлэх
- Хуралдааны үеэр бичгээр буюу асуулгын хуудсаар санал давхар авах
- Хурал болохоос өмнө иргэдэд зориулсан танилцуулга зохион байгуулах
- Үнэлгээний тайлангийн хураангуй, танилцуулгыг иргэдэд маш ойлгомжтой болгож боловсруулах
- БОАЖЯ, аймгийн Байгаль орчны газраас холбогдох мэргэжилтэн оролцох, хяналт тавих

Зарим оролцогчид ИНХ-аар хэлэлцүүлдэг одоогийн шаардлагыг өөрчилж илүү уян хатан, шуурхай аргаар иргэдийн саналыг авах хэрэгтэй гэж үзсэн байна. Үүнд:

- Сумын ИТХ, багийн хурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх
- Иргэдийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, түүний тайлангаа багийн удирдлагад танилцуулах
- Багийн иргэд, ялангуяа нөлөөллийн бүсийн иргэдийн санал асуулга судалгаа хийх
- Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, түүнд яам, холбогдох газраас хүмүүс оролцож, хяналт тавих


Шийдвэрлэх арга зам, түүний хувилбаруудын талаарх байр суурь

БОНБУ-ний хэрэгжилтийн талаарх өмнөх судалгаа, олон улсын түршлага, зарим шинжээчидтэй хийсэн ярилцлагад үндэслэн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах байдлыг сайжруулахад авч хэрэгжүүлж болох арга хэмжээ буюу шийдлүүдийн хувилбаруудыг судалгаанд оролцогчдод танилцуулж, дэмжих эсэх болон яагаад гэдэг шалтгааныг асуусан.

Асуулгын үр дүнг доорх графикт тоймлон харуулав. Үүнээс үзэхэд төслийн ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлага тавих, нарийвчилсан үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны шаардлагуудыг маш тодорхой болгож, түүнд ашиглах удирдамж, загвар, маягтуудыг боловсруулж хэрэглээнд нэвтрүүлэх, үнэлгээний тайланд оролцоог хангасан талаарх бүрэн хэмжээний баримт буюу тайлан, нотлох баримтуудыг хавсаргах шийдлийн хувилбарыг дийлэнхээр дэмжсэн бол бусад санал болгосон шийдлүүдийн хувьд чухал ач холбогдолтой боловч үр дүнтэй

хэрэгжих эсэх, нэмэлт хүнд суртал, шат дамжлаг үүсгэхгүй байх талаас нь сайтар судлан үзэх хэрэгтэйг дурьдсан байна.

Шийдэл тус бүрийн хувьд дэмжинэ, дэмжихгүй, мэдэхгүй гэж хариулсан уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниудын төлөөллийн саналын хувийг дараах графикт танилцуулж байна.



Шийдэл тус бүрийн хувьд дэмжихгүй гэж хариулсан уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдийн төлөөллийн саналыг дараах хүснэгтэд тоймлон авч үзэв.

Шийдлийн хувилбарууд	Дэмжихгүй байгаа шалтгаан
1. БОАЖЯ, орон нутгийн байгууллага Ерөнхий үнэлгээ хийх тухай эсвэл хийсэн талаар нийтийн зар мэдээ хүргэх, санал хүлээн авах	<p>Ерөнхий үнэлгээ гаргасан бол заавал орон нутгийн зар мэдээнд дээр гаргах гээд байдаг тэр нь бол уул уурхай хөгжсөн газруудаар бол боломжгүй тэгэхээр хүнд суртал нэмэгдэх байх гэж бодож байна.</p> <p>Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахад ЗД-аас санал авдаг. Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад шаардлагатай материал нь төлөв байдлын үнэлгээ байдаг. Төлөв байдлын үнэлгээ гэдэг нь яг одоо ямар байна гэдгийг бичсэн тайлан болохоос биш ямар нөлөөлөл гарах вэ гэсэн мэдээлэл байхгүй шүү дээ. Тэртээ тэрэнгүй энийг мэргэжлийн байгууллага үнэлэх гээд байхад нь дундуур нь иргэд орж ирээд саналаа өгье энэ тэр гээд байвал хэцүү.</p> <p>Ерөнхий үнэлгээнд иргэдээс санал авах шаардлагагүй л дээ. Яагаад ерөнхий үнэлгээн дээр орон нутгаас санал авах гээд байгааг ойлгохгүй байна л даа.</p>

	<p>Ерөнхий үнэлгээ гэдэг чинь ерөөсөө л дөнгөж эхэлж яаманд төслөө танилцуулж эхэлж байна гэсэн үг шүү дээ.</p>
<p>2. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд оролцоог хангах ажлын шаардлагуудыг тодорхой тусгах</p>	<p>Яамныхан үнэлгээний компаниудаас өөр мэдлэг ойлголттой хүмүүс байдаг. Амьдралыг мэдэхгүй учир тэс хөндлөн юм биччихдэг учир ажлыг арай удаашруулах байх.</p> <p>Иргэдийн оролцоо гэдгийг сайн ойлгохгүй байна. Ерөнхий үнэлгээнд иргэдийг оролцуулах шаардлагагүй гэж бодож байна.</p> <p>Үнэлгээний ажил удааширч, түүнийг дагаад төслийн удаашрах учир дэмжихгүй байна.</p> <p>Ерөнхий үнэлгээнд чинь угаасаа орон нутгийн иргэдээс саналыг нь авна гээд байгаа. Журманд шаардлагууд нь байгаа учраас ахиад ингэж шийдэж хийвэл давхцах л байх. Угаасаа журам нь байгаа учраас дүгнэлт дээрээ заавал тусгах шаардлагагүй байх.</p>
<p>3. Үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах</p>	<p>Нөгөө зөвшөөрнө, зөвшөөрөхгүй гэдгээсээ болоод хавсаргахаар хэн хэн дэмжсэн эсвэл хэн хэн дэмжээгүй вэ гэдэг мэдээлэл нь ил болчихоор дэмжсэн хүмүүсээ малчид нь ад үзээд ирнэ. Тэгэхээр энэ тайланд энэ мэдээллийг оруулах хэрэггүй.</p> <p>Хавсаргана гэхээр ажиллах явц улам л нэмэгдэнэ. Дээрээс нь цаг хугацаа үрсэн л юм болно гэсэн үг. Нэг юм өгчих байсан юм нь дээр ард нь заавал хавсралтаар юм бүрдүүлэх болдог. Тэд нарыгаа бүрдүүлэх гэж ажил нь сунжирна л гэсэн үг.</p>
<p>4. Төслийн ангилалаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах</p>	<p>Орон нутагт шаардлагагүй гэж бодож байна.</p> <p>Ангиллаа яаж ялгах юм. Маш олон байгаа. Ерөнхий үнэлгээ чинь ерөнхий гэдгээрээ зүгээр. Ангилал тусад дараа дараагийн ажил их уддаг.</p>
<p>5. Яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах</p>	<p>Тухайн орон нутгийн холбогдох хүмүүс ажлаа хийхгүй байхад яамнаас удирдамж гаргадаг хөрсөн дээрээ буух гээд асуудал гардаг.</p> <p>Үнэлгээг батлаад байгаа процесс чинь яаман дээр байх шаардлагагүй. Төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулж хариуцуулах хэрэгтэй.</p> <p>Авч байгаа газрууд нь бүгд маягттай байдаг. Бүх зүйл нь ойлгомжтой маягтууд байдаг. Саналын хуудас дээр бүх мэдээлэл нарийн орсон байдаг. Дахиад маягт гаргана гэж хэрэггүй байх.</p>
<p>6. БОНБУ-ний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан</p>	<p>Манай үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн хувьд энэ харьцангуй бага асуудал үүсгэдэг. Төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний компанийг үнэлгээний тайланд санал авах БИНХ-д заавал оролцуулж байх хэрэгтэй.</p>

<p>тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах</p>	<p>Сум нь хариуцсан нь дээр байх. Ерөнхий удирдлагатай.Тэгэхээр л хариу нь мөд гарахгүй хугацаа алдаад байдаг юм.</p>
<p>7. Олон нийт, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх</p>	<p>Хөдөө орон нутгийн иргэд санал өгөх боломжгүй.</p> <p>Энэ бол худлаа. Хөдөө орон нутагт энэ нь шиг худлаа юм байхгүй. Яахав бүгд л цахим боллоо гээд байгаа гар утсаар тэр чинь яг дундын нэг ФБ үүсгээд видео дуудлага хийгээд явна гэвэл худлаа. Гэхдээ яахав яваандаа байж болно л байх л даа.</p> <p>Өөрсдийн биеэр танилцуулга хийж, саналаа авах нь үр дүнтэй. Цахимаар хүмүүс бие биенээ маш их доромжилдог.</p> <p>Хөдөө орон нутагт дэд бүтэц хангалтгүй, мөн мэдээллийн үнэн бодит эсэхэд итгэхэд хэцүү байдаг.</p> <p>Малчдын оролцоо муу болно. Сум суурин газар боломжтой. Учир нь интернэтийн дэд бүтэц хөдөө орон нутагт хангалтгүй байдаг.</p>
<p>8. БОНБУ-ний талаар баг, сумаас Олон нийтийн сонгог зохион байгуулах</p>	<p>Тайлангаа тавиад мэдээлэл авч байгаа учраас нийтийн сонгог хийх шаардлагагүй. Гэхдээ томоохон төслүүд дээр байж болно. Тухайн төслийн хэмжээнээс хамаарна.</p> <p>Хуралтайгаа ялгаа байгаа юм уу. Ялгаагүй гэж бодож байна. ИНХ чинь бүх иргэдэд нээлттэй байдаг шүү дээ.</p> <p>Олон нийтийн сонгог гэхээр нэгт цаг хугацааны асуудал, хоёрт хичнээн хүнээс ямар сонгог авах нь тодорхой бус учир дэмжихгүй ээ.</p>
<p>9. Зөвхөн баг, хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /шинэ хуулиаар Зөвлөл/ үнэлгээний тайланг хэлэлцдэг байх</p>	<p>Бодоход төсөл хэрэгжүүлэгчид амар. Гэхдээ нөгөө л гомдол санал чинь тасрахгүй. Баг иргэдийн нийтийн арваад хүн чинь багийн иргэдийнхээ саналыг хэр авч орж ирснээс шалтгаалаад бид нар үнэлгээний тайландаа тусгах, тусгахгүй тухай асуудал яригдах гээд байна шүү дээ. Гэтэл цаана нь миний санал орсонгүй гэдэг хүмүүс чинь үлдчихнэ. Тэгэхээр ИНХ-тайгаа нүүр тулсан нь дээр. Багийн иргэдээсээ л саналаа аваад явж байсан нь дээр.</p> <p>Багийн ИНХ-ын дарга гэж ер нь бол 7 хүн л байдаг. Бүгд адилхан малчид л байхгүй юу. Тэгээд нөгөө хүмүүсийн хандлага нь ямар байх вэ гэдэг бас хэцүү. 7 хүний 4 нь өө наадах чинь ёстой хэцүү юм байна ойлгохгүй байна чадахгүй боль гээд зүтгэчихвэл хэцүү шүү дээ.</p> <p>Тэргүүлэгчдэд нөлөөлж шийдвэр гаргуулах боломжтой болно.</p>

Дүгнэлт

Төсөл хэрэгжүүлэгчид БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах нь төслийн үйл ажиллагааг төлөвлөх, сөрөг нөлөөллийг бууруулахад чухал, орон нутагтай хамтын ажиллагаа эхлүүлэхэд чухал үйл явц гэж үзэж байгаа боловч бодит байдал дээр оролцоог хангахад цөөнгүй бэрхшээл тулгарч байна гэж үзсэн байна. Нэгдүгээрт, үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах гол арга зам болж буй ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх ажлын зорилгын талаар ойлголцлын зөрүү байгаа нь хурлын зохион байгуулалт, талуудын оролцооны идэвх, сонирхолд сөргөөр нөлөөлж байна. Хоёрдугаарт, үнэлгээ эрхлэгчид олон нийтийн оролцоог хэрхэн хангахад чадавх султай, үнэлгээний ажлын ил тод байдал хангалтгүй байна. Гуравдугаарт, орон нутгийн удирдлагын үүрэг хариуцлагын талаар зохицуулаагүй орхигдуулснаас болж ИНХ-ын хэлэлцүүлгийн тов, ирц, үр дүнтэй холбоотой асуудлууд тулгарч байна.

Бусад салбарын төсөл хэрэгжүүлэгчид

Судалгаанд оролцогчид

Судалгаанд уул уурхайгаас бусад салбарын төсөл байгууллагын төлөөлөл болох шатахуун, нефтийн чиглэлийн 4 компани, барилгын материал үйлдвэрлэлийн 2 компани, арьс боловсруулах үйлдвэрлэлийн 1, аялал жуулчлалын 3 компани нийт 10 компани хамрагдсан. Сүүлийн 3-5 жилийн хугацаанд үнэлгээ хийлгэсэн тухайн салбартаа тэргүүлэгч, үндэсний хэмжээний томоохон компаниудыг хамруулсан.

Судалгаанд хамрагдсан компаниудын үйл ажиллагаа явуулсан жилийг авч үзвэл хамгийн багадаа 9 жил, хамгийн ихдээ 22 жил, дунджаар 16 жил үйл ажиллагаа явуулсан уул уурхайн аж ахуй нэгжүүд хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдыг авч үзвэл 6 эрэгтэй, 4 эмэгтэй байсан бол насны хувьд хамгийн залуу нь 31, хамгийн ахмад нь 62 настай бол, дундаж нас 47 байна.

Хүснэгт 4. Бусад салбарын компаниудын мэдээлэл

№	Бусад салбарын компаниудын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагаа явуулсан жил
1	Магнай Трэйд	Шатахуун	20
2	Женерал эталон ХХК	Барилгын материал	10
3	"Гурван эрдэнэ тэмүүлэл" ХХК	Арьс боловсруулах	11
4	"Онцын тасархай" camp	Аялал жуулчлал	15
5	Эрчис тал	Барилгын материал	9
6	Gobi Discovery Tour	Аялал жуулчлал	17
7	Синчи-Ойл	Шатахуун	20
8	"Гэрэлт-Эрдэм" ХХК - "Цайдам" жуулчны бааз	Аялал жуулчлал	17
9	МСМ ххк	Шатахуун, нефт	22
10	"АЙКУ" ХХК	Шатахуун, нефт	20

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангахад тулгарч буй асуудлууд

1. Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай хууль, журмын талаарх ойлголт мэдээлэл бага байна

Судалгаанд оролцогчид үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам, хуульд заасан иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх шаардлагын талаар маш бага мэдээлэлтэй байна. Зарим төсөл хэрэгжүүлэгчид иргэдээс санал авах шаардлага байдаг тухай мэдэхгүй байна. Ихэнхдээ үнэлгээ эрхлэгчийн боловсруулсан тайланг хүлээн авах, батлуулахад байлцдаг байдлаар оролцоо нь хязгаарлагдаж байна.

2. Олон нийтийн оролцоог хангах хөшүүрэг байхгүй

Үнэлгээ эрхлэгчид үнэлгээг хийх, тайлан боловсруулахдаа олон нийтийн саналыг авсан эсэх, тайландаа хэрхэн тусгасан талаар төсөл хэрэгжүүлэгч нягталж үзэх, шаардлага тавих сонирхол байдаггүй байна. Учир нь яам тайланг батлахдаа иргэдийн саналуудыг хэрхэн авсан, яаж авч үзэж,

хэрхэн тусгасан талаар анхаардаггүй зөвхөн тогтоол байгаа эсэх гэдэгт анхаардаг гэж үздэг байна. Түүнчлэн, жижиг, дунд төслүүдийн хувьд иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх нь ач холбогдолтой багатай гэдэг байр суурьтай оролцогчид байна.

Бүх зүйлсээ бичгээр явуулдгаас биш бид нар хуралд нь очиж суудаггүй. Энэ байгууллагыг манай орон нутагт үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн гэсэн иргэдийн гарын үсэгтэй хурлын протокол үнэлгээнд хавсрагдаж ордог. Яг иргэд нь бодитоор уулзаад үнэлдэг юм уу бид нар мэдэхгүй. Бодвол хэлэлцдэг л байлгүй дээ гэж л боддог.

Төсөл хэрэгжүүлэгч

Иргэдийн эрх ашгийг ноцтойгоор зөрчөөгүй тохиолдолд иргэд энд оролцох шаардлага байхгүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь судалгаа, шинжилгээний үндсэн дээр үндэслэгдэн хийгдэж байгаа учраас иргэд биш судалгааны ажилтнууд нь сайн мэднэ.

Төсөл хэрэгжүүлэгч

3. Үнэлгээ эрхлэгчдийн чадавх, хариуцлага сул байна

Үнэлгээ эрхлэгчдийн чадавх, хариуцлага сул байдаг талаар зарим оролцогчид дурьдаж тодорхой жишээ хэлсэн байна.

Нэгдүгээрт, үнэлгээ хийж буй үйл явц ил тод бус, төсөл хэрэгжүүлэгч, бусад байгууллагаас хяналт тавих боломж бага учраас үнэлгээний тайлан хэрхэн боловсруулагдсан, түүнд олон нийтийн санал хэрхэн орсон талаар мэдэх боломж байхгүй байна.

Хоёрдугаарт, үнэлгээний компаниудын чадавх, үнэлгээний ажлын төсвөөс хамаарч нарийвчилсан үнэлгээг чанаргүй гүйцэтгэх, өмнөх тайлангаас хуулбарлах, зөвхөн ерөнхий, хоёрдагч эх сурвалжаас авсан мэдээлэл ашиглах, төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцэлгүй, хэт ерөнхий, хэрэгжих боломж багатай зөвлөмж гаргах асуудал гардаг байна.

Гуравдугаарт, иргэдээс санал авах, ялангуяа ИНХ-аар хэлэлцүүлж санал авах ажлыг төсөл хэрэгжүүлэгчид хариуцуулж, төсөл хэрэгжүүлэгч нь ямар нэгэн аргаар дэмжсэн тогтоолын төсөл гаргуулах үүрэг хүлээх явдал байдаг байна. Энэ тохиолдолд нөлөөллийн талаар иргэдээс санал авах зорилго хэрэгжихэд бэрхшээлтэй болдог байна.

Бүгд л нэг төрлийн загвараа нэрийг нь өөрчлөөд ашигладаг. Энэ нь байгаль орчныг хамгаалах гэхээсээ илүү бизнес болчихсон.

Төсөл хэрэгжүүлэгч

Гэхдээ тэд нар тэгдэггүй, зүгээр л үнэлгээ хийх гэж байгаа газар нутгийнх нь ойролцоо газрын мэдээллийг хуулаад л ашиглачихдаг юм шиг санагддаг. Тэрнээс биш цаг гаргаад очоод шинжилж судлаад байдаг юм байдаггүй

Төсөл хэрэгжүүлэгч

Үнэлгээний компани “Ийм юм бүрдүүлээдэх” гэхэд нь бүрдүүлсэн, бид өөрсдөө энэ ажлаа хийсэн. Хийхдээ дүүрэг хорооны иргэдийн төлөөгчидтэй уулзаад, тохижилт үйлчилгээний ажилд нь оролцоод, иргэдээс нь саналыг нь авсан.

Төсөл хэрэгжүүлэгч

Яг үнэндээ нэлээн үнэтэй үнэлгээ хийдэг хэрнээ яг сайн үнэлж чаддаггүй гэж би боддог. Дунд нь өөр байгууллагын юмыг оруулаад зүгээр формат авчирч ирээд тавьчихдаг.. Гэхдээ ажил цааш үргэлжлэхэд зайлшгүй үнэлгээ хэрэгтэй болохоор бид нар ирснийг нь шууд ашигладаг.

Төсөл хэрэгжүүлэгч

БОНБУ-нд оролцоог хангах санал, шийдлийн хувилбарууд

4. Төслийн ангилалаас хамаарсан шаардлага тавих хэрэгтэй

Төслийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, байгаль орчинд учруулах нөлөөллийн эрсдэл зэрэг үзүүлэлтээр нөлөөллийн үнэлгээнд оруулах асуудлын хүрээг нь шаталсан байдлаар тодорхойлох нь үр дүнтэй гэж үзсэн байна. Үүнээс хамаарч тайлангийн хэмжээ, бүтэц, олон нийтээс санал авах шаардлага ялгаатай байж болно гэж үзсэн байна. Жишээ нь жижиг төслүүдийн үнэлгээний тайлан нь маш цомхон, ойлгомжтой, тодорхой байх хэрэгтэй юм.

5. Үнэлгээний ажлын чанарыг сайжруулах хэрэгтэй байна

БОНБУ нь хуульд заасан шаардлагатай баримт бичгийн бүрдэлтийг хангахад зориулсан бичиг баримт үйлдвэрлэх хэсэг бүлэг хүмүүсийн бизнес болж байна гэж зарим оролцогчид үзсэн байна. Өөрөөр хэлбэл үнэлгээний үр дүн гэхээр зүйл төслийн үйл ажиллагаанд гардаггүй, иргэд, олон нийт оролцдоггүй нь заавал хэлбэр төдий үнэлгээнд мөнгө төлөх хэрэгтэй эсэх гэдэг эргэлзээг үүсгэж байна. Тийм учраас үнэлгээний компаниудын чадавх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагыг чангаруулах, үнэлгээ хийх хугацааг аль болох хангалттай тавьж өгөх, яамнаас үнэлгээний тайлангийн агуулгад илүү гүнзгий дүн шинжилгээ хийдэг болох саналууд дэвшүүлсэн байна.

Дүгнэлт

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчидтэй харьцуулахад бусад салбарт БОНБУ-ний талаарх ойлголт, түүний практик хэрэглээний ач холбогдол бага байна. Хуульд заасны дагуу хэлбэрийн төдий байдлаар оролцоог хангах байдал нийтлэг байна. Төслийн ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлагуудыг тавих, үнэлгээ эрхлэгчдийн ажлын чанарыг сайжруулахад чиглэсэн зохицуулалт, бодлогын хөшүүргүүд хэрэгтэй байна.

Орон нутгийн удирдлагын судалгаа

Судалгаанд оролцогчид

Сум дүүргийн удирдлага: Сум, дүүргийн удирдлагыг судалгаанд хамруулахдаа сүүлийн 2-3 жилийн хугацаанд 2-оос дээш БОНБУ-г орон нутагтаа хийлгэсэн 10 төлөөллийг хамруулсан. Судалгааны баг мэдээлэл цуглуулалтын ажил эхлэхээс өмнө жагсаалтад орсон сумдын холбогдох мэдээллийг боломжит эх сурвалж (аймгийн веб сайт, цахим хуудас, лавлах утас)-уудыг ашиглан хайлт хийж олсон. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор сумын засаг дарга нар шуурхай хуралд орох, утсаа авахгүй байх хүндрэл тулгарч байсан. Судалгаанд аль болох шийдвэр гаргах түвшний төлөөллийг хамруулахыг зорьсон ба судалгаанд 8 засаг дарга, 1 засаг даргын орлогч, 1 байгаль орчны мэргэжилтэн хамрагдсан. Мөн цар тахлын улмаас сүүлийн 2 жил гаруйн хугацаанд сум/багийн ИНХ биечлэн хуралдаагүй учраас БОНБУ-ны тайланг хурлаар хэлэлцүүлсэн болон БОНБУ-г хэлэлцэх дүрэм, журмыг мартаж, мэдээлэл багатай байх тохиолдолууд байсан. Мөн улс төрийн сонгуультай холбоотойгоор шинээр томилогдсон 3 засаг дарга хамрагдсан. Судалгаанд хамрагдсан албан тушаалтнууд тухайн албан тушаалдаа хамгийн багадаа 0.3 сар, хамгийн ихдээ 8 жил, дунджаар 4 жил ажилласан байна. Судалгаанд оролцогчдыг авч үзвэл 8 эрэгтэй, 2 эмэгтэй байсан бол насны хувьд хамгийн залуу нь 25, хамгийн ахмад нь 56 настай бол, дундаж нас 40 байна.

Хүснэгт 5.. Сум, дүүргийн удирдлагын мэдээлэл

№	Хот/Аймаг	Сум/Дүүрэг	Ажилласан жил
1	Говь-Алтай	Есөнбулаг	6 сар
2	Өмнөговь	Гурвантэс	8
3	Баянхонгор	Баян-Овоо	5
4	Дорноговь	Алтанширээ	8
5	Увс	Бөхмөрөн	4
6	Хэнтий	Хэрлэн	5
7	Өмнөговь	Ханхонгор	1
8	Дундговь	Дэлгэрхангай	3 сар
9	Дорнод	Хэрлэн	5
10	Ховд	Дөргөн	6 сар

Баг, хорооны Засаг дарга, ИНХ-ын дарга: Баг, хорооны удирдлагыг судалгаанд хамруулахдаа сүүлийн 2-3 жилийн хугацаанд 2-оос дээш БОНБУ-г орон нутагтаа хийлгэсэн 20 төлөөллийг хамруулсан. Ярилцлага хийх баг/хорооны төлөөллийн холбоо барих мэдээллийг мөн адил мэдээлэл цуглуулалтын ажил эхлэхээс өмнө боломжит эх сурвалж (аймаг, сумын веб сайт, цахим хуудас, лавлах утас)-уудыг ашиглан хайлт хийж олсон. Ярилцлагад оролцох баг/дүүргийг сонгохдоо харьяа аймаг/сумын засаг дарга, ЗДТГ-ын дарга зэрэг удирдах албан тушаалтнуудаас зөвшөөрөл авч, хамгийн их уул уурхай, хүнд үйлдвэрийн төсөл хэрэгждэг, БОНБУ хийгддэг багийг сонгосон. Судалгаанд хамрагдсан албан тушаалтнууд тухайн албан тушаалдаа хамгийн багадаа 0.3 сар, хамгийн ихдээ 17 жил, дунджаар 6.7 жил ажилласан байна. Судалгаанд оролцогчдыг авч үзвэл 12 эрэгтэй, 8 эмэгтэй байсан бол насны хувьд хамгийн залуу нь 31, хамгийн ахмад нь 62 настай бол, дундаж нас 42 байна.

Баг, хорооны удирдлагын хувьд олон жил ажилласан хүмүүс нь туршлагатай, мэдээлэл сайтай байсан бол цөөн жил, сар ажилласан хүмүүс мэдээлэл муутай байсан.

Хүснэгт 6. Баг, хорооны засаг дарга, ИНХ-ын дарга

№	Хот/Аймаг	Сүм/Дүүрэг	Ажилласан жил
1	УБ	Хан-Уул дүүрэг	4
2	УБ	Налайх дүүрэг	3
3	Булган	Бүрэнхангай	5
4	Өмнөговь	Гурвантэс	2
5	Хэнтий	Дархан	5
6	Баянхонгор	Баян-Овоо	3 сар
7	Төв	Сэргэлэн	5
8	Дундговь	Баянжаргалан	4
9	Сүхбаатар	Эрдэнэцагаан	13
10	Дорноговь	Алтанширээ	17
11	УБ	СХД	4
12	Төв	Баян сүм	4
13	Өмнөговь	Ханхонгор	3
14	Дундговь	Дэлгэрхангай	16
15	Дорнод	Хэрлэн	16
16	Дорнод	Матад	5
17	Дорноговь	Даланжаргалан	2
18	Говь-Сүмбэр	Сүмбэр	5 сар
19	Өвөрхангай	Уянга	13
20	Өмнөговь	Ноён	13

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт

1. Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь иргэд мэдээлэл авах, үнэн бодитой үнэлгээ хийхэд чухал

Судалгаанд оролцсон орон нутгийн удирдлагын төлөөллийн дийлэнх нь үнэлгээнд иргэдийн санал авах үйл ажиллагаа нь иргэдэд төслийн талаар мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой гэж үзсэн байна. Өөрийн амьдарч буй нутагт ямар үйл ажиллагаа явагдаж байгаа, түүнээс ямар сөрөг нөлөөлөл учирч болох тухай мэдэх эрхээ эдлэхэд үнэлгээ ач холбогдолтой учраас иргэдэд төсөл, түүний үнэлгээний талаарх мэдээллээр маш сайн хангах хэрэгтэй гэж үзсэн байна. Улмаар төслийн байгаль орчин үзүүлэх нөлөөллийг бууруулахад хэрэгтэй иргэдийн мэдлэг, мэдээллийг хүлээн авах, үүнд аль болох сөрөг нөлөөлөл багатай хувилбар сонгох, нөхөн сэргээлтийг хэрхэн хийх талаар зөв шийдвэр гаргахад тустай гэж үзсэн байна.

Хамгийн гол нь иргэд өөрсдийн нутаг дэвсгэр дээр ямар үйл ажиллагаа явагдаж байгааг мэдэх эрхтэй. Үүний сөрөг нөлөөлөл, малчдад тусах эрсдэл нь юу вэ гэдгийг ойлгох нь чухал.

Багийн удирдлага

Мэдээж орон нутгийн уугуул иргэд чинь уул ус, амьтан, ус, байгаль орчныхоо бүх юмыг мэддэг учраас ойр мэдлэг мэдээлэлтэй хүмүүсээсээ санал авах хэрэгтэй.

Багийн удирдлага

Зарим оролцогчид үнэлгээний үе шатанд иргэдтэй уулзах, санал авах үйл явц нь уул уурхай ба орон нутгийн зөв ойлголцол, цаашдын харилцаанд маш чухал гэж үзсэн байна. Энэ үе шатанд мэдээлэл

хангалтгүй, суурь ойлголцол байхгүй, эргэж тайлагнах ажил хийдэггүйгээс болж уул уурхайн төслийн дараагийн үе шатанд орон нутгийн иргэдийн зүгээс таагүй хандлага хүчтэй болдог гэж үзсэн байна.

Зарим оролцогчид /6 хүн/ иргэдийн санал авах үйл ажиллагааг төслийг иргэд дэмжиж буй эсэх байр суурийг тодруулж байгаа хэрэг гэж дурьдсан байна.

Ер нь бол тухайн асуудлаар иргэд ямар байр суурьтайг тодотгож илэрхийлэх зорилготой гэж ойлгож байгаа. ИНХ-г хэлэлцүүлээд дийлэнх хувь нь юуг дэмжсэн гэдгийг илэрхийлэх тогтоолын баримт бичиг гарж байгаа. Тийм л үүрэгтэй гэж ойлгоод байна.

Багийн удирдлага

Тухайн уурхайг эхлүүлэх эсэх, байгаль орчинд яаж нөлөөлөх талаар нь гаргах зорилготой. Ер нь бол иргэдийг оролцуулах асуудал маш чухал.

Багийн удирдлага

Уул уурхай нь хэрэгтэй юу, үгүй юу, цаашид хэрхэн зөв зүйтэй оновчтойгоор ашиглах талаар иргэдийн санал санаачилгыг сонсох зорилготой. ИНХ-д уул уурхайн үйл ажиллагаа явагдахад тулгамдаж байгаа асуудал, малчид болон бэлчээртэй холбоотой асуудлууд хөндөгддөг.

Сууын удирдлага

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах практик

2. ИНХ-аар тайлан хэлэлцүүлэхээс өөр үйл ажиллагааны талаар мэдээлэл бага

Үнэлгээний тайланг багийн ИНХ-аар хэлэлцүүлэх нь үнэлгээ эрхлэгчдийн иргэдийн санал авах гол үйл ажиллагаа байдаг гэж ихэнх оролцогчид үзсэн байна. 30 оролцогчоос 6 нь үнэлгээ эрхлэгчид айлуудаар явж судалгаа авах, ганцаарчилж уулзах ажил хийдэг талаар дурьдсан байна.

Хуулиараа БИНХ хэлэлцүүлсэн байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Яг үнэлгээ хийгээд дууссаны дараа яаманд батлуулахын тулд багийн иргэдээр оруулж байгаа юм. Үнэлгээ хийх явцдаа олон нийтийн оролцоог яаж хангаж байгаа нь мэдэгдсэн зүйл байхгүй байна.

Багийн удирдлага

Багийн ИНХ дээр ирж иргэдээс саналыг нь аваад явдаг. Дараа нь авсан саналуудаа тусгадаг эсэхийг нь мэдэхгүй байна. Энэ саналыг ингээд тусгачихсан шүү гээд дараа нь хэлэлцүүлж байгаа зүйл байдаггүй.

Багийн удирдлага

Иргэд, орон нутгийн удирдлагын саналыг хэрхэн авч үзсэн, төслийн тайлан, менежментийн төлөвлөгөөнд тусгасан эсэх тухай эргэж мэдээлдэггүй нь оролцож саналаа хэллээ гээд үр дүн гарахгүй гэдэг сөрөг хандлагыг бий болгож байна гэж зарим оролцогчид үзсэн байна.

ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдэд танилцуулга хийж, санал авдаг эсэх талаар судалгаанд оролцогчид маш бага мэдээлэлтэй байна. Зөвхөн хоёр л оролцогч үнэлгээ эрхлэгч иргэдэд танилцуулга хийж, санал авч байсан гэж дурьдсан байна.

Нөлөөллийн бүсийн айл өрхүүдтэй уулзах, амаар болон бичгээр санал авах ажлыг компаниуд хийдэг гэдгийг зарим оролцогч дурьдсан байна.

Санал асуулгын хуудсаа тарааж өгөөд дараа нь эргэж ирж авах байдлаар ажиллаад байх шиг байдаг юм.

Суман дээр хийгдсэн үнэлгээний ажил хамгийн эхлээд хүмүүст сургалт хийж байсан. Дараа нь тараах материалаа өгч байсан. Хамгийн сүүлд багийн ИНХ-аар баталгаажуулна гээд хүмүүсийг цуглуулсан.

Газрын тосны үнэлгээн дээр эхлээд санал авсан шүү. Айлуудаар бараг 2 удаа явсан байх аа. Эхлээд хөдөөний айлуудаар хэсэгчидсэн байдлаар бид нартай хамт явж уулзсан. Үүн дээр бүх сурталчилгааныхаа материалаа тараасан. Иргэдээс бичгээр санал авч байсан. Багийн ргэдийн утасны жагсаалтыг авсан учраас тэр хүмүүсээсээ бас утсаар судалгаа авсан болов уу гэж бодож байна.

Орон нутгийн удирдлагын төлөөлөл

3. Үнэлгээний хууль, журмын талаарх ойлголт, мэдээлэл бага байна

Сум, багийн удирдлагын үнэлгээний хууль, журмын талаарх ойлголт маш бага байна. Уул уурхайн олон төсөл хэрэгжиж ирсэн газрынх эсвэл сум, багийн удирдлагад олон жил ажилласан хүмүүс бол үнэлгээний талаар зохих хэмжээнд мэдээлэлтэй байхад эсрэгээр уул уурхай, үйлдвэрийн төслүүд цөөтэй, орон нутгийн удирдлагад ажиллаад удаагүй байгаа хүмүүс үнэлгээний талаар ойлголт багатай байна.

Би хүртэл хувьдаа үнэлгээний тайланг батлана гээд тогтоол гаргаад өгөөч ээ, хурлаар оруулаад өгөөч ээ гээд ирэхэд ийм тайлан манайхаас гардаг юм байна гэж мэдэж авч байлаа.

Багийн удирдлага

Нийт 30 оролцогчоос 26 нь энэ журмын хэрэгжилтийг үнэлэх талаар тодорхой санал хэлэх боломжгүй буюу ийм журам байдаг талаар мэдэхгүй, журамтай танилцаж байгаагүй оролцогчид байна.

Манайхаас өөрсдийн авчирсан тайланг нь үндэслээд тогтоол гаргадаг. Үндэслээд ч гэж дээ бид нарт ч тодорхой нарийн мэдээлэл байхгүй ийм тайланг ямар зорилготой, яах ёстой, тайланг яаж үнэлэх ёстой, төрийн байгууллагын хүмүүст энэ талаар мэдлэг мэдээлэл байх ёстой байтал бид нарт тэр талаар мэдээлэл байхгүй.

Хорооны удирдлага

4. Үнэлгээний ажлын талаарх мэдээлэл хүртээмжгүй байна

Сум, багийн удирдлагад үнэлгээний үйл явцад олон нийт, иргэдийг оролцуулах ажлын төлөвлөгөө, хуваарьт танилцуулах байдлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах явдал байдаггүй гэж дийлэнх оролцогчид үзсэн байна.

Иргэдийн хувьд үнэлгээний талаарх мэдээлэл авах боломж нь ИНХ-ын хуралдаанд оролцох явдал байна. Үүнээс өөрөөр төсөл болон үнэлгээний талаар албан ёсны мэдээлэл авах боломж маш бага гэдгийг судалгаанд оролцогчид үзсэн байна. Нэгдүгээрт, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчид

урьдчилсан танилцуулга, мэдээлэл өгөх байдал хангалтгүй байна. Хоёрдугаарт, төсөл, үнэлгээний талаарх мэдээллийг шуурхай авах нэгдсэн мэдээллийн эх сурвалж байдаагүй.

Нөлөөллийн бүсийн иргэдэд мэдээлэл өгөх тохиолдол байдаг ч бусад иргэдийн хувьд мэдээлэлгүйгээр ИНХ-ын хэлэлцүүлэгт оролцож санал хураалтад оролцдог байна.

Байгаль орчны яамны лавлагаа үнэлгээний талаар цахим хуудсаар нь орж шалгана гэдэг хөдөөгийн иргэдэд бол тэнгэрт байгаа мэт хол зүйл. Бид хэдийн хувьд яамны сайтаар орж, хүнээс сураг тавьж асууж байгаад мэдээлэл авсан болдог.

Багийн удирдлага

Ерөнхий танилцуулгыг багийн иргэдийн хурал дээр мэдээлдэг болохоор хуралдаа ирсэн иргэд тухайн төслийн талаар мэдээлэл авчихдаг. Хуралдаа ирж суугаагүй иргэдийн хувьд дам, аман яриагаар сонсдог байх.

Сумын удирдлага

5. Үнэлгээний мэдээлэл иргэдэд ойлгомжгүй байна

Иргэд урьдчилсан мэдээлэл аваагүй эсвэл маш багатайгаар ИНХ-д оролцож үнэлгээ эрхлэгчийн 20 орчим минутын танилцуулгыг сонсоод өөрсдийн байр суурийг илэрхийлэх шаардлага үүсч байна. Танилцуулга нь иргэдэд ойлгомжтой мэргэжлийн үг хэллэгтэй, орон нутгийн иргэдийн анхаарч буй гол асуудалд төвлөрөөгүй байдаг учраас иргэд ойлгоход бэрхшээлтэй, урган гарах асуултууд нь ерөнхий, анхдагч мэдээлэл авах шинжтэй болдог байна.

Хурал дээр инфографикаар, слайдаар цацаж танилцуулдаг. Ерөнхийдөө нэлээн ойлгомжтой байдлаар явагддаг. Гэхдээ мэргэжлийн биш малчид, иргэд ойлгоход бас хэцүү. Жишээ нь талбайн дөрвөн өнцгийн GPS, координат авчихсан байдаг. Координатаа тоо хэлбэрээр нь тайлбарлаж ярихад хүмүүс ойлгохгүй. Координатаар нь биш тухайн талбайн нэг хэсэг, газрын нэршлээр нь тайлбарлаж хэлбэл хүмүүс илүү сайн ойлгоно.

Багийн удирдлага

Үнэлгээний тайлангийн хураангуйг бэлтгэж орон нутгийн удирдлага танилцуулах тохиолдолд байдаг боловч орон нутгийн удирдлага, үнэлгээ эрхлэгчдээс иргэдэд хүргэх байдал бага байна. Зарим компаниуд хурал болох өдөр танилцуулга материал бэлтгэж ирдэг байна.

Тухайн байгууллага тайлангаа иргэдэд өгөөд дараа нь БИНХ дээр ирээд танилцуулж байвал зүгээр юм болов уу гэж бодоод байгаа юм. Тэгэхгүйгээр судалгаагаа нэг удаа явж авчхаад их зузаан ном болгоод тавьчихаж байгаа юм. Би тэрийг нь танилцуулах гэхээр тухайн компанийн өмнөөс танилцуулах гээд байгаа юм шиг ойлгомжгүй байдал үүсээд байдаг юм.

Багийн удирдлага

Товч тайланг бол мэдэхгүй ямар ч байсан дэлгэрэнгүй тайланг бол үзүүлсэн тэр нь бол маш зузаан 200-300 хуудастай янз янзын л эд байдаг юм байна лээ.

Багийн удирдлага

Иргэдэд танилцуулж байгаа мэдээлэлд төслийн үр өгөөж, эерэг сайн талууд, нөлөөллийг бууруулах боломжтой тухай түлхүү ярьж үүсч болох эрсдэл, сөрөг нөлөөллүүдийн талаар сайтар танилцуулж санал авахыг эрмэлздэггүй гэж зарим оролцогчид дүгнэж байна.

6. Үнэлгээний тайлан иргэдэд хаалттай байна

Орон нутгийн удирдлага үнэлгээний тайлангийн нэг хувийн хүлээн авдаг боловч иргэд уншиж танилцах боломж маш хязгаарлагдмал байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байгааг судалгаанд оролцогчид дурьдсан байна. Үүнд:

- Үнэлгээний тайлан нь нийтэд ил тод баримт бичиг үү эсвэл нууцын зэрэглэлтэй баримт бичиг үү гэдэг ойлголт янз бүр байна.
- Үнэлгээний тайланг хаанаас үзэж танилцаж болох тухай нээлттэй мэдээлэл иргэдэд байхгүй байна.
- Орон нутгийн иргэд уншиж танилцах сонирхол бага, уншиж танилцсан ч ойлгоход бэрхшээлтэй нүсэр материал гэж үздэг учраас иргэдэд нээлттэй байлгах сонирхол бага байдаг.

7. Иргэдийн санал үр дүнд хүрдэг эсэх тодорхой бус байна

Иргэд усны чанар, хүртээмж, тоосжилт, хөрсний эвдрэл, хог хаягдал, бэлчээр, амьтан, ургамлын хамгаалал зэрэг олон асуудлаар санал хэлдэг. Түүнчлэн иргэдийн амьдрах орчинд шууд аюул учруулж буй замын хөдөлгөөний аюулгүй байдал, бэлчээрийн хуваагдал, уурхай, замын ажлын улмаас үүсэх овоолго, нүх зэрэг асуудлаар санал, гомдол хэлдэг байна.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд баг, хороодын иргэдийг ажилд авах, санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх, нөлөөллийн бүсийн айлд худаг гаргах зэрэг асуудлууд их гардаг байна.

Хэдийгээр иргэдийн саналыг тэмдэглэж авдаг, зарим талаар үйл ажиллагаанд тусгаж хэрэгжүүлэх талаар хариу өгдөг боловч үнэлгээний тайланд хэрхэн тусгадаг, улмаар менежментийн төлөвлөгөөнд оруулсан эсэх тухай хариу мэдээлдэггүй, нягталж шалгах боломж байдаггүй байна. Тийм учраас иргэдийн дунд нэгэнт үнэлгээгээ хийгээд дуусгачихаад бидэнд танилцуулж байгаа болохоор бид нарын санал чухал биш гэдэг хандлага байдаг байна.

Иргэд өөрсдийнхөө хэмжээнд, бодит нөхцөл байдлаа танилцуулдаг байх. Тухайн үнэлгээний байгууллага нь иргэдийн хэлсэн саналыг шинжлэх ухааны үндэслэлтэй болгож боловсруулах хэрэгтэй.

Сумын удирдлага

Манай багийн иргэд компаниас түр замуудаа нөхөн сэргээлтэд оруулах, засмал замаа малын гарцтай болгох ямар арга чарга байна гэж тайлан хэлэлцэхэд асууж байсан. Ерөөсөө тогтоол гаргаад өгчихвөл тэр ажлуудыг чинь хийж өгнө гэдэг. Тэгээд тогтоолоо авчихвал бүр алга болно гээд зууралдаад байж байгаа.

Багийн удирдлага

Иргэдийн хэлсэн саналуудыг нь үнэлгээний комданиуд чухам л дэвтэр дээр бичиж аваад явдаг. Эргээд яаж тусгасан талаараа тайлагнадаггүй.

Багийн удирдлага

Асуудлын шийдэл, хувилбарууд

8. Сайжруулах шаардлагатай 3 зүйл

БОНБУ-нд оролцоог хангах чиглэлээр нэн түрүүнд засаж сайжруулах асуудал юу вэ гэдэг асуултанд судалгаанд оролцогчид дараах 3 бүлэг сэдвийг хөндөж хариулт өгсөн байна. Үүнд:

- Үнэлгээний талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах: Иргэдэд аль болох эртнээс үнэлгээ хийх талаар янз бүрийн сүвгаар мэдээлэл түгээх, уулзалт, танилцуулга хийх, зар мэдээ тараах замаар иргэд үнэлгээний талаар мэдээлэл авч түүнд үндэслэсэн үр дүнтэй асуулт, санал дэвшүүлэх боломжоор хангах хэрэгтэй байна. Ялангуяа багийн удирдлагын төлөөлөл мэдээллийн хүртээмжийн асуудлыг илүү анхаарч дурьдсан байна.

Өмнө нь айлуудаар орж мэдээллээ өгөөд, санал авчихаад ИНХ дээрээ түүнийгээ нэгтгээд танилцуулаад, иргэдээс зөвшөөрөл авах хэрэгтэй.

Үнэлгээний ажлаа эхлүүлэхээс өмнө тараах материал буюу танилцуулгаа тараачихмаар юм уу гэж бодож байна. Тэгэх юм бол иргэд зав чөлөөгөөрөө түүнийг нь уншиж танилцаад арай мэдээлэлтэй болно. Үүнийгээ дагаад идэвх нь ч сайжрах болов уу.

Ерөнхийдөө хамгийн түрүүнд тухайн компаниуд нь манайх үнэлгээг ингэж хийх ёстой, танай нутаг орны газар ийм байна гэж иргэдэд танилцуулаад хэрэгжүүлэгч болон үнэлгээ хийх гэж байгаа компани нь өөрсдийн биеэр ирж уулзаад, тухайн үйл ажиллагаагаа тайлбарлаж хийдэг бол зүгээр санагддаг. Тэгэхээр хэдэн дарга нарын гарын үсгээр төсөл хэрэгжээд явчихдаг зүйлс байгаад байна.

Орон нутгийн удирдлагын төлөөлөл

- Үнэлгээний талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах: Сумын удирдлагын хувьд үнэлгээний ажлын зорилго, ач холбогдол, үе шатууд юу болох, үнэлгээний тайланг уншиж танилцаад хэрхэн үнэлэх зэрэг иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах сургалт, сурталчилгааны ажлууд хэрэгтэй байгааг дурьдсан байна.
- ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдээс санал авах: Багийн хичнээн өрхөөс урьдчилж санал авах, түүнд нөлөөллийн бүсийн хичнээн өрх байх, иргэдийн саналыг аваад нөлөөллийг бууруулах ямар шийдэл дэвшүүлж байгаагаа танилцуулах зэрэг явцын оролцоог хангах зохицуулалтыг тодорхой болгож хэрэгжүүлэх хэрэгтэй байна гэж зарим оролцогчид үзсэн байна.

9. Иргэдэд мэдээлэл түгээх олон арга замууд байна

Сум, багийн удирдлагууд иргэдэд тухайн төслийн үнэлгээний талаарх мэдээллийг үр дүнтэй хүргэх олон арга зам байгааг дурьдсан байна. Тэдгээрийг нэгтгэн үзвэл дараах гол арга замууд байна.

Үүнд:

- Хэсэгчилсэн уулзалт зохион байгуулж танилцуулга хийх
- Багийн ажлын албаар дамжуулж мэдээлэл хүргэх
- Сум, багийн цахим хуудсаар мэдээлэл хүргэх
- Мэдээллийн хураангуйг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр буюу зурагт хуудас, мэдээллийн хуудас, видео контент байдлаар бэлтгэж хүргэх
- Иргэдийн мэдээлэл авдаг гол сүвгүүдээр буюу телевиз, сонин, сошиалаар мэдээлэл хүргэх
- Цахимаар төрөл бүрийн хэлбэрийн контент бэлтгэж мэдээлэл, сурталчилгаа, зар мэдээ хүргэх

Зарим оролцогчдын дурьдсанаар орон нутгийн зарим багийн өндөр настай ахмадуудаас бусад ихэнх хүмүүс цахимаар мэдээлэл авах чадвартай болсон байна. Нөгөө талаас иргэдэд хүргэх мэдээлэл маш ойлгомжтой байх нь чухал гэж үзсэн байна. Түүний жишээ болгож Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдээс санал авах талаарх мэдээлэл, сурталчилгааг зарим оролцогчид онцолсон байна.

10. Үнэлгээг хийх явцад буюу ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдийн санал авах олон арга замууд байна

Судалгаанд оролцсон сум, багийн удирдлагууд үнэлгээний явцад иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийхдээ дараах арга замуудыг анхаарч үзэх санал дэвшүүлсэн байна. Үүнд:

- Багийн иргэдийг хуваах байдлаар буюу нэг баг дээр 2-3 эсэгчилсэн хэлэлцүүлэг хийх
- Иргэдийн хэлэлцүүлгийг уламжлалт аргаар биш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх идэвхжүүлэх аргууд ашиглах
- Иргэдийн саналыг бичгээр авах, ингэхдээ хувь хүний нүүцыг хамгаалах
- Иргэдийн санал хүсэлтийг тусгасан, тусгаагүй, тусгах боломжгүй тухайд эргэж мэдэгддэг байх буюу тайланд тусгах түүнийхээ дараа тайлангаа ИНХ-аар оруулж хэлэлцүүлэх
- Хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр үнэлгээ хийх цар хүрээ, төлөвлөгөөгөө гаргах
- Орон нутгийн иргэдтэй хамтарч үнэлгээг хийх, ингэхдээ үнэлгээний ажилд багийн иргэдээс оруулж, мэдээллээр хангах, хамтран ажиллах
- Зар мэдээг олон сувгаар хүргэх
- Хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, онцлогт тохируулж хэсэгчилсэн уулзалт хийх, ингэхдээ жишээ нь цахимаар цахим мэдээлэл авдаг залуучуудад цахимаар мэдээлэл олгох, хөдөө хол байгаа ахмад настай хүмүүст нь дунд нь хэсэгчилж багцалж танилцуулах
- Нөлөөллийн бүсийн хүрээнд айл өрхүүдээс нарийвчилж судалгаа аваад түүнийгээ тайланд дэлгэрэнгүй оруулах, түүний дараа ИНХ-аар танилцуулж санал авах
- Үнэлгээнд оролцоог хангах ажлаа маш сайн төлөвлөх, ингэхдээ орон нутгийн иргэд, малчдын амьдалын хэв маяг, улирлын ажлын ачааллыг бодолцох

11. ИНХ-ын хэлэлцүүлгийн үр дүнг сайжруулах арга замууд

Хурлаар үнэлгээний тайланг хэлэлцүүлэхэд дараах зүйлсийг анхаарч зохих өөрчлөлтийг хийх санал дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хэрэв цахимаар зохион байгуулах бол сум, багийн цахим хуудсыг ашиглах
- Иргэдэд хурлын зар мэдээг сайн хүргэхдээ бичгээр санал өгөх хуудсыг хүргүүлж хуралд ирэхдээ саналаа өгч болохуйцаар зохион байгуулах
- Үнэлгээний тайланг хэлэлцэх зар мэдээ, холбогдох бүх мэдээллийг өгсөнөөс хойш 5-7 хоногийн дараа хурлаар хэлэлцүүлдэг байхаар уялдуулах
- Хурлаар хэлэлцүүлэх тайлангийн төсөлд хичнээн хүнээс, ямар санал авсан, тэдгээрийн дагуу ямар арга хэмжээг тусгасан гэдгийг тодорхой тусгасан байх
- Хурлыг хэсэгчилж зохион байгуулах
- Багийн ИНХ-аар зөвхөн тухайн тайланг хэлэлцдэг байхаар зохион байгуулах
- Үнэлгээний тайланг хэлэлцэхэд хүмүүс цуглуулахын тулд тодорхой хэмжээнд иргэдийн сонирхол татсан арга хэрэглэх, жишээ нь урамшуулал, сугалаа,


- Үнэлгээг хийж эхлэх үеэс төлөвлөгөөгөө багт танилцуулж хэзээ хурлаар хэлэлцүүлэхээ тохирдог байх

12. Шийдвэрлэх арга зам, түүний хувилбаруудын талаарх байр суурь

БОНБУ-ний хэрэгжилтийн талаарх өмнөх судалгаа, олон улсын түршлага, зарим шинжээчидтэй хийсэн ярилцлагад үндэслэн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах байдлыг сайжруулахад авч хэрэгжүүлж болох арга хэмжээ буюу шийдлүүдийн хувилбаруудыг судалгаанд оролцогчдод танилцуулж, дэмжих эсэх болон яагаад гэдэг шалтгааныг асуусан.

Асуулгын үр дүнг доорх графикт тоймлон харуулав. Үүнээс үзэхэд иргэдээс санал авах ажлыг цахимаар хэрэгжүүлэх, ИНХ-ын Тэргүүлэгчид тайланг хэлэлцэж сана өгдөг байх шийдлийн хувилбарыг хамгийн ихээр дэмжихгүй байна. Бусад арга замуудын хувьд дийлэнх нь дэмжиж, зарим нь тодорхой байр суурь илэрхийлэх боломжгүй байна.

Шийдэл тус бүрийн хувьд дэмжинэ, дэмжихгүй, мэдэхгүй гэж хариулсан уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компаниудын төлөөллийн саналын хувийг дараах графикт танилцуулж байна.



Шийдэл тус бүрийн хувьд дэмжихгүй гэж хариулсан орон нутгийн удирдлагын төлөөллийн саналыг дараах хүснэгтэд тоймлон авч үзэв.

Шийдлийн хувилбарууд	Дэмжихгүй байгаа шалтгаан
1. БОАЖЯ, орон нутгийн байгууллага Ерөнхий үнэлгээ хийх тухай эсвэл хийсэн талаар нийтийн зар мэдээ хүргэх, санал хүлээн авах	Үнэлгээний талаар нийтэд мэдээлнэ гэж байхгүй
2. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд оролцоог хангах ажлын шаардлагуудыг тодорхой тусгах	
3. Үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах	Тэр протоколыг нийтэд ил байлгах хэрэг байхгүй. Харин шийдвэрийг ил тод байлгаж болно
4. Төслийн ангилалаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах	Адил байх хэрэгтэй байх. Уул уурхай, том жижиг аль аль нь иргэдэд тэгш хүртээмжтэй байх ёстой. Угаасаа үнэлгээ харилцан адилгүй гардаг тул дэмжинэ, дэмжихгүй гэж ярих шаардлага байхгүй. Тухайн орон нутгийнхаа байршил, онцлогоос шалтгаалаад, харилцан адилгүй үнэлгээ гарна, түүнийгээ дагаад өөр өөр асуудлууд яригдана.
5. Яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах	Яам гэхээс илүү орон нутагтаа анхан шатны байгууллага нь хяналтаа хийх нь зөв.
6. БОНБУ-ний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах	Шаардлагатай биш байх. Иргэдийн нийтийн хурлаасаа шалтгаална. Иргэдийн нийтийн хурлыг хэзээ ч хийж болно. Тэдэнд тийм ажлыг үүрэг өгөхийг дэмжихгүй.
7. Олон нийт, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх	Төв газар бол болно. Хөдөөгийн малчдын хувьд хүндрэлтэй. Хүмүүс тэр бүр цахимаар орж санал өгөхгүй байх. Саналыг бичгээр өгөх, цахимаар өгөх хоорондоо хол зөрөөтэй. Цахимаар саналаа өгчихдөг, цаашаа үр дүн болж байгаа эсэхэд нь хяналт тавих боломжгүй. Бичгээр өгчих юм бол дараа нь ядаж хурлын протоколоо харна шүү дээ.

<p>8. БОНБУ-ний талаар баг, сумаас Олон нийтийн сонсгол зохион байгуулах</p>	<p>Манайхан зарим нь сонсгол гэдэг зүйлээ сайн ойлгодоггүй. Нийтийн сонсгол гэдэг нь хүмүүс босож ирээд санал хэлэх, баг хорооны хуралтай адил зүйл болж байгаа. Манайхан сонсгол гэхээр зүгээр хурал шиг зүйл хийчихдэг. Уг нь сонсгол гэдэг нь тухайн хүн санал хэлээд гарах ёстой зүйл. Сонсгол хийтэл цаг хугацаа их шаардах байх.</p>
<p>9. Зөвхөн баг, хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /шинэ хуулиаар Зөвлөл/ үнэлгээний тайланг хэлэлцдэг байх</p>	<p>Цөөхөн хүрээ тул нөлөөлөл орно.</p> <p>Багийн иргэдээс асуух ёстой. Тэргүүлэгч чинь таван л хүн байгаа.</p> <p>Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэхээр хэцүү л дээ. Ер нь бол ИНХ-р хэлэлцсэн нь дээр тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэхээр яг 5 хүн байгаа тэр цөөхөн хэдэн хүмүүс чинь ялгаагүй хувийн эрх ашиг зөрчигдөнө.</p>

Дүгнэлт

Орон нутгийн удирдлагын хувьд үнэлгээний ажлын талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй, ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатанд иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх үүргээ үнэлгээ эрхлэгчид хэрэгжүүлдэггүй гэдэг байр суурийг илэрхийлсэн байна. Тийм учраас мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг сайжруулах, иргэдэд БОНБУ-ний талаар мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдээс авсан саналын үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжоор хангах, үнэлгээ эрхлэгчдийн орон нутагтай илүү ойр, төслийн үнэлгээний эхнээс хамтарч ажиллах саналуудыг дэвшүүлсэн байна.

Орон нутгийн иргэд

Судалгаанд оролцогчид

Сүүлийн 1-2 жилийн хугацаанд БОНБУ-г тухайн баг, хороонд хийгдсэн иргэдийн төлөөлөл болох Булган аймгийн Бүрэнхангай, Хэнтий аймгийн Дархан, Өмнөговь аймгийн Гурвантэс, Дорноговь аймгийн Алтанширээ, Говь-Алтай аймгийн Төгрөг сумын 5 иргэнийг хамруулсан. Баг/хорооны засаг дарга нартай ярилцах явцдаа ярилцлагад оролцох боломжтой иргэдийн холбогдох мэдээллийг авсан. Иргэдийн сэтгэл ханамж болон тухайн үнэлгээний ажилд идэвхтэй оролцох, оролцохгүй эсэх нь тухайн орон нутагт төсөл хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниудын хариуцлага, хандлагаас нь хамаарч байгаа нь ажиглагдсан.

Хүснэгт 7. Орон нутгийн иргэдийн мэдээлэл

№	Хот/Аймаг	Сум/Дүүрэг	Хүйс	Нас	Тухайн орон нутагт амьдарч байгаа жил
1	Булган	Бүрэнхангай сум	Эр	58	20
2	Хэнтий	Дархан сум	Эр	47	47
3	Өмнөговь	Гурвантэс	Эм	57	27
4	Дорноговь	Алтанширээ сум	Эм	75	39
5	Говь-Алтай	Төгрөг	Эм	30	30

БОНБУ-ний талаарх иргэдийн итгэл

1. Үнэлгээний тогтолцоонд итгэхгүй байна

Судалгаанд оролцогчид үнэлгээ нь эерэг, сөрөг бүхий л нөлөөллийг үнэн зөв тодорхойлж, түүний дагуу авах арга хэмжээг тусгаж байгааг гэдэгт эргэлзсэн байр суурьтай байна. Нэгдүгээрт, үнэлгээний компани нь төсөл хэрэгжүүлэгчээс хараат бусаар үнэлгээ хийж чаддаг эсэхэд эргэлзсэн байна. Төсөл хэрэгжүүлэгчийн “хөлсөлж авсан” компани байдаг учраас аль болох тайланг батлуулж, төслийг явуулах сонирхол байдаг байх гэж нэг оролцогч хариулсан байна. Хоёрдугаарт, иргэдэд танилцуулдаг мэдээлэлд төслийн эерэг талуудыг аль болох оруулж, байгаль орчны сөрөг нөлөөлөл маш бага эсвэл байхгүй мэт ойлголт төрүүлэхийг хичээдэг нь үнэлгээнд эргэлзэхэд хүргэдэг байна.

Үнэлгээний компаниуд тухайн байгаль орчны нөлөөлөл үнэлгээг нь яг бодитой үнэн зөв гаргадаг гэдэгт нь би итгэдэггүй. Ерөнхийд нь тойм зүйл гаргаад аль болох байгаль орчинд сөрөг нөлөө бага гэсэн чиглэлийг барьж гаргадаг болов уу. Гэтэл яг бодит байдал дээр өөр байдаг.

Орон нутгийн иргэн

Иргэд тухайн малын бэлчээрийн усан хангамж муудна, агаар, хөрсний бохирдол ихэснэ, хөрс сүйднэ гэсэн өөрсдийн хар ухаанаар бодож дүгнэхэд, яг тухайн үнэлгээ хийж байгаа компаниуд нь ямар ч нөлөө байхгүй гэсэн дүгнэлт гаргадаг.

Орон нутгийн иргэн

2. ИНХ-ын хэлэлцүүлгийн үр дүн хангалтгүй

ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүэхэд дараах сул талууд байдгийг дурьдсан байна. Үүнд:

- Урьдчилсан мэдээлэл өгөлгүйгээр ИНХ-аар тайлан хэлэлцүүлэх тохиолдол их байдаг. Иргэд богино хугацаанд танилцуулгыг ойлгоод асуулт, санал хэлэхэд маш хэцүү.
- Бичгээр санал авахгүй зөвхөн хурлын богино хугацаанд ярьсанаар санал авсанд тооцдог.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саналыг сонсох сонирхол байдаггүй, төлөөлж ирсэн хүний саналыг авч үздэггүй.
- Тодорхой сөрөг нөлөөллийн талаар ойлгомжтой танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлдэггүй.
- Багийн хурлаар хэлэлцэх асуудлын дундуур эсвэл төгсгөлд давчуу хугацаанд танилцуулга хийхдээ тодорхой, энгийн хүмүүст ойлгомжтой тайлбар мэдээлэл хийдэггүй.

Тэдэн метр квадрат газар ухалтын ажил хийгдэнэ гэдгээ яг мэргэжлийн хэллэгээр бичсэн байдаг. Малчид барагцаагаар энэ уулыг доош нь 35 километр ухна, хажуу тийшээ ийм гэсэн байдлаар хоорондоо ойлголцдог. Координатын талбайгаар нь ярихаар ойлгодоггүй.

Орон нутгийн иргэн

Нарийвчилсан үнэлгээг нэгдүгээрт иргэдэд ойлгомжтой сайн хийдэггүй. Хавтастай зүйл авчраад, түүнээс товчилсон тайлангаа слайд байдлаар иргэдэд үзүүлдэг. Тэгээд саналыг нь хурааж авдаг.

Орон нутгийн иргэн

3. Мэдээллийн хаалттай байдал

БОНБУ-ний мэдээлэл маш хомс байдаг талаар иргэд дурьдсан байна. Иргэдэд ойлгомжтой мэдээллийг тодорхой давтамжтай, тохирсон сувгаар хүргэх ажил орхигдсон байдаг. Тийм учраас иргэд дам сонссон мэдээлэл, өөрийн ойлголтын хүрээнд л ярьж тодорхой, үр дүнтэй санал хэлэх боломж бага байдаг байна. Үнэлгээний тайлантай хэрхэн, хаанаас танилцаж болох тухай мэдээлэл байхгүй, сум, багт тайлангийн хувь байдаггүй гэж нэг оролцогч хариулсан байна.

Цаашид анхаарах асуудлууд

4. Мэдээллийн хүртээмж

Иргэдэд мэдээллийг үнэлгээ эхлэх үед, хурал болохоос өмнө давтамжтайгаар өгөх, ингэхдээ мэдээллийг хүлээж авч, зохих хэмжээнд ойлгож, боловсруулалт хийх хугацааг бодолцох хэрэгтэй гэж үзсэн байна.

Мэдээллийг үнэн зөв иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй урт хугацаанд өгөх хэрэгтэй. Ганц удаа сонсгоод тэнд нь шууд санал авбал хэн ч ямар ч ойлгомжгүй байдалд саналаа өгнө. Мэдээллээ өгсний дараа тухайн зүйлийг нь ойлгож авахад хугацаа хэрэгтэй. Одоо бол өдөрт нь мэдээлэл өгөөд 2 цагийн хурлын хүрээнд санал авч байгаа юм.

Орон нутгийн иргэн

Сүүлийн жилүүдэд орон нутгийн иргэд өдөр тутмын мэдээллийг цахимаар авах нь ихэссэн тул үнэлгээний мэдээллийг цахимаар хүргэх нь илүү хүртээмжтэй гэж үзсэн байна.

Иргэдэд үнэлгээний тайлангийн мэдээллийг ойлгомжтой, тодорхой болгох тухайд дараах саналыг нэг оролцогч дэвшүүлсэн байна.

Төслийн хураангуй тайланд:

- 1. Төслийн нөлөөлөх талбайд яг юу ашиглах гэж байгаа, хайгуулаар юу илэрсэн, юуг илрүүлэх гэж байгаа талаар маш сайн дэлгэрэнгүй танилцуулсан байх*
- 2. Төслийн хэрэгжилт, үе шатанд хэдэн хоног ямар байдлаар ажиллах, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, сөрөг нөлөөллийг хэрхэн арилгах талаарх мэдээллийг маш сайн дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн байх*
- 3. Тухайн төсөл хэрэгжсэнээр малчид болон иргэдэд нөлөөлөх эерэг болон сөрөг байдлыг тусгаж өгөх, мэдээлдэг байх хэрэгтэй.*

Орон нутгийн иргэн

5. Хамтын оролцоо

Үнэлгээний багт багийн иргэдийн төлөөллийг оролцуулах хэрэгтэй гэсэн дараах саналыг нэг оролцогч гаргасан байна.

Үнэлгээний ажлын хэсэгт тухайн нутгийн иргэдээс нэг хүн сонгож оруулах тухай журамд тусгаж өгвөл зүгээр байх. Тухайн үнэлгээний үйл ажиллагааг хийж байх явцдаа тухайн нутгийн нэг иргэнийг /нутгийн иргэдийн төлөөлөгч, хурлын дарга/ хамт байлгаж, хамтарч ажиллавал нутгийн иргэд хүлээж авахдаа дуртай байна.

Орон нутгийн иргэн

6. ИНХ-ын хэлэлцүүлэг

ИНХ-ыг зохион байгуулахад багийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, нэмэгдүүлэх нь үр дүнтэй гэж үзсэн байна. ИНХ-ын товыг улирал бүрээр тодорхой болгож өгвөл үр дүнтэй гэж үзсэн байна. Жишээ нь үнэлгээний тайланг хүлээн авсанаас хойш нэг сарын дотор ИНХ-ыг хуралдуулах шаардлага байж болно.

Дүгнэлт

Орон нутгийн иргэд БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн итгэх итгэл сул байгааг онцолж, үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь нөлөөллийн үнэлгээний дагуу байгаа хамгаалах үр дүнтэй ажлууд хийгддэггүй, үнэлгээ нь иргэдэд ойлгомжгүй, ил тод бус, санал өгсөн ч түүнийг тайланд тусгана гэдэг итгэл, хүлээлт бага байдаг явдал юм гэж үзсэн байна. Тийм учраас мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, ил тод болгох, иргэдээс санал авахаас гадна үнэлгээний багт оролцох, хяналт тавих боломж олгох, багийн удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх санал дэвшүүлсэн байна.

Төрийн бус байгууллагууд, салбарын холбоод

Судалгаанд оролцогчид

Хүний эрх, нийтийн эрх ашгийн өмгөөлөл, Уул уурхай, Байгаль орчны асуудал, Судалгаа нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 иргэний нийгэм, ТББ-уудын төлөөллийг хамруулсан. ТББ-уудын хувьд БОНБУ-нд иргэдийн санаа бодлыг тусгах явдал хангалтгүй байгааг шүүмжилж, иргэд, орон нутгийн удирдлагыг чадавхжуулах, зөрчилтэй үнэлгээний талаар шүүхэд хандах, судалгааны ажил хийх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Судалгааны ажлын хүрээнд ИНБ, ТББ-уудын төлөөлөл болох Хүний эрх, хөгжил төв, Онон Улз голынхон хөдөлгөөн ТББ, Хил хязгааргүй алхам ТББ, Нээлттэй нийгэм форум, Монголын байгаль эхийн аврал сан ТББ гэсэн 5 байгууллагатай ярилцлага хийсэн.

Хүснэгт 8. Иргэний нийгэм, ТББ-уудын мэдээлэл

№	ТББ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагаа явуулсан жил
1	Хүний эрх хөгжил төв	Хүний эрх, нийтийн эрх ашгийн өмгөөлөл	23
2	Онон Улз голынхон хөдөлгөөн ТББ	Уул уурхай, байгаль орчин	18
3	Хил хязгааргүй алхам ТББ	Байгаль орчин, хяналт, чадавх	21
4	Нээлттэй нийгэм форум	Судалгаа, нөлөөлөл	17
5	Монголын байгаль эхийн аврал сан ТББ	Уул уурхай, байгаль орчин	12

БОНБУ-г хийх явцад салбарын өмнө нийтлэг тулгамдаж буй асуудлыг тодорхойлох үүднээс 5 оролцогч талыг хамруулсан. Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо, Уул уурхай ассоциаци, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Монголын Тогтвортой хөгжил, Нийгмийн Хариуцлагын Зөвлөл төлөөллүүд болох 5 оролцогчийг хамруулсан. БОНБУ-нд иргэдийн санаа бодлыг тусгах байдал салбаруудын хувьд хэрэгжиж байгаа тал дээр иргэдийн санаа бодлыг хангалтгүй тусгадаг мөн нөгөө талаараа иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг саналуудыг гаргасан. Судалгааны ажлын хүрээнд салбар мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл 5 байгууллагатай ярилцлага хийсэн.

Хүснэгт 9. Мэргэжлийн ба салбарын холбоодын мэдээлэл

№	Мэргэжлийн ба салбар холбоодын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагаа явуулсан жил
1	Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо	БОНБУ	22
2	Уул уурхайн ассоциаци	УУ	27
3	Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо	Үйлдвэрлэл	24
4	Монголын барилгачдын нэгдсэн холбоо	Барилга	30
5	Монголын Тогтвортой хөгжил, Нийгмийн Хариуцлагын Зөвлөл	Нийгмийн хариуцлага	6

Оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд

1. Үнэлгээнд итгэх олон нийтийн итгэл бүүрсан

Орон нутгийн иргэд, олон нийт үнэлгээний хараат бус байдалд эргэлзэх, үнэлгээ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хийгдэж буй ажил гэж ойлгох хандлага их байдгийг дурьдсан байна. Ийм учраас үнэлгээний компаниуд иргэдтэй сайн харилцаа, итгэлцэл бий болгоход бэрхшээл тулгарч, тэр хэмжээгээр иргэдийн санал авах үйл ажиллагаа утга учиртай, үр дүнтэй болдоггүй байна.

2. Олон нийтийн оролцоог хангах журам хийдэл ихтэй

БОНБУ-нд оролцоог хангах журамд практик хэрэглээнд нийцэхгүй, тодорхой бус зохицуулалтыг байдгийг дурьдсан байна. Үүнд:

- “Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна”/2,7/ гэдэг заалт нь практикт хэрэгжих боломж маш бага байдаг байна. Журамд нийцүүлэн 15 хоногийн дотор хурлаа зарлаж болох боловч хурлын ирц бүрдэх үү гэдэг асуудалтай байдгийг дурьдсан байна.
- Баг, хорооны хураар хэлэлцүүлэх зохицуулалттай боловч хэлэлцүүгийг зохион байгуулахтай холбогдсон баг, хорооны удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой тусгаагүй учраас хариуцах эзэнгүй хийдэл үүсдэг.
- Мэргэжлийн шинжээч, мэргэжлийн зөвлөл нарийвчилсан үнэлгээний тайланг хянан үзэхдээ хууль, журамд заасан явцын оролцоог хангасан эсэхийг хэрхэн үнэлэх талаар зохицуулалт байхгүй байна.
- Иргэдээс санал авахаас өмнө тэдэнд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, ямар цаг хугацаанд, хэн хариуцаж хүргэх вэ, иргэд саналаа яаж илэрхийлэх вэ гэдгийг нарийвчилж тусгаагүй маш ерөнхий зохицуулсан.
- Батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна гэж заасан боловч хаана, хэзээ, ямар хэлбэрээр гэдэг тодорхой шаардлага тавиагүй учраас тайлантай танилцахад маш бэрхшээлтэй байдаг.

Иргэд тайланг уншиж танилцах боломжгүй. Сумын байгаль орчны улсын байцаагч болон уурхайд тайлангийн 1 хувь нь байдаг. Уурхай дээр очоод тайлангаа гаргаад ир гэхэд хотод оффис дээр байгаа гэдэг.

ТББ-ын төлөөлөл

БОАЖЯ дээр байгаа тайлан нь ил тод байдал муутай. Ил тод байх ёстой гэдэг боловч бүрэн эхээрээ байна гэсэн зохицуулалтгүй учраас яамны веб сайт дээр хураангуй байдлаар л байдаг. Үүнийг аваад хяналт тавихад хангалтгүй мэдээлэл байдаг. Тайланг бүрэн эхээр нь авахын тулд яаманд албан бичиг өгдөг боловч шийдвэрлэлт нь маш удаан.

ТББ-ын төлөөлөл

1. ИНХ-ын ирцэд нөлөөлж буй хүчин зүйлс

Үнэлгээний тайланг хэлэлцүүлэх ИНХ-ын ирцийг бүрдүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч зүй бусаар нөлөөлөх буюу зарим иргэдэд шан харамж өгөх, үнэн бодит мэдээлэлгүйгээр санал өгүүлэх үйлдэл хийх тохиолдол байдгийг дурьдсан байна. Түүнчлэн ирцийг бүрдүүлсэн хуурамч баримт бүрдүүлэх, тамга тэмдгийг хуурамчаар үйлдэх зөрчил гардаг гэж мэдээлсэн байна.

ИНХ-ын ирц бүрдэхгүй байдаг шалтгааны тухайд дараах 2 үндэслэлийг дэвшүүлсэн байна. Нэгдүгээрт, хурал болохоос өмнөх буюу үнэлгээг эхлэхээс эхлээд иргэдэд мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийх хуульд заасан шаардлагыг үнэлгээ эрхлэгчид хэрэгжүүлэхгүй, улмаар мэдээлэлгүй иргэдийг хуралд оролцуулж хэлэлцүүлсэн гэдэг нэр зүүх зорилготой холбоотой үзсэн байна. Хоёрдугаарт, орон нутгийн малчдын уламжлалт амьжиргааны онцлог, цлирлын ажлын ачлаалаас хамаарч хурлын давтамж, оролцооны идэвх хэлбэлздэг учраас түүнд нийцсэн оролцоог хангах зохицуулалт байдаггүйтэй холбоотой гэж үзсэн байна.

2. ИНХ-аар хэлэлцүүлгийн үр дүн тааруу

ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлэхдээ иргэдэд урьдчилсан мэдээлэл өгөх, хурлын өдөр товч мэдээлэл тараах, тайланд иргэдийн саналыг тусгасан эсэх талаар мэдээлэл өгөх зэрэг иргэд мэдээлэлд үндэслэж тодорхой санал хэлэх боломж бүрдүүлдэггүй гэж үзсэн байна.

Үнэлгээний тайланг товч танилцуулахдаа төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхой, ойлгомжтой тайлбарлаж, тэдгээрийг бууруулах, арилгах, зайлсхийх арга замүүдыг сонгоход иргэд саналаа өгөх боломжийг бүрдүүлдэггүй гэж үзсэн байна. Ихэвчлэн ерөнхий эсвэл хэт техникийн мэдээлэл өгөх, төслийн эерэг талуудыг онцлох, ерөнхий менежментийн арга замүүдыг танилцуулдаг байна.

ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцэхдээ багийн бусад асуудлын хамтаар хэлэлцдэг учраас богино хугацаанд, асуудалд төвлөрч ярилцах боломжгүйгээр санал авдаг гэж үзсэн байна.

Үнэлгээний тайланг хэлэлцүүлэхдээ багийн ИНХ-аас тусад нь хиймээр байгаа юм. баахан өвс хадлан, өвөлжилт ярьж байгаад л хамгийн сүүлд нь төсөл хэрэгжүүлэгчдэд ганцхан цаг өгдөг. Тэр ганцхан цагийн дотор маш сайхан зүйлсийг, хурдан хугацаанд яриад л иргэдээс санал авчихдаг.

ТББ-ын төлөөлөл

3. Үнэлгээний хараат бус, үнэн зөв байдалд хяналт тавих боломж бага

Судалгаанд оролцогчийн дурьдсанаар нийтийн эрх ашгийн өмгөөллийн чиглэлээр ажилладаг ТББ-ууд БОАЖЯ-ын Мэргэжлийн зөвлөлийг үнэлгээний дүгнэлт гаргахдаа олон нийтийн оролцоог хангах хуулийн шаардлагыг харгалзаж үзээгүй гэдэг үндэслэлээр Захиргааны хэргийн шүүхэд өгч шийдвэрийг цуцлуулж чадсан тохиолдол гарсан байна. Цаашдаа олон нийтийн оролцооны хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар хяналт тавьж, шүүхээр шийдүүлэх боломж байгааг дурьдсан байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн захиалгаар хийж буй үнэлгээний үйл явц, үнэн бодит байдалд хөндлөнгийн хяналт тавих боломж бага байна. Түүнчлэн, Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөлөл эсвэл олон нийтийн оролцооны асуудлаар мэргэшсэн шинжээч байдаггүй учраас иргэдийн саналыг хэрхэн авсан талаар хяналт тавихад бэрхшээлтэй байна гэж үзсэн байна.

Иргэд ямар санал гаргасан, яагаа татгалзсан, яагаад дэмжсэнийг БОАЖЯ-аас хянаж үздэггүй, улмаар журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг хүн байхгүй.

Оролцоог сайжруулах арга замууд

4. Хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах хэрэгтэй

БОНБУ-ний хуульд заасан үнэлгээг хийх явцад иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх шаардлагыг хэрэгжүүлэхэд үнэлгээ эрхлэгчид болон бусад оролцогч талууд анхаарах хэрэгтэй гэж үзсэн байна. Улмаар хуульд заасан явцын оролцоог хангахад чиглэсэн журмын зохицуулалтуудыг сайжруулж, амьдралд нийцтэй болгох хэрэгтэй гэж үзсэн байна.

БОНБУ-ний тухай хуулийн 18.4 болон 18.5-р заалтыг хуулийн дагуу хэрэгжүүлбэл бол 8.4.8 буюу багийн ИНХ-ыг зохион байгуулах, иргэдийн ирцийг бүрдүүлэхэд бэрхшээлгүй болно. Харин юу ч мэдэхгүй байгаа иргэдийг цуглуулаад хүчээр танилцуулаад, хүчээр батлуулаад байгаа учраас хүмүүс энэ хуралд идэвхтэй оролцохгүй байгаа юм. Үүн дээр ямар ч шийдэл хэрэггүй. Зүгээр л хуулиа хэрэгжүүлэх хэрэгтэй.

ТББ-ын төлөөлөл

5. Журмын зохицуулалтыг нарийвчилж, амьдралд нийцсэн, хэрэгжилтэд хяналт тавьж болохуйц болгох хэрэгтэй

Журмын тодорхой хэсэг, тухайлбал иргэдээс санал авахаас өмнө тэдэнд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, ямар цаг хугацаанд, хэн хүргэх вэ тухай, санал авах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэлбэр, иргэд саналаа чөлөөтэй хэлэх боломжийн баталгаа зэргийг амьдралд нийцсэн, маш тодорхой болгох хэрэгтэй гэж үзсэн байна. Түүнчлэн, ирсэн саналуудыг яаж тусгах, харгалзаж үзсэн бол яах, үзээгүй бол яах вэ гэдэг зохицуулалт нь байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нэг хүний саналыг тусгах эсэх асуудлаас гадна нийтээрээ санал нэгдсэн ерөнхий саналыг эцсийн шийвэр гаргахад яаж хаггалзаж үзэх вэ гэдэг одоогийн тодорхойгүй байдлыг арилгах хэрэгтэй гэж үзсэн байна.

6. Баг, хорооны ИНХ-ын үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэгтэй холбоотой үүрэг хариуцлагыг тодорхой богох хэрэгтэй

Хуулиар баг, хорооны ИНХ-д тайланг хэлэлцэх, санал авах эрхийг өгсөн боловч хурлыг зохион байгуулах, үр дүнг тайагнах үүрэг, хариуцлагын талыг орхигдуулсан. Тиймээс баг, хорооны үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулах хэрэгтэй гэж үзсэн байна.

7. БОНБУ-ний талаарх сургалт, сурталчилгаа явуулах хэрэгтэй

Орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлагад БОНБУ-ний талаарх суурь ойлголт өгөх, өөрсдийн оролцоо, эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх арга замуудын талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгцээ их байгааг оролцогчид дурьдсан байна.

8. Үнэлгээний тайлангийн талаарх мэдээллийг ил тод болгох хэрэгтэй

Үнэлгээний тайлангийн ил тод байдал, иргэд танилцах хэвлэмэл болон цахим хэлбэрээр чөлөөтэй танилцах боломжийн талаар хууль, журамд маш тодорхой тусгаж өгөх санал дэвшүүлсэн байна. Энэ талаарх дараах тодорхой саналуудын дэвшүүлсэн байна. Үүнд:

ЗДТГ-ын байран дээрээ ямар нэг албан тушаалтны зөвшөөрөлгүй, шалгуургүйгээр очиж үзэж болдог байх хэрэгтэй. Бүр нарийн үзэх гэж байгаа хүн үнэлгээний тайланг бүрэн эхээр нь, ерөнхий мэдээлэл авах гэж байгаа хүн хураангуй танилцуулга

байдаар нь орон нутгаасаа үзэх боломжтой байх хэрэгтэй. Мөн хэвэлмэл байдлаар байхаасаа гадна тухайн орон нутгийн иргэдийн хамгийн их үздэг цахим хуудас, телевизийн сувгаар байршуулах хэрэгтэй байх.

ТББ-ын төлөөлөл

Ерөнхий үнэлгээг маш боловсронгуй хийж нийтэд зарласны дараа нарийвчилсан үнэлгээг ямар процессын дагуу, хэрхэн хийх, хэдэн удаагийн уулзалт хийгдэх, үүнийг хэн зохион байгуулах гэх мэт маш нарийн зохицуулалт хийх хэрэгтэй

ТББ-ын төлөөлөл

9. ТББ-ын хяналтыг сайжруулах хэрэгтэй

Холбогдох чиглэлийн ТББ-уудын оролцоо, хяналтыг бий болгох хэрэгтэй байна. Үүнд БОАЖЯ-ны Мргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ТББ-уудын төлөөллийг оруулах, иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийхэд ТББ, бусал холбогдох байгууллагуудыг оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх, суртгалт, сурталилгаа хийхэд хамтран ажиллах арга замууд байна гэж дурьдсан байна.

10. Үнэлгээ эрхлэгч компаниудын чадавхийг сайжруулах

Үнэлгээний компаниудын чадавхийг сайжруулах, улмаар олон нийтийн эерэг ойлголтыг бий болгох хэрэгтэй. Үүний тулд үнэлгээний компанид тавигдах шаардлагуудыг өндөрсгөх, үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг сайжруулах, тодорхой чиглэл, салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангах зохицуулалтыг хийж болох санал дэвшүүлсэн байна.

11. Төслийн мөчлөгийн бусад үе шатуудын хариуцлагыг сайжруулах

Уул уурхайн төслийн үнэлгээнд хайгуулын шатанд иргэдэд мэдээлэл танилцуулга хийж, санал авах зохицуулалт оруулах замаар БОНБУ хийх үед тулгардаг үл ойлголцолоос сэргийлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

12. Төслийн ангилалын дагуу оролцооны ялгаатай шаардлага тавих

Жижиг төслүүдийн хувьд заавал ИНХ аар хэлэлцүүлэх шаардлага тавилгүй санал авах, хэлэлцүүлэг хийх уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж салбарын холбоод үзсэн байна.

13. Үнэлгээний санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах

Үнэлгээний ажлын зардалд олон нийтийн оролцоог хангахтай холбоотой зардлыг тусгах, үүний тулд үнэлгээний ажлыг хэт хямд үнээр, чанаргүй хийхээс сэргийлсэн жишиг тариф тогтоох, зардлын санхүүжилтийн хяналт, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлж болно гэж үзсэн байна.

Дүгнэлт

БОНБУ-ний чиглэлээр тодорхой ажлууд хийж байсан ТББ-уудын хувьд оролцоог хангахтай холбоотой тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга замуудын талаар тодорхой дүгнэлт, саналуудаа хуваалцсан. Хуульд заасан үнэлгээг хийх явцад буюу ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатанд иргэдэд мэдээлэл өгөх, санал авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүйгээс иргэдийн итгэл сулрах, ИНХ-ын ирц бүрдэхгүй байх, мэдээлэлгүйгээр хуралд оролцож нөлөөлөлд автах үр дагавар үүсч буйг онцолсон байна. Хууль, журмын зохицуулалтыг хэн, хэзээ, хэрхэн гэдэг байдлаар

нарийвчилсан, амьдрал нийцэлтэй, хариуцлага тооцох боломжтой байдлаар сайжруулах шаардлагатай байна гэж үзсэн байна.

Салбарын холбоодын хувьд төслийн ангиллаас хамаарсан оролцооны шаардлагыг тавих, үнэлгээ эрхлэгч компаниудын чадавхийг сайжруулах, үнэлгээний ажлын төсөв, санхүүжилтийг зохистой болгох талаар анхаарах санал дэвшүүлсэн байна.

Оролцогч талуудын саналын тойм

Оролцогч талуудын дэвшүүлсэн саналуудыг тодорхой эрэмбэ дараалалгүйгээр бүлэг сэдвүүдээр ангилан танилцуулж байна.

Саналуудын ангилал	Судалгаанд оролцогчдын санал
Төслийн ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлага тавих	<ul style="list-style-type: none"> Төслүүдийн төрөл, нөлөөлөл, ангилал, хамрах хүрээнээс хамаараад иргэдийн оролцоог хангах асуудлыг ялгаатай тусгаж өгөх Уул уурхай болон хүнд үйлдвэрлэлийн төсөл дээр зайлшгүй ИНХ-аа хэлэлцүүлээд жижиг төслүүд дээр ИНХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх, иргэдийн саналыг авсан тайлангаа олон нийтэд ил тод мэдээлэх, тайланд хавсаргах, мэргэжлийн зөвлөлөөр сайн хэлэлцээд зөвлөмж өгөх Орон нутгийн Байгаль орчны газарт үнэлгээний ангилалд үндэслэн БОННУ-ний тайланд дүгнэлт гаргах эрх мэдлийг шилжүүлэх замаар яамны ачааллыг бууруулж, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх Жижиг төслүүдийн үнэлгээний тайлан нь маш цомхон, ойлгомжтой, тодорхой байх
Төлөв байдлын үнэлгээг хийх үед буюу ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахаас өмнө санал авах	<ul style="list-style-type: none"> Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах шатанд буюу байгаль орчны үнэлгээний суурь төлөв байдлын үнэлгээ хийх үед иргэдэд мэдээлэл өгч, санал авах Төлөв байдлын үнэлгээний үе шатанд багахан хэмжээний танилцуулга хурал зохион байгуулж, ийм байгууллага, энэ газар ийм үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулах гэж байна гэсэн мэдээлэл өгөөд тухайн үйл ажиллагааг сонирхож байгаа иргэд санал хүсэлтээ хүргүүлж болдог байх Суурь судалгааны шатанд иргэдэд мэдээлэл өгч саналыг авах, үнэлгээ боловсруулах явцад нэмэлт саналыг авах, мөн ИНХ-аар хэлэлцүүлж санал авах гэх мэт шат дараатай хэд хэдэн удаа мэдээлэл өгч, саналыг нь авдаг байх Багийн хичнээн өрхөөс урьдчилж санал авах, түүнд нөлөөллийн бүсийн хичнээн өрх байх, иргэдийн саналыг аваад нөлөөллийг бууруулах ямар шийдэл дэвшүүлж байгаагаа танилцуулах
Нарийвчилсан үнэлгээ хийж эхлэх болон явцад иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх шаардлагыг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> Хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр үнэлгээ хийх цар хүрээ, төлөвлөгөөгөө гаргах Үнэлгээнд оролцоог хангах ажлаа маш сайн төлөвлөх, ингэхдээ орон нутгийн иргэд, малчдын амьдалын хэв маяг, улирлын ажлын ачааллыг бодолцох Ерөнхий үнэлгээний дүгнэлт гараад нарийвчилсан үнэлгээг боловсруулж байх явцад иргэдийн саналыг аваад тайландаа тусгаад, хэрхэн тусгаснаа дараа нь хурал дээр танилцуулдаг байх

	<ul style="list-style-type: none"> • БОНБУ-ний хуульд заасан үнэлгээг хийх явцад иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх шаардлагыг хэрэгжүүлэх • Журмын тодорхой хэсэг, тухайлбал иргэдээс санал авахаас өмнө тэдэнд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, ямар цаг хугацаанд, хэн хүргэх вэ тухай, санал авах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэлбэр, иргэд саналаа чөлөөтэй хэлэх боломжийн баталгаа зэргийг амьдралд нийцсэн, маш тодорхой болгох • Ирсэн саналуудыг яаж тусгах, харгалзаж үзсэн бол яах, үзээгүй бол яах вэ гэдэг зохи Нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдийн судалгааг гаргаж нарийвчилсан үнэлгээний явцад тэдний дунд санал асуулга, хэлэлцүүлэг, ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, тайланг хавсаргадаг болох хэрэгтэй.цуулалт нь байх • Багийн иргэдийг хуваах байдлаар буюу нэг баг дээр 2-3 хэсэгчилсэн хэлэлцүүлэг хийх • Орон нутгийн иргэдтэй хамтарч үнэлгээг хийх, ингэхдээ үнэлгээний ажилд багийн иргэдээс оруулж, мэдээллээр хангах, хамтран ажиллах
<p>Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах</p>	<ul style="list-style-type: none"> • Зар мэдээг олон сувгаар хүргэх • Үнэлгээтэй холбоотой мэдээллийг цогц байдлаар нэг эх үүсвэрээс хялбар байдлаар иргэдэд түгээдэг байх • Орон нутгийн удирдлага төслийн эхний шатнаас иргэдэд мэдээлэл хүргэдэг байх, ингэхдээ зарлалын самбар, Фэйсбүүк, бусад сувгаар мэдээллийг хүргэж байх • БОАЖЯ-аас холбогдох төрийн байгууллагаас иргэдэд орон нутагт нь хийгдэж байгаа үнэлгээний талаар мэдээлэл өгдөг байх, үүнд байгаль орчны мэдээллийн санг үр дүнтэй, шуурхай ашигладаг хэлбэрт шилжүүлж сурталчилах • Багийн удирдлагын мэдээллийн хүртээмжийн хангах чиг үүргийг тодорхой болгох • Хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, онцлогт тохируулж хэсэгчилсэн уулзалт хийх, ингэхдээ жишээ нь цахимаар цахим мэдээлэл авдаг залуучуудад цахимаар мэдээлэл олгох, хөдөө хол байгаа ахмад настай хүмүүст нь дунд нь хэсэгчилж багцалж танилцуулах • Мэдээллийн хураангуйг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр буюу зурагт хуудас, мэдээллийн хуудас, видео контент байдлаар бэлтгэж хүргэх • Иргэдийн мэдээлэл авдаг гол сувгуудаар буюу телевиз, сонин, сошиалаар мэдээлэл хүргэх • Цахимаар төрөл бүрийн хэлбэрийн контент бэлтгэж мэдээлэл, сурталчилгаа, зар мэдээ хүргэх
<p>ИНХ-ын тов, ирцтэй холбоотой үүсдэг чирэгдэлийг арилгах</p>	<ul style="list-style-type: none"> • ИНХ, ИТХ-ын товыг улирал тус бүрээр тодорхой тогтоож өгөх • Баг, хорооны үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулах • ИНХ-ын ээлжит бус, нэмэлт, хэсэгчилсэн хуралдаан хийх • Хурлын тов, зохион байгуулалт, ирц бүрдүүлэлтийг нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хуульд оруулж өгөх, үүнд хурлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлагын механизм байх ёстойг тусгах

	<ul style="list-style-type: none"> • Бүх үйл ажиллагааг цахим болгох, тухайн аймаг, сум, багийн удирдлага, ажилтнууд хурлын мэдээллээ цахимаар цаг тухай бүрд нь мэдээлдэг, хурлын цагаа мэдэгддэг харилцаа холбоотой байх • БОНБУ-ний тухай хуулийн 18.4 болон 18.5-р заалтыг бүрэн хэрэгжүүлэх замаар 8.4.8 буюу багийн ИНХ-ыг зохион байгуулах, иргэдийн ирцийг бүрдүүлэхэд бэрхшээлийг арилгах
<p>ИНХ-ын хэлэлцүүлгийн оролцоо, үр дүнг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн хэлэлцүүлгийг уламжлалт аргаар биш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх идэвхжүүлэх аргууд ашиглах • Иргэдийн саналыг бичгээр авах, ингэхдээ хувь хүний нууцыг хамгаалах • Иргэдийн санал хүсэлтийг тусгасан, тусгаагүй, тусгах боломжгүй тухайд эргэж мэдэгддэг байх буюу тайланд тусгах түүнийхээ дараа тайлангаа ИНХ-аар оруулж хэлэлцүүлэх • Нөлөөллийн бүсийн хүрээнд айл өрхүүдээс нарийвчилж судалгаа аваад түүнийгээ тайланд дэлгэрэнгүй оруулах, түүний дараа ИНХ-аар танилцуулж санал авах • Үнэлгээг хийж эхлэх үеэс төлөвлөгөөгөө багт танилцуулж хэзээ хурлаар хэлэлцүүлэхээ тохирдог байх • Ээлжит бус хурал зохион байгуулж үнэлгээг дангаар нь хэлэлцэх • Хурал болохоос өмнө иргэдэд зориулсан танилцуулга зохион байгуулах • Үнэлгээний тайлангийн хураангуй, танилцуулгыг иргэдэд маш ойлгомжтой болгож боловсруулах • БОАЖЯ, аймгийн Байгаль орчны газраас холбогдох мэргэжилтэн оролцох, хяналт тавих • Иргэдэд хурлын зар мэдээг сайн хүргэхдээ бичгээр санал өгөх хуудсыг хүргүүлж хуралд ирэхдээ саналаа өгч болохуйцаар зохион байгуулах • Үнэлгээний тайланг хэлэлцэх зар мэдээ, холбогдох бүх мэдээллийг өгсөнөөс хойш 5-7 хоногийн дараа хурлаар хэлэлцүүлдэг байхаар үялдүүлэх • Хурлаар хэлэлцүүлэх тайлангийн төсөлд хичнээн хүнээс, ямар санал авсан, тэдгээрийн дагуу ямар арга хэмжээг тусгасан гэдгийг тодорхой тусгасан байх • Хурлыг хэсэгчилж зохион байгуулах • Үнэлгээний тайланг хэлэлцэхэд хүмүүс цуглуулахын тулд тодорхой хэмжээнд иргэдийн сонирхол татсан арга хэрэглэх, жишээ нь урамшуулал, сугалаа
<p>Оролцооны талаарх талуудын ойлголтын зөрүүг арилгах</p>	<ul style="list-style-type: none"> • Багийн ИНХ-аас гарсан шийдвэрийг яам талаасаа авч үзэхдээ дэмжих/дэмжихгүй гэсэн саналыг нь голчлох биш иргэдээс ирсэн саналуудыг нарийвчилсан үнэлгээн дээр хэрхэн тусгасан байна вэ гэдгийг нь харгалзаж үзэх • БОНБУ-ний зорилго, түүнд иргэдийн оролцоо ямар үүрэгтэй талаар талууд нэгдмэл ойлголттой болох, үүнд үнэлгээний компаниудыг төсөл хэрэгжүүлэгчийн талд үйлчилж, зөвшөөрлийг авч өгдөг гэсэн ташаа ойлголтыг өөрчлөх • Иргэдэд БОНБУ хийхийн ач холбогдол, түүнд санал авах явц ямар үүрэгтэй болохыг сайтар сурталчлан таниулах

<p>Үнэлгээний талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлагад БОНБУ-ний талаарх суурь ойлголт өгөх, өөрсдийн оролцоо, эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх арга замуудын талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх
<p>Үнэлгээний тайлангийн ил тод байдал, иргэдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний тайлангийн ил тод байдал, иргэд танилцах хэвлэмэл болон цахим хэлбэрээр чөлөөтэй танилцах боломжийн талаар хууль, журамд маш тодорхой тусгаж өгөх • ЗДТГ-ын байран дээрээ ямар нэг албан тушаалтны зөвшөөрөлгүй, шалгуургүйгээр очиж үзэж болдог байх • Үнэлгээний тайланг бүрэн эхээр нь, ерөнхий мэдээлэл авах гэж байгаа хүн хураангуй танилцуулга байдаар нь орон нутгаасаа үзэх боломжтой байх • Хэвэлмэл байдлаар байхаасаа гадна тухайн орон нутгийн иргэдийн хамгийн их үздэг цахим хуудас, телевизийн сувгаар байршуулах
<p>Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • БОННУ-ний дагуу боловсруулсан менежментийн төлөвлөөний хэрэгжилтийг хангах хариуцлага, хяналтын механзмыг сайжруулах • Жил бүрийн менежментийн төлөвлөгөө батлах, шалгах эрх бүхий субъектүүд нь тухайн төсөл иргэдийн оролцоог хангасан эсэхийг шалгаж, хангаагүй бол асуудал тавьдаг байх
<p>Үнэлгээний санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний ажлын зардалд олон нийтийн оролцоог хангахтай холбоотой зардлыг тусгах, үүний тулд үнэлгээний ажлыг хэт хямд үнээр, чанаргүй хийхээс сэргийлсэн жишиг тариф тогтоох, зардлын санхүүжилтийн хяналт, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
<p>Үнэлгээний ажлын чанарыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний компаниудын чадавх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагыг чангаруулах, үнэлгээ хийх хугацааг аль болох хангалттай тавьж өгөх, яамнаас үнэлгээний тайлангийн агуулгад илүү гүнзгий дүн шинжилгээ хийдэг болох • Үнэлгээний компаниудын чадавхийг сайжруулах, улмаар олон нийтийн эерэг ойлголтыг бий болгох хэрэгтэй. Үүний тулд үнэлгээний компанид тавигдах шаардлагуудыг өндөрсгөх, үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг сайжруулах, тодорхой чиглэл, салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангах • Холбогдох чиглэлийн ТББ-уудын оролцоо, хяналтыг бий болгох хэрэгтэй байна. Үүнд БОАЖЯ-ны Мргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ТББ-уудын төлөөллийг оруулах, иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийхэд ТББ, бусал холбогдох байгууллагуудыг оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх, суртгалт, сурталилгаа хийхэд хамтран ажиллах
<p>Төслийн мөчлөгийн бусад үе шатуудын хариуцлагыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн төслийн үнэлгээнд хайгуулын шатанд иргэдэд мэдээлэл танилцуулга хийж, санал авах зохицуулалт оруулах замаар БОНБУ хийх үед тулгардаг үл ойлголцолоос сэргийлэх
<p>ИНХ-аар хэлэлцүүлдэг одоогийн шаардлагыг өөрчлөх</p>	<ul style="list-style-type: none"> • Сумын ИТХ, багийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх • Иргэдийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, түүний тайлангаа багийн удирдлагад танилцуулах

	<ul style="list-style-type: none"> • Багийн иргэд, ялангуяа нөлөөллийн бүсийн иргэдийн санал асуулга судалгаа хийх • Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, түүнд яам, холбогдох газраас хүмүүс оролцож, хяналт тавих
--	--

Эцэст нь судалгааны асуулгад санал болгосон 9 шийдлийн талаарх үнэлгээ эрхлэгчид /30 оролцогч/, уул уурхайн компаниуд /30 оролцогч/, орон нутгийн удирдлагын /30 оролцогч/ байр суурийг харьцуулсныг танилцуулж байна. Үүнээс үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах /Санал 3/, төслийн ангилалаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах /Санал 4/, яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах /Санал 5/, үнэлгээний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах /Санал 6/ саналын талаар оролцогч талуудын байр суурь харьцангуй эерэг, бусад саналуудын хувьд эерэг, сөрөг үр дагавар, бусад хууль, бодит амьдралд нийцэлтэй эсэхийг сайтар нягтлах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Саналууд	Үнэлгээ эрхлэгчид			Төсөл хэрэгжүүлэгчид			Орон нутгийн удирдлага		
	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй
1	17	13	0	17	11	1	29	1	0
2	18	11	1	21	6	2	25	0	5
3	21	9		25	3	1	28	1	1
4	29	1		21	7	1	24	2	4
5	19	9	2	23	6	0	24	3	3
6	23	6	1	16	13	0	25	2	3
7	21	8	1	19	9	1	16	14	0
8	20	7	3	12	16	1	24	1	5
9	18	9	3	12	16	1	12	18	0

1. БОАЖЯ, орон нутгийн байгууллага Ерөнхий үнэлгээ хийх тухай эсвэл хийсэн талаар нийтийн зар мэдээ хүргэх, санал хүлээн авах
2. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд оролцоог хангах ажлын шаардлагуудыг тодорхой тусгах
3. Үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах
4. Төслийн ангилалаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах
5. Яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах
6. БОНБУ-ний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах
7. Олон нийт, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх
8. БОНБУ-ний талаар баг, сумаас Олон нийтийн сонсгол зохион байгуулах
9. Зөвхөн баг, хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /шинэ хуулиаар Зөвлөл/ үнэлгээний тайланг хэлэлцдэг байх

Australia Mongolia Extractives Program
2A Temple View Residence
Suhbaatar District-1
Ulaanbaatar
Mongolia
T: +976 7000 8595

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

www.amep.mn

[/AMEP2](#)

[AusMonXtractives](#)

